

**ЭРХ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОНОЛ,
АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ**

ШИХИХУТУГ

2/2001

**ХУУЛЬ БҮТЭЭХ ШИНЖЛЭХ УХААН
АСУУДАЛД**



**ШИНЖЛЭХ
ЭРХ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОНОЛ,
АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ**

Гурав дахь жилдээ
2/2001

ХУУЛЬ БҮТЭЭХ ШИНЖЛЭХ УХААНЫ АСУУДАЛД

АГУУЛГА

1. Цэндийн Мөнх-Оргил
Хууль тогтоомжийн тосол боловсруулах ажиллагаанд тулгарч байгаа оноогийн асуудлуул
2. Дашдондовын БАЯРСАЙХАН
Хууль бүтээх үйл ажиллагаа
3. Даваанямын ОЮУМАА
Хууль бүтээх үйл ажиллагааны оноогийн байдал, боловсронгуй болгох зарим асуудал
4. Рольф Киннер-Владимир НАЗАРЯН
Хууль бүтээх үйл ажиллагааны техникийн зөгийн дүрмүүд
5. Осорын АМАРХҮҮ
Хуулийн тосол боловсруулах нь их адармаатай, чимхлүүр ажил
6. Дитрих НИЛЛЕ
Эх газрын эрх зүйн бүлгийн иргэний эрх зүйн системийн товч түүх
7. Дамбадаржаагийн ОЮУНЦЭЦЭГ
Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн харилцааны эрх зүйн зохицуулалт -
8. Ганболдын АМАРЖАРГАЛАН
Дампуурлын эрх зүйн харилцааг боловсронгуй болгох зарим асуудалд
9. Дагдангийн ОТГОНТУЯА
Соён гэгээрүүлэгчдийн улс төр, эрх зүйн философи сэтгэлгээний хөгжлөөс Ш.Л.Монтескье
10. Афоризм
11. Монгол Улсын хууль тогтоомжийг 2004 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл

Эрхлэн гаргасан
"ШИХИХУТУГ"
ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛЬ

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИ

Ерөнхий редактор

Данзангийн ЛҮНДЭЭЖАНЦАН

Редакцийн гишүүд

Галдангийн СОВД
Жигжидийн Болдбаатар
Чинсидийн ЭНХБААТАР
Жамсрангийн БЯМБАДОРЖ
Жаргалантын ЭЛБЭГСАЙХАН
Бирваагийн МАНДАХБИЛЭГ
Түдэврэнчингийн БАЯРМАА

Нарийн бичгийн дарга

Чинсэл-Очярын БАЯРТУУЛ

Хаяг:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Соёлийн гудамж,
"Шихихутуг" ХЗДС-ийн байр.
Утас: 323392, 320176
Факс: 976-11-323392

Жилд 4 дугаар хэвлэгдэн гарна.
Улсын бүртгэлийн дугаар 173



"Монхийн үсэг"
хэвлэх үйлдвэрт хэвлэн.

ӨМНӨТГӨЛ

Монгол оронд хэрэгжиж буй өөрчлөлт шинэчлэлийн нэг хэсэг нь эрх зүйн шинэтгэл хийх явдал мөн. Эрх зүйт төрийг төлөвшүүлэх, зах зээлийн эдийн засгийн эрх зүйн орчмыг бүрдүүлэх нь Монгол Улсын хууль тогтоох байгууллага Улсын Их Хурлын гол үйл ажиллагаа юм.

Иймд 1998 онд УИХ-аас баталсан эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн дагуу хууль, тогтоомжийг боловсронгуй болгох үйл ажиллагаа тодорхой төлөвлөгөөтэй үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Монгол Улсын хууль тогтоомжийг 2004 он хүртэл боловсронгуй болгох чиглэлийг 2001 онд УИХ батласан юм. Энэхүү үндсэн чиглэлд тодорхойлсноор 140 орчим хууль батлах бөгөөд шинээр боловсруулах хууль 31, одоо үйлчилж байгаа 65 хуульд нэмэлт өөрчлөлт оруулна.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажиллагаанд тулгамдсан асуудлууд, хууль бүтээх ажиллагааны арга технологийг шинжлэх ухааны үүднээс нарийн тодорхойлох асуудал нь хууль тогтоочид, хуулийн төсөл боловсруулах ажиллагаанд оролцдог төр, засгийн байгууллагын ажилтнууд, эрдэмтэд, судлаачдын маш чухал зорилт, хэрэгцээ, шаардлага болон тавигдаж байна. Тэрхүү чухал зорилт, хэрэгцээ, шаардлагыг хангахад тус дэм болох зорилгоор хууль бүтээх арга, технологийн асуудлуудад голчлон анхаарсан өгүүлүүдийг "Шихихутуг" эрх зүйн шинжлэх ухааны онол, арга зүйн сэтгүүлтэй хамтран хэвлүүлж байна. Эрх зүйн шинэтгэлийн судалгаа сурталчилгааны асуудлаар мэргэжлийн нийм сэтгүүлтэй цаашид ч хамтран ажиллах болно.

Сэтгүүлд орсон материалуудыг хуулийн байгууллагын удирдах ажилтнууд, эрх зүйн чиглэлийн манай болон гадаадын эрдэмтэд, залуу судлаачид бичсэн болно.

УЛСЫН ИХ ХУРАЛД ДАХЬ
МАХН-ЫН БҮЛГИЙН АЖЛЫН АЛБА

Эрхэм уншигч танаа

Манай сэтгүүлийн нэг чухал зорилт бол эрх зүйн салбар бүрийн гол гол эх сурвалж болох хуулиудын талаарх үзэл баримтлал, зохицуулалтын механизм, үр нөлөөг дээшлүүдэх арга замыг мэргэжлийн олон түмэнд хүргэж, тэдний анхаарлыг энэ чигт хандуулахад чиглэдэг.

Улсын Их Хурал бол Монгол Улсын хууль тогтоох цорын ганц байгууллага. Энэ ч учраас УИХ хууль тогтоох үйл ажиллагаандаа гол анхаарлаа хандуулах нь ойлгомжтой. Бас хууль тогтоох ажиллагааг өөртөө багтаадаг хууль бүтээх үйл ажиллагаанд ч бүхэлд нь анхаарлаа хандуулдаг.

Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл хэрхэн боловсрогдсоноос парламентын хууль тогтоох ажиллагааны хувь заяа үлэмж хэмжээгээр хамаардаг.

Иймд бид эрх зүйт төрийн нэг гол шөнж болсон нийгмийн харилцааг хуулиар зохицуулах шаардлагын хүрээнд эл ажлын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах зорилт тулгарч буйг иш үндэс болгон Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлгийн ажлын албатай хамтран энэхүү дугаарыг бэлтгэсэн юм.

Түүнчлэн иргэний хуулийн төсөл боловсрогдож буй энэ үед иргэн, гэр бүлийн эд хөрөнгийн харилцааны эрх зүйн зохицуулалтын тулгамдсан зарим асуудлаарх судлаачдын өгүүллийг эл дугаартаа оруулав.

ЕРӨНХИЙ РЕДАКТОР ДАНЗАНГИЙН ЛҮНДЭЭЖАНЦАН

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖИЛЛАГААНД ТУЛГАРЧ БАЙГАА ӨНӨӨГИЙН АСУУДЛУУД

Цэцгийн МӨНХ-ОРГИЛ

Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд

1990-ээд оноос Монгол Улсад эхэлсэн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд нийгмийн олон талт харилцааг зохицуулсан олон хууль төрөн гарсан бөгөөд тэдгээр нь өөр өөрсдийн үүргийг зохих хэмжээгээр гүйцэтгэж ирлээ. 1998 онд Улсын Их Хурлаас баталсан Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн дагуу хууль тогтоомжийг боловсронгуй болгох үйл ажиллагааг тодорхой төлөвлөгөөтэй, үе шаттайгаар зохион байгуулж байна. Монгол Улсын хууль тогтоомжийг 2004 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд 140 орчим хууль батлахаар туссанаас шинээр боловсруулах 31, одоо үйлчилж байгаа 65 хуульд нэмэлт, өөрчлөлт орох юм.

Өнөөдөр манайд хууль санаачлагч субъектүүд бүрэн эрхийнхээ дагуу хуулийн төсөл санаачлан боловсруулж байгаа, гэхдээ мэргэжлийн яам болохынхоо хувьд Хууль зүй, дотоод хэргийн яам хуулийн төсөл боловсруулах үүргийг үндсэнд нь хариуцаж байгаа билээ. Хуулийн төсөл боловсруулна гэдэг нь олон хүний хөдөлмөр шаардсан нарийн цогц үйл ажиллагаа бөгөөд хуулийн төслийн боловсруулалтаас тухайн нийгмийн харилцааг зохицуулж чадах эсэх, тухайн хууль цаашид хэрхэн хэрэгжих нь шууд хамаардаг. Хуулийн төслийн боловсруулалтын чанар нь Улсын Их Хурлын Байнгын хороо, нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэх явцад нлэрлэг билээ.

1997 онд Улсын Их Хурлаас "Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай" хууль батлан гаргасан бөгөөд энэ хуулиар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах журам, түүнд тавигдах шаардлага болон хууль санаачлагчдын бүрэн эрхийг нарийвчлан тодорхойлж өгсөн юм.

Сүүлийн үед Улсын Их Хурлаар хуулийн төсөл хэлэлцэх явцад хуулийн төслийн боловсруулалт муу, чанаргүй хууль оруулж ирж байна гэсэн шүүмжлэл байнга гарч байна. Мөн түүнчлэн олон нийтийн зүтээс амьдралаас хол тасархай хууль баталдаг, баталсан хууль нь хэрэгждэггүй гэсэн санал шүүмжлэл ч тасрахгүй байгаа билээ. Тэгэхлээр эд бүгд чухам юунаас болоод байна, асуудлын учир шалтгаан нь чухам юунд байна, эдгээр асуудлыг ямар арга замаар шийдвэрлэж болох талаар авч үзэхийг оролдоё. Дашрамд дурдахад Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаа болно.

1. Хуулийн төсөл боловсруулах ажил юуны түрүүнд хуулийн үзэл баримтлал (концепц) боловсруулахаас эхэлдэг. Хууль санаачлагч нь үзэл баримтлал боловсруулахдаа юуны өмнө тухайн хууль гарах зайлшгүй чухал шаардлагатай, нийгмийн тухайн харилцааг хууль гаргахгаас өөр аргаар зохицуулах боломжгүй болохыг нотлох шаардлагатай. Түүнчлэн хуулиар зохицуулах асуудлын хүрээг маш тодорхой нарийн зааглаж өгөх хэрэгтэй байдаг. Өнөөгийн практикаас харж байхад зарим хуулийн төсөлд нэгдсэн үзэл баримтлал байдаггүй, байсан ч зөрүүтэй байдаггаас болж чухам ямар харилцаа зохицуулах гээд байгаа нь ойлгомжгүй, хэрэгжүүлэх механизм тодорхой бус байх нь тийм ч цөөнгүй тохиолдож байна.

Үүнтэй холбогдуудан дээр дурдсан хуулийн төсөлд доорхи агуулгатай заалт тусгахыг зорьж байна. Засгийн газраас боловсруулж буй хуулийн төслийг өнөөдөр төрийн захиргааны төв байгууллагууд буюу яамд харууцан боловсруулж байгаа. Гэтэл зарим тохиолдолд тодорхой салбарын эрх ашгийг явцуу хамгаалсан, асуудалдаа хэт баригдсан хуулийн төсөл боловсруулан орж ирэх нь цөөнгүй байна. Чухамхүү ниймээс яам бодлогоо өөрсдөө тодорхойлоод хуулийн үзэл баримтлалаа Хууль зүй, дотоод хэргийн яамтай зөвшилцөн хамтран баталж, хуулийн төслөө боловсруулах, Хууль зүй, дотоод хэргийн яам хуулийн төслийн эцсийн боловсруулалт, технологид хяналт тавьж байвал илүү үр дүнтэй байх болов уу. Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн хуулийн төсөл санаачлан боловсруулж байгаа бол хуулийн төслийн үзэл баримтлалаа Хууль зүй, дотоод хэргийн яаманд ирүүлж болох бөгөөд энэ тохиолдолд Хууль зүй, дотоод хэргийн сайд зөвлөмж гаргана. Уг зөвлөмжийг хүлээн авах эсэх нь мэдээж тэдний эрхийн асуудал байх юм. Засгийн газрын тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд "хууль тогтоомжийн боловсруулалтын арга зүй"-н асуудал багтдаг билээ. Энэ нь Хууль зүй, дотоод хэргийн яам зөвхөн Засгийн газраас харууцан боловсруулж байгаа төсөл төдийгүй ер нь аливаа хуулийн төслийн боловсруулалтыг харууцна гэсэн үг юм.

Үзэл баримтлалаа эхэлж тогтож аваад нэгдсэн санаа бодолтой болсон байх нь их чухал бөгөөд энэ нь тухайн хуулийн цаашдын хувь заванд ч эерэгээр нөлөөлөх нь дамжиггүй юм. Нэгэнт үзэл баримтлалаа зөв тодорхойлж чадсан, хууль зүйн хувьд зохих зөвшөөрөл авсан тохиолдолд хуулийн төслийн боловсруулалтын явцад зарчмын чанартай зөрчилдөөн гарах явдал үгүй болж, улмаар хууль тогтоогчийн өмнө хуулийн төслөө амжилттай хамгаалж, тэдэнд ойлгуулж, үнэмшүүлэх, батлуулахад дөхөм болох юм.

2. Хууль практик амьдралд муу хэрэгждэгийн нэг шалтгаан нь хуулийн төсөл боловсруулах явцад хуулийн үр дагаврыг бие дээрээ мэдэрдэг, хуулийн үр шимийг жинхэнэ хүртэгч нар болох иргэд, олон нийт, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийнхний саналыг авдаггүйтэй холбоотой болов уу гэж бодож байна. Одоо үйлчилж байгаа "Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай" хуульд

хуулийн төсөл боловсруулахад холбогдох мэргэжлийн хүмүүс, эрдэмтдийг оролцуулна, хуулийн төсөл боловсруулсны дараа холбогдох байгууллага, хуулийн этгээдийн саналыг авна гэж заасан байдаг боловч энэ нь их явцуу хүрээнд явагддаг, иргэний нийгмийн дуу хоолой бараг хүрдэггүй гэхэд хилсдэхгүй бизээ. Энэ байдлыг засах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж байгаа Хууль, Улсын Их Хурлын бусад нийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх зорилгоор хэлэлцдэг нийтлүүлж, санал авч байх тухай заалт оруулж байгаа болно. Хууль санаачилж байгаа субъект хуулийг сурталчлах ажлыг хуулийн төсөл боловсруулах шатнаас эхлэх нь тухайн хуулийн шандын хэрэгжилтэд эерэгээр нөлөөлөх нь дамжиггүй юм. Нөгөө талаар иргэдийн эрх зүйн боловсролд зохих үр нөлөөгөө үзүүлж гэж үзэж байна.

АНУ-ын Конгресс чухал ач холбогдолтой буюу маргаантай хуулийн төслийг олон нийтээр (public hearing) хэлэлцүүлдэг байна. Хэлэлцүүлэх асуудал, хэлэлцэх он сар, өдөр, байрм 7 хоногийн өмнө олон нийтэд зарлаж, хэлэлцүүлэгт тухайн хуулийн төсөлд сонирхогч этгээдийг дуудан ирүүлж, төсөлтэй холбоотой асуулт тавьж, хариултыг нь сонсдог. Мөн тухайн этгээдийн тайлбарыг бичгээр авдаг. Ингэж хуулийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, хуулийн төсөл боловсруулах явцад олон нийтийн санаа бодлыг авах нь хуулийн хэрэгжилтэд сайнаар нөлөөлөх тул Улсын Их Хурлын зохих Байнгын хороо хуулийн төсөлд ирсэн саналыг нэгтгэн судалж, шаардлагатай тохиолдолд санал өгсөн иргэн, хуулийн этгээдийн төлөөлөгчийг Байнгын хорооны хуралдаанд дуудан ирүүлж, зөвхөн төсөлтэй холбогдсон асуулт тавьж, хариулт авч болох тухай заалт Улсын Их Хуралдааны дэгийн тухай хуульд оруулахад болохгүй гэх газаргүй юм.

3. Аливаа хуулийн төсөл боловсруулахын өмнө тооцоо, судалгаа хийх нь маш чухал ач холбогдолтой байдаг. Энэ шаардлага нь хэдийгээр хуульчлагдсан байдаг ч манай хууль санаачлагчид хуулийн төсөл хийхдээ судалгаа бараг хийдэггүй, санхүүгийн тооцоогүй, гарах үр дагавар нь бодит амьдрал дээр, жирийн хүмүүст яаж тусах вэ гэдгийг мэддэрлэггүй, урьдчилан харж чаддаггүйгээс хүмүүсийн ярьдгаар "амьдралаас тасархай" хууль гарах нь цөөнгүй тохиолдож байна. Тэгэхлээр аливаа хуулийн төсөл боловсруулахын өмнө түүний хэмжээгээс үл хамааран судалгааг үл суурьтай сайтар хийж, (магадгүй энэ нь багагүй хугацаа авна) нийгмийн болон эдийн засгийн үр дагаврыг урьдчилан тооцож чаддаг байх хэрэгтэй байна.

4. Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэхэд бэлтгэх, хэлэлцүүлэх шатанд тухайн үүрэг хүлээж байгаа байгууллагууд, өөрөөр хэлбэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Байнгын хороодын ажлын алба дор бүрдээ "Хууль, Улсын Их Хурлын бусад нийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай" хуулийн заалт бүрийг биелүүлж баймаар байна. Жишээ нь, уг хуульд заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын санаачилсан хуулийн төслийг Үндсэн хууль, бусад хууль, эрх зүйн бодлогод нийцсэн эсэхийг эцэслэн хянаж Засгийн газрын хуралдаанаар

хэлэлцүүлдэг. Засгийн газраас санаачилж байгаа хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайд дэмжээгүй бол уг төслийг дахин боловсруулж, хуульд заасан шаардлагыг хангахуйц төсөл хийх хэрэгтэй болдог. Гэтэл бодит амьдрал дээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэмжээгүй төслийг Засгийн газраар хэлэлцүүлэн улмаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, өргөн мэдүүлсэн төсөл нь тэнд очоод унах жишээтэй. Зүй нь хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийн өмнө энэ асуудал дээр онцгой анхаарч хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд хуралдаанаар оруулж байх хэрэгтэй юм. Тэхдээ энд Засгийн газраас боловсруулж байгаа бүх төслийг ингэдэг гэж хэлж байгаа хэрэг биш юм. Мөн дээрхи хуулийн дагуу Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн нь хуулийн төсөл санаачилж байгаа бол Засгийн газраас санал заавал авсан байх ёстой. Гэтэл зарим тохиолдолд Засгийн газраас санал авалгүйгээр Улсын Их Хуралд шууд өргөн бариад, дараа нь Байнгын хороо, намын бүлгээр хэлэлцэж байх явцад Засгийн газрын санал нэхэгдэж, буцаагдаж байх жишээтэй. Эдгээр нь хуулийн заалтыг биелүүлэх талаар бага анхаарч байгаагийн илрэл юм.

ХУУЛЬ БҮТЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дашдондовын БАЯРСАЙХАН

Хууль зүй, дотоод хэргийн яамны

Хууль зүйн бодлогын газрын дарга

Эрх зүйт төрийн нэг үндсэн шинж бол нийгмийн гол гол харилцааг хуулиар зохицуулах, өөрөөр хэлбэл төрийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ гагцхүү хуулийг баримтлах, үүнээс үүдэн нийгмийн харилцааны тал бүрийг нэг бүрчлэн хуульчлах явдал бөгөөд төрөөс нийгмийг удирдах үндсэн арга нь хууль юм.

Хамгийн товчоор тодорхойлбол хууль бүтээх үйл ажиллагаа гэдэг нь нийгмийн харилцааг зохицуулах эрх зүйн хэм хэмжээний нэг хэлбэр болох хуулийг боловсруулах, баталж гаргах үйл ажиллагааг хэлнэ.

Хууль тогтоох, хууль бүтээх үйл ажиллагаа гэсэн 2 нэр томъёо байдаг. Хууль тогтоох үйл ажиллагаа нь хууль бүтээх үйл ажиллагааны нэг хэсэг юм. Өөрөөр хэлбэл хууль бүтээх үйл ажиллагаа өргөн утга агуулах бөгөөд уг үйл ажиллагаанд зөвхөн Улсын Их Хурал төдийгүй Ерөнхийлөгч, Засгийн газар, төрийн байгууллага, иргэн оролцдог байна.

Монгол Улс хууль шазмы баялаг уламжлалтай болох нь Их засаг, Халх журам, Монгол Ойрдын шаз, Зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичиг, түүнчлэн ардын засгийн жилүүдэд тогтоон мөрдөж ирсэн олон хуультай байгаагаас тод карагддаг. Эдгээр хууль шазмы бичгүүд нь бусад улсын нэгэн адил төр улсаа удирдах, ард иргэдээ захирахад чөлгөж байсан ба тухайн цаг үеийнхээ аж амьдралыг зохицуулж байсан. Түүхийн сурвалжийг судлаж үзэхдээ ганц өөрийн эх орноор хязгаарлавал учир дутагдалтай. Бусдын түүхийг судлах нь зайлшгүй чухал бөгөөд дуурайж дагаж хуулбарлахдаа бий харин нийгмийн амьдралаар тэгтож, шалгарсан хэм хэмжээг судлаж, өөртөө тохирох оновчтой зөвийг нь ашиглах явдал юм.

Америк, Япон, Герман зэрэг өндөр хөгжилтэй орнууд өнөөгийн хөгжиж байгаа орнуудын эрх зүйн үндсийг тодорхойлж байгаа нь маргах зүйл биш. Дэлхийн жишгээс тэс өөрөөр хөгжинө гэвэл хэзээ ч бүтэхгүй зүйл боловч жишиг болгоно гэдэг нь загварчилна хуулиа гэсэн үг бас биш юм.

Монгол Улсад шинэ Үндсэн хууль гарч байнгын ажиллагаатай парламент бий болсноор, тэр нь хууль тогтоох бүрэн эрхийг дангаар хэрэгжүүлж, уг үйл ажиллагаа нарийн журмын дагуу явагдах болсон. Үүнийг дагалдан хууль бүтээх үйл ажиллагаа ч мөн Үндсэн хуульд нийцсэн хуулиар нарийвчилсан журмаар зохицуулагдах болсон. Хууль бүтээх үйл ажиллагаа

гэж төрийн хүсэл зоригийг нийтээр дагаж биелүүлэх зан үйлийн дүрэм болгон удаан хугацаанд тогтвортой зохицуулах хууль зүйн дээд хүчин чадалтай эрх зүйн хэм хэмжээг бүтээх хүний ухамсарт үйл ажиллагаа юм.

Хууль бүтээх үйл ажиллагаа нь хуулийн төслийг боловсруулах, хуулийн төслийг хэлэлцэн батлах гэсэн 2 үндсэн үе шаттай байна.

Хуулийн төслийг боловсруулах үе шатанд дараах ажлууд хийгдэнэ:

- Хуулийг гаргах хэрэгцээ, шаардлага, үзэл баримтлалыг тодорхойлох
- Төслийн эхний хувилбарыг гаргах
- Төсөлд санал авах
- Төсөлд ирүүлсэн саналыг тусган дахин боловсруулах
- Төслийг эцэслэн боловсруулах
- Төслийг өргөн мэдүүлэх

Төслийг хэлэлцэн батлах үе шатанд дараах ажлыг хийнэ:

- Хуулийн төслийг хэлэлцэх
- Хуулийг батлах
- Хуулийг ёсчлох болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг тавих бүрэн эрхийг хэрэгжүүлэх
- Хуулийг хэлэлцэн нийтлэх
- Хуулийг системчлэх

Хуулийн төслийг хууль цаазын хэлбэрт оруулан бичих, хуулийг батлан гаргах, цаашид системчлэх, улам боловсронгуй болгоход хууль зүйн тусгай журам, арга хэрэгсэл ашиглах ба түүнийг бүхэлд нь хууль зүйн техник гэнэ.

Үндсэн хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрхтэй байна.

Хууль санаачлагч энэ эрхээ хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө санаачлах гэж буй хуулиар зохицуулах нийгмийн харилцааны төлөв байдал, өөрөөр хэлбэл тухайн харилцааг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилт, үр нөлөөг судалсны үндсэн дээр хэрэгцээ, шаардлагыг тодорхойлдог.

Хуулийн хэрэгцээг тодорхойлохын тулд шинжлэх ухааны үндэслэл сайтай судалгаа, мэдээллийг сайтар ашиглах ёстой юм. Нэгэнт хууль амьдралаас төрж, түүнд үйлчилдэг учраас нийгмийн амьдралыг дээд зэргээр судлан мэдэх нь чухал.

Нийгэмд хөгжил, өөрчлөлт явагдах хувьсахын кирээр нийгмийн харилцааным шинж, төлөв шинэчлэгдэж хувьсана. Иймд нийгмийн амьдралын бүхий л хүрээг сайтар судлах хэрэгтэй болно. Өөрөөр хэлбэл, хэрэгцээ, үйлдвэрлэл, өмч хөрөнгө, эрх мэдэл, үүрэг, хариуцлага гэх мэт хүмүүсийн хоорондын харилцааным сэжүүрүүд байх юм.

Эдгээрт үндэслэн нийгмийн амьдралын үлэмж олон талтай, ихээхэн нарийн төвөгтэй хэрэгцээ шаардлагыг зохицуулж чадахуйц хэмжээний хууль санаачлах хэрэгтэй болно.

Хууль санаачлах хэрэгцээ хоёр янзаар илэрч болох юм. Энэ нь юуны өмнө одоо үйлчилж байгаа хуулийг боловсронгуй болгох буюу тухайн цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай бол, эсхүл нийгэмд шинээр үүссэн харилцааг зохицуулах шаардлагатай бол тухайн харилцааг зохицуулах хууль гаргах зайлшгүй шаардлагатай болно.

Эдгээр хэрэгцээг мэдрэх хэрэгтэй. Үүний тулд нийгмийн сэтгэл зүйг судлах, түүнчлэн шинэ зүйлийг соргогоор хүдээн авах чадвартай байх хэрэгтэй юм.

Цаг үеийн шаардлага нэрээр дутуу дулимаг хууль гаргаад түүнийгээ ойр ойрхон өөрчлөөд байвал, тэр нь тухайн нийгмийн харилцааг бүрэн төгс, нухацтай судлаагүй гэсэн үг. Гэхдээ ямар ч хууль тодорхой цаг үе, тодорхой орон зайд үйлчлээд хүчингүй болохыг үгүйсгэх аргагүй юм.

Нийгмийн нэг төрлийн харилцааг зохицуулах нэг хуулийн хэрэгцээг судлаад зогсохгүй хууль тогтоомжийг нийтэд нь боловсронгуй болгох буюу нэг хэсэг хуулийн хэрэгцээг тодорхойлох нь хамгийн чухал асуудлын нэг мөн. Үүнийг хууль бүтээх ажлыг төлөвлөх гэж ойлгож болно.

Хууль бүтээх ажлыг төлөвлөх ажлын нэг хэлбэр нь Улсын Их Хурлаас батлан гаргадаг Эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр буюу хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл юм. Энэ баримт бичигт хуулийн төсөл боловсруулах ажлын үндсэн чиглэлүүд болон ойрын 4 жилд шинээр ямар ямар хууль гаргах, ямар ямар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг заасан байдаг.

Хуулиуд хоорондоо уялдаа холбоотой байдаг бөгөөд нийгмийн тулгуур хуулиуд болох Иргэний хууль, Эрүүгийн хууль өөрчлөгдөхөд түүнийг дагалдаад нилээн олон хуульд өөрчлөлт орох жишээтэй.

Иймээс энэхүү үндсэн чиглэлийг маш нухацтай олон талаас нь нягтлан үзэж байж боловсруулах шаардлагатай. Харамсалтай нь энэ ажил хэдхэн жамны хүрээнд явагдаад өнгөрөх явдал байдаг. Ингэхдээ тэр болгон шинэчлэх ухааны үндэстэй нийгмийн харилцааны судалгаанд тулгуурлахгүйгээр ийм л хууль хэрэгтэй байх гэсэн маягаар тааж оруулах, эсхүл салбарын явцуу эрх ашгийн үүднээс хандах явдал байдаг.

Энэ хөтөлбөр нь дөнгөж 2 дахь удаагаа батлагдаж байгаа шинэчлэг зүйл боловч хууль тогтоомжийн системийг нэгдсэн бодлоготой бүрдүүлэх, хууль бүтээх ажиллагаа ил тод байх, хуулийн төсөл боловсруулах ажил зохион байгуулалттай системтэй явагдах зэрэг ач холбогдолтой.

Хууль санаачлагч хуулийн хэрэгцээг судалсны дараа хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлдог. Үзэл баримтлалд хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн ерөнхий бүтэц, тухайн хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хууль батлагдсаны дараа үүсэх нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, бусад хуультай уялдуулах санал зэргийг тусгадаг.

Ер нь хууль санаачлагч хуулийн төслийг өөрөө боловсруулахаас гадна холбогдох байгууллагын эрдэмтэн, мэргэжилтэн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж, эсхүл гэрээний үндсэн дээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлж болохоор хуульд заасан.

Хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагаа нь өөрийн гэсэн зарчимтай байна. Үүнд:

- хууль ёсны зарчим буюу Үндсэн хуульд нийцсэн байх, бусад хуультай зөрчилдөхгүй байх, дотроо зүйл заалт нь зөрчилгүй байх, хууль боловсруулах ажил нь хуулийн хүрээнд явагдах,
- ил тод байх буюу аль болох олон түмний санаа бодолд тулгуурласан тэдний хүсэл зоригт нийцсэн байх,
- шинжлэх ухааны үндэстэй байх буюу зохицуулах нийгмийн харилцаа нь судлагдсан байх, бусад орны туршлага хуулийн практикийг судалсан байх,
- бодитой байх буюу түүхэн цаг үеийн объектив шаардлагыг тусгасан байх,
- нийгэм, төр, иргэдийн нийтлэг хэрэгцээ, ашиг сонирхлыг харгалзан үзэх буюу үндэсний аюулгүй байдал, үндэстэн, ард түмний нийтлэг эрх ашгийг тусгах,

Түүнчлэн хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд шударга ёс, ардчилсан ёс, нэрэнгүй ёсны түгээмэл зарчмуудыг удирдлага болгох ёстой.

Хуулийн төслийг боловсруулахдаа Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлдэх журмын тухай хуулиар тодорхойлсон төсөлд тавигдах шаардлагуудыг нарийн баримтлах хэрэгтэй байдаг.

Эдгээр шаардлагад нийцүүлэн зохих түвшинд боловсруулсан үндэслэл, хэл найруулга сайтай хуулийн төслийн анхны хувилбар нь дараа дараагийн шатанд бага цаг зарцуулж шуурхай батлагдах, улмаар батлагдсан хойноо бодитой хэрэгжихэд дөхөм үзүүлдэг.

Хуулийн төсөл нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байвал зохино:

1. Үндсэн хуульд нийцсэн болон бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээний заалттай уялдсан байх ёстой. Бүх хууль Үндсэн хуулийн хүрээнд гарах бөгөөд бусад хуультай харьцуулан судалж, орхигдсон харилцааг зохицуулахад чиглэнэ. Хэрэв бусад хуультай зөрчилдсөн байвал

түүнийг нийцүүлэхийн тулд уг хуульд өөрчлөлт оруулах төсөл боловсруулах, эсхүл зөрчилдсөн заалтыг хасна гэсэн үг.

2. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг аль болох бүрэн тусгаж, тухайн хуулиар зохицуулах харилцааны хүрээндээ халихгүй байх ёстой. Үүний тулд уг хуулиар зохицуулах харилцааг жагсааж гаргаад түүндээ дүн шинжилгээ хийнэ гэсэн үг.

3. Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх, хэм хэмжээ тогтоогоогүй тунхагласан шинэжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх ёстой. Энэ нь зүйл хэсгийн заалтуудад нэг санааг дахин давтан заахгүй, заалтууд нь бие биеэ үгүйсгэхгүй байх ба эрх зүйн ямар нэгэн үр дагавар үүсгэхгүй эсхүл, зөвхөн нэг удаа хэрэглэх заалт оруулахгүй байна гэсэн үг.

4. Бусад хуулийн заалтыг давхардуулан заалгүйгээр шаардлагатай бол түүнийг иш татах ёстой. Энэ нь ихэнхдээ ишлэл хийж байгаа нөгөө хуулиа тухайн харилцааг илүү дэлгэрэнгүй тусгасан байдагтай холбоотой ба тухайн хэм хэмжээг хэрэглэхэд дөхөмтэй байдаг. Ишлэлийг маш тодорхой хийнэ өөрөөр хэлбэл хуулийн бүрэн нэр, зүйл, хэсэг, заалтыг тодорхой бичин оруулна.

5. Хуулийн зорилт, тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хамрах хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогчдоос удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл, тэдгээрийг биелүүлэх журам, эрх, үүрэг, онцгойлон үзэх нөхцөл байдал, эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээг тодорхой заасан байх ёстой. Энэ нь тухайн хуулийн амон сүнс нь. Хуулийн зорилтыг маш зөв, уг хуулиар зохицуулах харилцааг бүхэлд нь багтаасан, товч байхаар томъёолох хэрэгтэй юм. Яагаад гэвэл зорилтоос нь уг хуулиар чухам ямар харилцааг, ямар хүрээнд зохицуулах гэж байгааг шууд ойлгох ёстой юм. Зорилтоосоо улбаалан бусад харилцаа нь тодорхой болно.

6. Шаардлагатай бол хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хуулийг дагаж мөрдөх хэм хэмжээ, хууль, хуулийн заалтыг хүчингүй болгох, бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг тусгасан байвал зохино. Хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг ихэвчлэн хөрөнгө снхүүжилттэй холбоотой болон хэрэг маргаан шийдвэрлэх процессын хуульд хэрэглэдэг. Уг хуулиар зохицуулах асуудлыг цогцоор нь авч үзэж шийдвэрлэхийн тулд даган гарах эрхийн акт болон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг хамтад нь оруулах шаардлагыг тавидаг.

Хуулийн төсөлд тавигдах нэг чухал шаардлага бол хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон төсөв зардлыг зөв тооцож гаргах явдал юм. Зохиц ёсоор нь бодитой төлөвлөхгүй бол хуулийн хэрэгжилт, үр нөлөөнд муугаар нөлөөлөх талтай.

Хуулийн үзэл баримтлалыг тодорхойлно гэдэг нь улс төрийн шийдвэр гаргаж байна гэсэн үг.

Хууль бүтээх үйл ажиллагааны нэг чухал үе бол энэхүү улс төрийн шийдвэрийг хууль зүйн хэллэгт оруулах явдал юм. Хууль зүйн хэллэгт оруулах үйл ажиллагааг төсөл бэлтгэх шийдвэр гаргасан үеэс тодруулбал,

тухайн төслийг боловсруулж эхлэх тэр үеэс хэрэгжиж эхэлнэ. Энэ үед л хууль бүтээх үйл ажиллагаанд оролцогсдын ур чадвар, туршлага, хууль зүйн шинжлэх ухааны нөлөөлөл, түүний хөгжлийн түвшин илрэн гарна. Хуулийн төслийг боловсруулах нь нягт нямбай, уйгагүй хөдөлмөрийг шаарддаг.

Хууль зүйн техник арга хэрэгслийн тусламжтайгаар энэ үйл ажиллагаа явагдана. Хуулийн төсөлд тавих хэл, нэр томъёоны шаардлагад дараах шаардлага орно.

- Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх,
- Нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх,
- Нэр томъёог үндсэн болон нийтээр хүлээн зөвшөөрсөн утгаар илэрхийлэх,
- Монгол хэлэнд тохирох үг нь байвал гадаад хэлний нэр томъёо хэрэглэхгүй байх,
- Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй, товч тодорхой ойлгоход хялбараар бичих,

Хуулийн төсөлд дараах тохиолдолд нэр томъёоны тайлбар хийдэг.

1/ нэр томъёо нь олон утгатай бол

2/ нэр томъёо нь өргөн утгатай бөгөөд түүнийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай бол

3/ шинээр бий болсон ойлголт буюу нэр томъёо нь нийтэд ойлгомжгүй бол,

Хуулийн төсөлд дараах тохиолдолд гадаад хэлний нэр томъёо хэрэглэж болдог байна.

1/ уг нэр томъёог оноосон нэр монгол хэлэнд байхгүй бол

2/ уг нэр томъёог олон улсын хэмжээнд нийтлэг хэрэглэж хэвшсэн бол

3/ уг нэр томъёог Монгол улсын олон улсын гэрээнд хэрэглэж байгаа бол

Ер нь хууль зүйн хэм хэмжээг хэлбэржүүлэхэд гурван төрлийн нэр томъёог ашигладаг.

а/ нийтээр хэрэглэдэг

б/ техник хэллэг

в/ хууль зүйн хэллэг

Хамгийн гол нь нэр томъёог нэг талаас маш ойлгомжтой, тодорхой, нөгөө талаас утга санаа бүрэн төгс байхаар зөв сонгож хэрэглэх явдал юм.

Техникийн болон хууль зүйн тусгай хэл нь мэргэжлийн хүмүүс хоорондоо харьцах хэл юм. Мэргэжлийн бус хүмүүс түүнийг хэрэглээд эхлэхээр тэр нь өөрийнхөө мэргэжлийн хүмүүсийн ойлгож байсан шууд утгыг алдахад хүрдэг. Жишээ нь: "өмч", "эд юмс", "эээмших", "ашиглах" зэрэг үгийг ахуйн нөхцөлд нэг өөр, хууль зүйн хэллэгт нэг өөр утгаар ойлгох жишээтэй

юм. Хууль зүйн актын заалтууд нь гол төлөв тодорхой бус тооны хүмүүст чиглэгддэг бөгөөд тэдний ихэнх нь хуульч биш байдаг.

Иймд мэргэжлийн бус хүмүүс ойлгоход хүндрэлтэй тийм хэллэг, үгийг аль болох хэрэглэхгүй байх нь зүйтэй. Нийтэд хүртээмжтэй ойлгомжтой болгох гээд оновчтой үг хэллэгийг хэрэглэхээ зайлсхийх нь зохисгүй. Энэ байдлыг тухайн хууль зүйн акт болон хуулийн нэр томъёоны тайлбар хийх замаар шийдэж болно.

Үг сонгохдоо аль болохоор орчин цагтайгаа нийцүүлж сонгох хэрэгтэй. Хоцрогдсон, хэрэглэхээ больсон үг хэллэгийг хэрэглэхээ зайлсхийх нь зүйтэй. Чимэг үг, зүйрлэл үг хэллэгийг хэрэглэхгүй байх нь зохистой.

Хуулийн заалт нь аль болохоор хялбар уншигддаг байхаас гадна мөн заалтуудыг бүрдүүлэх өгүүлбэрт зохицуулах гэж буй санааг илэрхийлсэн үг олон байх ёсгүй. Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад түүний нэгдсэн хэлбэржилт, хэллэгт анхаарах зүйлийн нэг бол товчлолыг яаж хэрэглэх явдал юм. Жишээ нь: Он, сар, өдрийг нэг хэв загвараар бичих, ямар тоог үсгээр, ямар тоог тоогоор бичих (мөнгөний дүн, бутархай тоо)

Мөн бүлэг, зүйл, хэсэг, заалтуудын дугаарыг ямар тоогоор, үсгээр дугаарлах (араб, латин) гэх зэргийг анхаарах нь зүйтэй.

Харин тооноос бусад тодорхой нэр үг, холбоо үг, сул үг зэргийг товчлохоос татгалзах ёстой. Жишээ нь: г.м-гэх мэт, МУ-Монгол Улс, УИХ-ын-Улсын Их Хурлын

Хууль зүйн техникийн арга хэрэгсэлд баримт бичгийн бүрдүүлэлт, бүтэц чухал байр суурьтай. Хуулийн төсөл нь толгойн хэсэг, бичвэрийн хэсэг, баталгааны хэсгээс бүрдэнэ. Толгойн хэсэгт агуулгыг товч, тодорхой илэрхийлсэн нэр, гаргасан он, сар, өдөр багтана. Бичвэрийн хэсэгт тухайн нийгмийн харилцааг зохицуулах хэм хэмжээнүүд орно. Бичвэрийн хэсэг нь зүйл, бүлэг, анги, зүйлийн дотор дэд хэсэг, хэсэг нь дотроо заалтаас бүрдэнэ.

Хуулийн төслийн оноосон нэр, нийтлэг хэм хэмжээ тогтоож байгаа зүйлийг нэгтгэсэн "ерөнхий анги" буюу эсхүл "нийтлэг үндэслэл" гэсэн анги, бүлэг, нэр томъёоны тайлбар, тусгайлсан хэм хэмжээ тогтоож байгаа зүйлийг нэгтгэсэн "тусгай анги" буюу, эсхүл агуулгаар нь бүлэг болгосон эрх зүйн хэмжээ, иргэн, хуулийн этгээдээс үйл ажиллагаа явуулах журам, тэдгээрийн эрх үүрэг, онцгойлон үзэх нөхцөл байдал, хариуцлага тогтоож байгаа хэм хэмжээ, шаардлагатай бол хууль хүчин төгөлдөр болох тухай хэм хэмжээ гэсэн хэлбэрт оруулж байрлуулна.

Ангийг ром тоогоор, бүлгийг бичгээр, зүйлийг ард нь "дугаар" буюу "дүгээр" зүйл гэж араб тоогоор (1 дүгээр зүйл гэх мэт), хэсгийг баруун талдаа цэгтэй араб тоогоор (1.1. гэх мэт), хэсгийн доторхи заалтыг баруун талдаа цэг бүхий араб тоогоор (1.1.1. гэх мэт) тус тус тэмдэглэнэ.

Хуулийн төслийг боловсруулсан этгээд (ажлын хэсэг, хуулийн этгээд, иргэн) төслийг боловсруулж дуусаад хууль санаачлагчид анхны хувилбарыг танилцуулна.

Хууль санаачлагч төслийг хянан үзээд шаардлагатай гэж үзвэл чиглэл өгч дахин боловсруулахаар буцаах эсвэл холбогдох байгууллагаас санал авахаар тараах шийдвэр гаргана.

Засгийн газар яаж санал талаар дэлгэрүүлж ярьж, Засгийн газраас санаачилж буй хуулийн төслийг тухайн асуудлыг хариуцаж байгаа сайд буюу Засгийн газрын гишүүн хариуцан боловсруулдаг. Ингэхдээ тухайн сайдын харьяанд ажиллаж байгаа төрийн захиргааны төв байгууллага буюу сайдын ажлын аппаратад мэргэжилтнүүд төслийг боловсруулдаг.

Засгийн газрын тухай МУ-ын хуульд Засгийн газрын гишүүдийн хариуцах асуудлыг нарийвчлан тодорхойлсон байдаг. Тухайлбал, эрүү, иргэний хууль тогтоомжийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Авто зам, барилга, тээврийн талаархи хуулийг Дэд бүтцийн сайд, нийгмийн даатгал, хөдөлмөрийн асуудлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд гэх мэт.

Ихэнхдээ хуулийн төслийг боловсруулах тухайн асуудлаар мэргэшсэн мэргэжилтэн, тус салбарын эрдэмтэн, судлаачдын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулж, тэдгээрийг чиг үүргээр нь ажлын хэсгийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга гэж хуваана. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь тус хэсгийн хуралдааны тэмдэгтэлийг хөтлөж, төслийг гардан бичдэг тул нилээд туршлагатай байхыг шаарддаг.

Ажлын хэсэг, мэргэжилтнүүд төслийг боловсруулж дуусаад сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр төслийг уг зөвлөлийн гишүүдэд урьдчилан тараана. Сайдын зөвлөл нь сайдад зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэх, шийдвэрлэхэд нь зөвлөх үүрэг бүхий орон тооны бус байгууллага юм.

Сайдын зөвлөлд тухайн салбарт ажиллаж байгаа тодорхой албан тушаалтан, нэр хүндтэй хүмүүс ордог.

Сайдын зөвлөл хуулийн төслийг нягтлан хэлэлцээд тодорхой санал өгөх ба саналыг хүлээн авах боломжтой бол төсөлд тусган боловсруулж, сайдын гарын үсэгтэй албан бичгээр бусад бүх яам болон тухайн асуудалд хамаарах байгууллагаас (төрийн болон төрийн бус) санал авахаар хүргүүлнэ.

Төсөлд яам болон төрийн байгууллага ажлын 5 хоногт багтаан санал ирүүлэх журамтай байдаг ба энэ нь тун богино хугацаа. Яагаад гэвэл зарим хууль олон зүйл, заалттай, нийгмийн олон талт харилцааг зохицуулсан байдаг. Түүнд санал бичихийн тулд саналын төсөл бэлтгэж байгаа мэргэжилтэн эхлээд уг хуулиар зохицуулах харилцааг өөрөө сайн ойлгож, хэдэн арван удаа уншиж судлах шаардлагатай.

Гэхдээ төсөлд санал авахаар тарахдаа сайд хугацааг уртасган тогтоох боломжтой.

Яамд саналыг сайдын гарын үсэгтэйгээр, бусад байгууллага тухайн байгууллагын удирдах дээд албан тушаалтны гарын үсэгтэй албан бичгээр төсөл санаачлагчид ирүүлнэ.

Саналыг ажлын хэсэг хүлээн авч тусгай хүснэгтэд оруулан бичих ба санал болгоныг ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэн төсөлд тусгах эсэхийг шийдвэрлэнэ. Хэрэв саналыг тусгах боломжгүй гэж үзвэл тайлбар, үндэслэлийг заавал тэмдэглэнэ.

Ажлын хэсгийн гишүүд санал зөрөөтэй байвал олонхийн саналаар шийдвэрлэнэ. Энэ талаар ажлын хэсгийн хурлын тэмдэглэлд тэмдэглэнэ.

Ажлын хэсэг төсөлд ирүүлсэн саналыг тусган боловсруулж сайдад танилцуулна. Ингэхдээ бүх холбогдох материалыг ирүүлсэн бүх санал, түүнд өгсөн ажлын хэсгийн тайлбар, ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлийн хамт танилцуулна.

Сайд төслийг эцэслэн хянаж засвар хийж ажлын хэсэгт өгнө. Сайдмн хийсэн засварыг тусган эцэслэн боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн сайдад хүргүүлдэг. Өөрөөр хэлбэл хууль зүйн асуудал эрхэлсэн сайд 2 удаа хянан үзэж санал өгдөг.

Хууль зүйн асуудал эрхэлсэн сайд төслийг эцэслэн хянаж, Засгийн газрын танхимын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлдэг. Тухайн асуудал эрхэлсэн сайд, хууль зүйн асуудал эрхэлсэн сайд хуулийн төсөлд тусгагдсан ямар нэг асуудлаар санал зөрөөтэй байвал Засгийн газрын танхимын хуралдаанаар хэлэлцэн эцэслэн шийдвэрлэдэг.

Танхимын хуралдаанаар төслийг хэлэлцэхдээ гишүүдийн саналыг тусгах эсэхийг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Танхим дараах шийдвэрийн аль нэгийг гаргана.

1) төсөлд танхимын гишүүдийн тодорхой саналыг тусган эцэслэн боловсруулж Улсын Их Хуралд өргөн барихыг диалгах

2) төслийг дахин боловсруулахаар тухайн асуудал харнирсан сайд буюу ажлын хэсэгт буцаах

1 дэх тохиолдолд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, ажлын хэсэгтэй хамтран танхимын саналыг тусган УИХ-д өргөн мэдүүлэхэд бэлтгэнэ.

2 дахь тохиолдолд ажлын хэсэг дахин төсөл дээр ажиллаж сайдад танилцуулна. Төсөлд зарчмын өөрчлөлт хийсэн бол дахин холбогдох байгууллагаас санал авч, дээр дурдсан процесс дахин давтагдана.

Хуулийн төсөл санаачлах эрх бүхий нөгөө 2 субъект нь төслийг боловсруулж дууссаны дараа Засгийн газраас санал дүгнэлт авна. Засгийн

газраас санал дүгнэлт авахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт ирүүлнэ. Засгийн газрын хэрэг эрхлэх газар төслийг тухайн асуудал эрхэлсэн сайдад хүргүүлнэ.

Уг сайд төслийг хүлээн аваад бусад яамд болон шаардлагатай гэж үзвэл холбогдох бусад байгууллагаас санал авна. Ирүүлсэн санал бүрийг тэмдэглэн, нэгтгэнэ. Нэгтгэсэн саналаас тусгах нь зүйтэй гэсэн саналыг нэгтгэн саналын төсөл боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн сайдад хүргүүлнэ.

Хууль зүйн асуудал эрхэлсэн сайд уг саналын төслийг хянан үзнэ. Ингэхдээ дараах зүйлийн талаар санал бэлтгэнэ.

Уг саналын төсөл нь

- Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа эсэх
- уг хуулийн төсөл нь бүхэлдээ үндэсний эрх зүйн шинэтгэлийн бодлогод нийцэж байгаа эсэхийг хянан үзээд дүгнэлт бэлтгэн тухайн асуудал эрхэлсэн сайдад явуулна.

Тухайн асуудал эрхэлсэн сайд Засгийн газрын санал, дүгнэлтийн төслийг Засгийн газрын танхимын хуралдаанаар хариуцан хэлэлцүүлнэ.

Засгийн газар танхимаар хэлэлцэн Засгийн газрын санал, дүгнэлтийг батлан төсөл санаачлагчид хүргүүлнэ.

Хуулийн төслийг санаачлагч Улсын Их Хурлын даргад Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр өргөн баривч. Ингэхийн омын Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргад дараах материалыг бүрдүүдэн хүргүүлнэ.

- 1) хуулийн төслийг өргөн мэдүүлэх тухай хууль санаачлагчийн албан бичиг
- 2) хуулийн төсөл, түүний дэлгэрэнгүй танилцуулга
- 3) уг хуультай уялдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл
- 4) хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээний санал, холбогдон үүсэх зардал, санхүүгийн тооцоо
- 5) Засгийн газар болон холбогдох бусад байгууллагын санал

УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга 72 цагийн дотор уг материалыг хянан үзээд шаардлага хангасан гэж үзвэл хуулийн төслийг өргөн барих одрийг товлон хууль санаачлагчид мэдэгдэнэ.

Хэрэв шаардлага хангаагүй гэж үзвэл хангуулах арга хэмжээг авна.

Улсын Их Хурлын дарга төслийг хүтээж аваад холбогдох байнгын хороонд шилжүүлнэ. Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх асуудлыг Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулагд.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг авч хэлэлцэхдээ уг төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд хэлэлцүүлэхээр оруулах, эсхүл дахин боловсруулахаар хууль санаачлагчид буцаахаар асуудлыг шийдвэрлэнэ. Хуудлын төсөл хууль тогтоомжийн техник найруулга зүйн шаардлага хангаагүй, эсхүл түүгээр зохицуулагдах ёстой асуудлыг төсөлд тусгасан гэж үзвэл төслийг буцаадаг бөгөөд төслийг нэхэхдээ Байнгын хороо хууль санаачлагчтай хамтран төслийг гүйцээн боловсруулж Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оруулдаг. Байнгын хорооны хуралдаанд бусад байнгын хорооны гишүүд оролцож төслийн талаархи өөрийн саналыг хэлж болно. Гэхдээ таслах эрхгүй байна. Мөн нам, эвслийн хуралдаанаар хуудлын төслийг хэлэлцэх ба уг төсөл санаачлагчийг байлцуулна. Хэлэлцүүлэг энд байнгын хорооныхтой нэгэн ажил явагдана. Ялгаа нь тогтоол төлөвлөхгүй. Санал хураалтын дүнг Улсын Их Хуралд өргөн барина.

Байнгын хорооны хуралдаан дээр санал зөрж байгаа гишүүд хоорондоо зөвшилцөж улмаар төслийн талаар хорооны санал дүгнэлтийг боловсруулж Улсын Их Хурлын нийт гишүүнд тарааж анхны хэлэлцүүлэгт бэлтгэнэ.

Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар уг төслийг хэлэлцүүлэхдээ төсөл санаачлагч илтгэл тавина. Байнгын хороо, нам, эвслийн санал дүгнэлт байвал хэлнэ. Үүний дараа Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал дүгнэлтийн талаар асуулт хариулт явуулна. Ингээд төслийг дэмжиж байгаа буюу эсэргүүцэж байгаа хоёр хүн үг хэлнэ. Ингээд Улсын Их Хурал дээр төслийг хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулна. Хэрэв Улсын Их Хурал хэлэлцэх санал хураалтыг дэмжвэл нэгдүгээр хэлэлцүүлгийг хангах үүргийг тухайн байнгын хороонд өгнө. Хэлэлцэхгүй гэж үзвэл үндэслэл, нохцлийг дурьдсан Улсын Их Хурлын тогтоол гаргана.

Байнгын хороо зүйл, заалт болгоноор асуулт хариулт явуулна. Төсөл санаачлагч хариулт өгнө. Хэрэв уг төслийн талаар Улсын Их Хурал буюу байнгын хороо, ажлын хэсэг байгуулсан бол уг хэсгээр асуулт хариулт авна. Ажлын хэсэг төсөл санаачлагчтай хамтарч уг төслийн талаар тодорхой саналуудыг бэлтгэнэ. Асуулт хариулт авсны дараа гишүүн бүр саналаа хэлнэ. Ингэж саналаа хэлэхдээ зүйл заалтад оруулах томъёололыг байнгын хорооны даргад өгсөн байна. Ингээд санал дүгнэлт хэлж дууссаны дараа байнгын хороон дээр санал хураалт явуулна. Санал хураалтыг тухайн гишүүний саналаар явуулна.

Мөн байнгын хорооны дүгнэлтэд уг зүйлийг заавал дурьдана. Хэрэв энэ олонхи болж чадахгүй бол төслийн саналыг байнгын хорооны олонхи явуулна. Ингээд бэлэн болсны дараа төслийг өөрсдийн санал дүгнэлттэй Улсын Их Хуралд оруулна. Улсын Их Хурал дээрхи зарчмын зөрүүтэй санал болгоноор санал хурааж шийдвэрлэнэ. Зарчмын зөрүүтэй санал гэдэгт Байнгын хорооноос санал нэгтгэй буюу олонхийн саналаар оруулахаар шийдвэртгэсэн төсөлд тусгагдаагүй санал, зохих Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн боловч зөвшилцөлд хүрээгүй Улсын Их Хурлын гишүүний санал, олонхи, цонхийн, нам, эвслийн бүлгээс зарчмын гэж үзэж

дүгнэлтэндээ тусгасан саналыг тус тус хэлдэг. Улсын Их Хурлын гишүүн Байнгын хорооны дүгнэлтэд тусгуулсан зарчмын зөрүүтэй саналаа бичгээр томъёолж урьдчилан өгсөн байна. Зарчмын зөрүүтэй саналуудыг Тамгын газар нэгтгэн хуралдаан даргалагчид өгнө. Даргалагч тэдгээр санал бүрээр санал хураалгана. Санал хураахад альтернатив байдлаар санал хурааж болно.

Төсөлд зарчмын зөрүүтэй асуудлаар санал хураасны дараа Улсын Их Хурал доорхи хоёр шийдвэрийн аль нэгийг гаргана.

- Төслийг бүхэлд нь 2 дугаар хэлэлцүүлэгт бэлдье.
- Хууль санаачлагчид буцаах тухай

Анхны хэлэлцүүлгийн үед зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд уг төслийг батлах санал гарсан бол эцсийн хэлэлцүүлгийг шууд явуулж болно.

Хуулийн анхны хэлэлцүүлгийн үр дүнг үндэслэн Байнгын хороо дараагийн хэлэлцүүлэгт бэлтгэнэ. Ингэхдээ Улсын Их Хурлын гишүүний болон хууль санаачлагчийн томъёолж өгсөн санал бүрийг хянан үзэж төсөлд зохих нэмэлт өөрчлөлт оруулж хууль тогтоомжийн бичлэгийн техник, хэл зүй, найруулгын талаас нь нягтлан зохих танилцуулгыг бэлтгэнэ.

Ихэнх тохиолдолд хоёр дахь хэлэлцүүлэгээр хууль батлагддаг. Төсвийн зэрэг зарим хуулийг хэд хэдэн хэлэлцүүлэг дамжуулдаг байна.

Эцсийн хэлэлцүүлгийн явцад дор дурдсан нөхцөл байдал үүссэн бол санал хурааж, асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг.

1. Эхний хэлэлцүүлгийн үед гүйцээн боловсруулахаар шийдвэрлэсэн төслийн зүйл, заалтыг хэлэлцэх бол,
2. Эхний хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн боловч уг асуудлаар дахин санал хураах шаардлагатай гэсэн Байнгын хорооны саналыг чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны нэг нь дэмжсэн бол,
3. Төслийн аль нэг зүйл, заалт хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа хууль болон уг төслийн бусад зүйл заалттай зөрчилдөж байна гэж зохих Байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороо үзсэн бол .

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд зааснаар хуулийн төслийн эцсийн найруулгыг сонсдог. Эцсийн хэлэлцүүлгээр батлагдсан төслийг ажлын хэсэг, Улсын Их Хурлын Тамгын газар эцэслэн шийдвэрлэсэн байдлаар нь өөрчлөн найруулж, энэхүү найруулгыг Улсын Их Хуралд танилцуулна. Ийнхүү Улсын Их Хурлын гишүүд баталсан төсөлтэй бүрэн эхээр нь танилцаж эцсийн хэлэлцүүлгээр шийдсэн утга санаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт бүрэн тусгагдсан эсэхийг шалгадаг. Эцсийн найруулга танилцуулах үед аливаа хэлэлцүүлэг хийхгүй, гагцхүү "техникийн" шинжтэй асуудлаар санал гаргаж шийдэж болно. Тухайлбал: хууль, шийдвэрийн найруулгыг сайжруулах, үйлчилж буй хууль тогтоомжид нийцэхгүй бол

зөрчлийг арилгуулах, батлагдсан боловч тусгагдаагүй орхигдсон, эсхүл буруу тусгагдсан саналыг засч залруулах асуудлыг энэ үе шатанд авч үздэг.

Хуулийн төслийг батлах, түүний хүчинтэй болоход тодорхой тооны гишүүд байхыг шаарддаг. Гэхдээ энэ нь бүх улсад ижил байдаггүй. Их Британы гол танхимд энэ нь маш бага 40 гишүүн, Австри Австралид бүх гишүүдийн 3-ны нэгээс багагүй гишүүд байхыг шаарддаг. Ихэнх орны Үндсэн хууль болон дотоод дүрмээр хуралдаанд байх ёстой гишүүдийн тоо нийт гишүүдийн талаас багагүй байхыг шаарддаг. Самал хураалтын үр дүнд хэлэлцсэн асуудлаархи олонхийн санал илэрхийлэгдэн гарч ирдэг. Ардчилсан зарчмаар олонхийн санал цөөнхийн саналаас давуу хүчтэй бөгөөд иргэн бүр заавал биелүүлэх болдог.

Санал хураалт нь хэд хэдэн төрөлтэй байна. Хууль тогтоох үйл ажиллагаанд нууц санал хураалт маш ховор хэрэглэгддэг боловч Итали зэрэг цөөн орны парламент хуулийн төслийг нууц санал хураалтаар баталдаг. Зарим парламентад тодорхой тооны гишүүд шаардвал нууцаар санал хурааж болдог. Ливанд 10, Монакод 23 гишүүн санал тавьбал нууцаар санал хураадаг. Туркэд нууц санал хураалт явуулахыг санал болгосон гишүүдийн нэрсийг хуралдааны албан ёсны тэмдэглэлд бичдэг байна. Дээр дурьдсанаас бусад тохиолдолд парламентын шийдвэрийг нээлттэй, ил санал хураах хэлбэрээр баталдаг.

Амаар санал өгөх, гараа өргөж саналаа өгөх, парламентын гишүүд суудлаасаа босох хэлбэрээр саналаа өгөх зэрэг санал хураах арга байна.

Ил санал хураалтын дурьдсан явц муутай болбол саналыг илүү нарийн тоолох боломжтой "нээлттэй" санал хураалтыг хэрэглэдэг. Ийм гурван арга байна.

1. Гишүүд 2 хуваагдаж саналаа өгөх. Энэ аргыг Английн танхимд хэрэглэдэг бөгөөд зөвшөөрч байгаа нь баруун, эсрэг саналтай нь зүүн талд зогсдог. Энэ үед тусгай томилгоосон хүн танхимын гишүүдийн нэрсийг тэмдэглэж дөрвөн тоологч санал хураалтын дүнг гаргадаг. Ил санал хураалтын нэлээд дэлгэрсэн хэлбэр бол нэрээр санал хураах арга юм. Энэ арга нь баруун Европын ихэнх оронд болон АНУ, Турк, Чили, Ливан зэрэг улсад хэрэглэдэг.

2. Санал хураалтын өөр нэг арга бол санал хураах хуудсаар санал өгөх арга юм. Парламентын гишүүдэд нэрийг нь бичсэн өнгө бүрийн саналын хуудас тараахад тэд бэлтгэсэн тусгай хайрцаг руу хийнэ. Дүнг шахилгаан тоолуураар гаргадаг.

3. Эцэст нь шахилгаан ба шахим тооцоолуурын тусламжтайгаар санал хураах арга байдаг. Энэ аргыг Аргентин, Бельги, Энэтхэг, Финланд, Швед, Францын парламентад хэрэглэдэг.

Ихэнх орнуудад хуулийн төслийн төлөө санал тэнцүү болбол тэрхүү төслийг хүчин төгөлдөр бусад тооцдог. Харин Швед, Финланд зэрэг зарим

оронд хуулийн төслийн хувь заяаг энэ тохиолдолд сугалаагаар шийдвэрлэдэг байна.

Монгол Улсын Их Хурлын гишүүн хуулийн төслийг батлахдаа "зөвшөөрсөн", "татгалзсан" гэсэн 2 саналын аль нэгийг өгнө.

Хуулийн эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулсны дараа 72 цагийн дотор түүнийг ёсчилно. Ёсчилно гэдэг ойлголтонд хууль, Улсын Их Хурлын шийдвэрт дээр дурьдсан найруулгын засваруудыг оруулж, "Монгол Улсын хууль" гэсэн албан ёсны хэвлэмэл хуудсан дээр бичиж, бүх алдааг хянаж, улмаар Улсын Их Хурлын даргаар гарын үсэг зуруулж тамга даруулна. Гагцхүү ингэж ёсчлогдсон баримт бичиг, хуулийн албан ёсны эх болох бөгөөд түүнээс хийгдсэн хуулбарыг сонин хэвлэлд нийтэлдэг. Энэ нь эрх зүйн маргаантай асуудал шийдэх хууль ёсны эх сурвалж болно.

Хууль, Улсын Их Хурлын шийдвэрийг ёсчлогдсоноос хойш 24 цагийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчид илгээн Ерөнхийлөгч түүнийг хүлээн авснаас хойш ажлын таван хоногийн дотор уг хууль, шийдвэрт хориг тавих эсэхээ шийдвэрлэнэ. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Ерөнхийлөгч хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт хориг тавих эрхтэй. Ерөнхийлөгчийн хориг нь хууль тогтоох засаглалд гүйцэтгэх засаглалын зүгээс тавьж буй хяналтын хэлбэр юм. Ерөнхийлөгчийн засаглалтай улсад хуулийг Ерөнхийлөгч заавал батламжилдаг тул энэ үе шатыг тусад нь бие даасан үе шат болгон авч үздэг онцлогтой.

Манай улсад Ерөнхийлөгч хуульд зөвхөн хориг тавих эрхтэй байдаг. Хориг тавьсан тохиолдолд уг хууль шийдвэрийн биелэлтийг Улсын Их Хурлаар хоригийг хэлэлцэж шийдвэрлэх хүртэл түр зогсооно. Хоригийг хэлэлцээд Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёр нь түүнийг хүлээн аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

Гадаад орнуудын Үндсэн хуулиар төрийн тэргүүн парламентаар хэлэлцэгдсэн бүх хуулийн төслийг батлах албагүй, "үүрэггүй" байдаг байна. Төрийн тэргүүн хуулийн төслийг батлахаас татгалзах буюу хүчингүй болгох эрхийг "хориг тавих эрх" гэнэ. Хоригийг туйлын буюу хойшлуулсан хориг гэж хувааж үздэг. Туйлын хориг гэж төрийн тэргүүн хуулийн төслийг батлахаас татгалзсанаар бүр эцсийн шийдвэр гарч төслөөс татгалзсан шинэжтэй хориг юм. Харин хойшлуулсан хориг гэж хэрвээ төрийн тэргүүн хориг тавибал парламентад төслийг дахин хянан хэлэлцүүлэхээр буцаан өгдөг ба энэ үед Үндсэн хуулинд заасны дагуу төрийн тэргүүний баталгаагүйгээр төсөл хууль болдог байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулахаар төслийг өгснөөс хойш ажлын 5 хоногийн дотор буцаагаагүй бол Ерөнхийлөгчийг зөвшөөрсөнд тооцон хууль хүчин төгөлдөр болно.

Төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлаас баталсан хуулийг албан ёсны хэвлэлд даруй нийтэлж бүх байгууллага, иргэдийн

сонорт хүргүүлэх ажиллагаа хуулийг батлагдсаны дараа хийгддэг. Аливаа хуулийг чанд сахин биелүүлэх явдлыг хангахын тулд юуны өмнө түүний гүйцэтгэгчид хүргүүлсэн байх ёстой. Хууль нь хүчин төгөлдөр болсон хугацаанаас хууль зүйн хүчин чадлаа алдах хүртэл хугацаанд үйлчилдэг.

Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 3-г: "Монгол улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол нийхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно" гэж заажээ. Хуулийг хэвлэн нийтлэх явдлыг түүний хүчин төгөлдөр болох хугацаатай уялдуулснаар тухайн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө агуулгыг нь олон нийтэд мэдэгдсэн байх явдал юм. Энэ нь хууль цаазат төрийг бүрхэдүүлж төгөлдөржүүлэхийн төлөө зорилт тавьж байгаа манай оронд хувьд том алхам бөгөөд төр нь иргэдээс хуулийг мэдэж, ухамсартайгаар биелүүлэхийг, харин иргэд төрөөс нэгэнт батлагдсан хуультай урьдчилан шуурхай танилцах боломжийг бүрдүүлэхийг шаардах харилцан эрх, үүргээр нөхцөлдөж байдаг.

Хууль хүчин төгөлдөр болох 3 үндсэн хугацаа байдаг. Үүнд:

1. Хууль батлагдмагц
2. Хуульд заасан тодорхой хугацааны дараа
3. Төрийн хэвлэлд нийтлэгдсэн өдрөөс хойш арав хоног өнгөрснөөр хүчин төгөлдөр болох.

Хууль хүчин төгөлдөр болох хугацааг тухайн хуулийн зохицуулалтын өндөргөөс шалтгаан дээрхи хугацааны аль нэгийг хууль тогтоогчоос зааж өгдөг. Жишээ нь Нэмэгдсэн ортгийн албан татварын хуулийг 1998 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр уг хуульд шууд зааж өгсөн байна. Хууль хүчин төгөлдөр болох хугацааг ингэж зааж өгч байгаа нь тухайн хуулийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах, түүнийг дагаж мөрдөх бэлтгэл нөхцлийг хангуулах, хуулийг дагаж мөрдөхтэй холбоотой зорчилдоомыг бий болгохгүй байх чухал ач холбогдолтой.

Тэгвэл нийгмийн харилцааны янд дунд тухайн хууль нийгмийн харилцааг үргэлжлүүлэн зохицуулах боломжтой нөхцөлд хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг төрийн албан ёсны хууль тогтоомжийг нийтлэх зорилго бүхий хэвлэл "Төрийн мэдээлэл" сэтгүүлд нийтлэгдсэн өдрөөс хойш арав хоног өнгөрөөд хүчин төгөлдөр үйлчлэх болсонд тооцно.

Хуулийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг доорхи аргаар дуусгавар болгодог.

1. Хууль тогтоох байгууллагаас хүчингүй болгосон хууль гарсан.
2. Уг хуулийг орлохуйц өөр хууль батлагдаж гарсан тохиолдолд тус тус хүчингүй болно.

Хууль бүтээх үйл ажиллагааны сүүлийн шат нь хуулийг системчлэх үе шат юм. Хуулийг системчлэх гэдэг нь хүчин төгөлдөр үйлчилж буй аргуудыг үр ашигтай хэрэглэх, хүрч ашиглах зорилгоор хууль тогтоогчоос тэдгээрийг нэгдсэн системд оруулж, журамлах үйл ажиллагааг хэлнэ. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндэс нөхцөл нь эрх зүйн систем, түүний салбар, хэд институтыг мэдэж байх явдал юм. Хууль тогтоомжийг системчлэх нь: эрх зүйн хэм

хэмжээний актыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай олж ашиглах шинжийг хангах хуулийг цэгцтэй системийг бий болгох, хуучирч үр нөлөөгүй болсон актыг хүчингүй болгох, хуулийн хийдлийг арилгах, хоорондын зөрчилдөөнийг нь шийдвэрлэх, шинэчлэн баяжуулах зорилготой.

**ХУУЛЬ БҮТЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН
БАЙДАЛ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ**
(Дипломын ажлаас)

Давааньямын ОЮУМАА

Хууль зүйн ухааны магистр

Хууль бүтээх үйл ажиллагааны үр дүнд бүтсэн хуулиуд нь улс орны нийгмийн хөгжлийн тулгамдсан эрэлт хэрэгцээг цаг тухайд нь соргоогоор тусгасны үндсэн дээр нийт ард түмний эрх ашиг, хүсэл сонирхлыг дээд зэргээр илэрхийлэх үүрэгтэй байдаг. Иймээс эрх зүйт төрийн нэг үндсэн шинж болох нийгмийн гол гол харилцааг хуулиар зохицуулах өөрөөр хэлбэл нийгэмд төрийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ дан ганц хуулийг баримтлан ажиллах шаардлагаас үүдэн нийгмийн харилцааны олон талыг нэг бүрчлэн хуульчлах шаардлага гарч ирдэг.

Төрөөс нийгмийг удирдах үндсэн арга, түүнийг хэрэгжүүлэх хэлбэр нь хууль бүтээх үйл ажиллагаа бөгөөд энэ нь хууль болон эрх зүйн хэм хэмжээ тогтоож түүнийг гүйцэтгэлийг хангах үйл ажиллагаагаар илэрч байдаг. Нийгмийн харилцааг зохицуулах эрх зүйн хэм хэмжээнд тэргүүлэх байр эзэлдэг хуулийг боловсруулж бэлтгэж баталж гаргах ажиллагааг үндсэнд нь хууль бүтээх үйл ажиллагаа гэнэ.

Хууль бүтээх үйл ажиллагаа нь хэд хэдэн тодорхой үе, үе нь дотроо хэд хэдэн шатыг дамжин хэрэгждэг. Үүнд:

1. Төслийг бэлэн болгох үе:

- 1.1 Хуулийн төслийн хэрэгцээг тодорхойлох буюу төлөвлөлтийн шат
- 1.2 Төслөө бичиж бэлэн болгох шат
- 1.3 Мэргэжлийн олон нийтээр хэлэлцүүлэх зөвшилцөх шат
- 1.4 Эцсийн буюу гүйцээн боловсруулалт хийх шат
- 1.5 Төслийг өргөн мэдүүлэх шат

2. Төслийг хэлэлцэн батлах үе шат

- 2.1 Хуулийн төслийг хэлэлцэх шат
 - А. Анхны хэлэлцүүлэг
 - Б. 2 дахь буюу дараа дараагийн хэлэлцүүлгийн шат
- 2.2 Хуулийг батлах шат
- 2.3 Хууль ёсчлох болон Ерөнхийлөгчийн хориг тавих бүрэн эрхийг хэрэгжүүлэх шат
- 2.4 Хуулийг хэвлэн нийтлэх шат
- 2.5 Хууль системчлэх шат

Хуулийн төслийг хууль цаазын хэлбэрт оруулах, хуулийг батлан гаргах, цаашид эмхлэн нэгцлэх, улам боловсронгуй болгоход хууль зүйн тусгай журам, арга, хэргэслүүд ашиглагдана. Эдгээр нь бүхэлдээ хууль зүйн техникийг бүрдүүлдэг.

Хууль тогтоомж буюу эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт өөрөө авчдаг гарч ирдэггүй. Энэ нь маш нарийн чанд уйтгагүй хөдөлмөр, нягт нямбай ажиллагаа, төрийн байгууллагуудын идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд бий болдог. Хууль бүтээх үйл ажиллагааны гол субъект нь мэдээж төрийн байгууллагууд байдаг ч иргэд, аж ахуйн нэгж байгууллага, тэдгээрийн албан тушаалтан, мэргэжилтнүүд, олон нийтийн байгууллагуудын оролцоотой бүтдэг. Түүнчлэн нийт ард түмэн төрийн төлөөллийн байгууллагууд (парламент)-аар дамжуулан хууль бүтээх үйл ажиллагаанд оролцдог. Энэ утгаараа хууль бол угтаа нийт ард түмний бүтээл юм.

Монгол улс байнгын үйл ажиллагаатай парламенттай болсноор хууль тогтоох үйл ажиллагаа нарийн журмын дагуу явагдах болсон юм. Ингэснээр манай улсад хууль тогтоох эрх мэдлийг хэд хэдэн байгууллага дундаа хадгалж байсан олон жилийн тэжээлд арилан Үндсэн хуулийн дагуу тус улсад анх удаа бүх ард түмнээс сонгогдож тэдний хүсэл зориг, ашиг сонирхлыг илэрхийлсэн, байнгын ажиллагаатай, хууль тогтоох бүрэн эрхийг дангаар хэрэгжүүлэх дээхий нийтийн жишигт дүйцсэн парламент-Улсын Их Хурал бий болсон. Хуулийн төслийг хэлэлцэж батлах үйл ажиллагаа Улсын бага хурлын үед чуулганы хуралдааны дэсээр зохицуулагдаж байсан бол өнөөдөр Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын хуралдааны дэсний тухай хууль, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулиар тус тус зохицуулагдаж байна. Хууль санаачлагчдын өгсөн үүрэг, чиглэлийн дагуу хуулийн төсөл боловсруулах ажилд төрийн яам, тусгай газрууд, Улсын Их Хурлын болон Ерөнхийдөгчийн тамгын газрууд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар өөр өөрийн чиглэлээр оролцож, хуулийн анхны төслийг бэлтгэж, холбогдох танилцуулга, судалгаа мэдээг гаргадаг. Хуулийн төсөл боловсруулахад холбогдох яам, тусгай газар, эрдэм шинжилгээний болон нам, олон нийтийн байгууллага, мэргэжлийн хүмүүсийн саналыг аль болох өргөнөөр авдаг. Шаардлагатай гэж үзвэл төсөл боловсруулах ажилд мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулна. Хэрэв тухайн хуулиар зохицуулагдах асуудал нийгмийн амьдралын өргөн хүрээг хамарч байвал төслийн талаар сонгогчид, нийт иргэдийн санал авч болно. Ийнхүү олон нийтийн санал судлахдаа иргэд байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, тов, орон нутгийн сонин хэвлэлийн нийтлэл, радио, телевизийн нөвтрүүлгийг анхааралтай судалдаг.

Хууль тогтоох байгууллага шинээр хуулийг торүүлэн гаргахдаа тухайн хуулийн хэрэгцээг тодорхойлох нь хамгаас чухал. Энэ нь хэд хэдэн нөхцлийг хангасан байх ёстой.

1. Нийгэмд хөгжил өөрчлөлт явагдаж, түвшин чанар нь дээшлэхийн хэрээр нийгмийн харилцан шинж төлөв шинэчлэгдэж хувьсана. Иймд нийгмийн амьдралын бүхий л хүрээг сайтар судлах.

2. Ер нь хууль гарснаараа тухайн нийгмийн харилцааг зохицуулна гэдэг. Энэ нь ямар объектыг зохицуулах вэ гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, хэрэгцээ, үйлдвэрлэл, өмч хөрөнгө, эрх мэдэл, үүрэг хариуцлага гэх мэт иргэд хоорондоо харилцах сэтгүүрүүд байх юм. Нийгэм өөрчлөгдөн хувьсахын хирээр эдгээр нь өөрчлөгдөн хувьсах нь зүй ёсны асуудал учраас одоо байгаа хууль нь тэдгээр харилцааг зохицуулах чадваргүй, хангалтгүй болно гэж үзвэл шинээр хууль гаргах шаардлага бий болно.
3. Хууль гарснаар хэнд үйлчлэх вэ? гэсэн асуудал тавигдана. Энэ бол хуулийг хэрэглэгч субъектийн тухай ойлголт юм. Субъектэд иргэд, хувь хүн, нийгмийн бүлэг, төр, нам, төрийн бус байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгж гэх мэт түүнчлэн тодорхой улс үндэстэн, бүс нутгийн улс, олон улсын байгууллага, нийт хүн төрөлхтөн гэх мэт олон арван субъектүүд нь төрийг байгуулж, төр нь хуулийг гаргаж буй зүй тогтол дээр тэдгээрийн боловсрол, улс төр, хууль эрх зүйн мэдлэг нь дэлхий нийтийн түвшнийг даган үргэлж өөрчлөгдөн хувьсах өнөөгийн өндөр шаардлагад нийцэж оршин тогтнохын учир үүнтэй уялдан хуулийн хэрэгцээ ч өөрчлөгдөх нөхцөл болно.¹

Эдгээрээс үндэслэн нийгмийн амьдралын үлэмж олон талтай, ихээхэн нарийн төвөгтэй хэрэгцээ шаардлагыг тусгаж гарсан хуулиуд нийгмийн харилцаанд үйлчлэх явцдаа засварлагдах, өөрчлөгдөх, бүр шинэ хуулийг төрүүлэх зэргээр үргэлж боловсронгуй болно. Хуулийн хэрэгцээг тодорхойлохын тулд шинжлэх ухааны үндэслэл сайтай судалгаа, мэдээллийг хууль тогтоогчид маань сайтар ашиглах ёстой юм. Нэгэнт хууль амьдралаас төрж түүнд үйлчилдэг нь үнэн юм бол амьдралаа дээд зэргээр судлах мэдэх нь чухал. Хууль нийгмийн амьдралаас төрж гарахын зэргэцээ нийгмийн боловсронгуй бийн харилцааг сайн боловсрсон хуулиар жолоодон хөгжүүлж болно. Энд ялгаж зааглах нэг чухал асуудал, тухайлбал урьд өмнө мөрдөгдөж ирсэн хуулийг боловсронгуй болгох асуудал бий. Юу гэвэл батлагдаж гарсан хууль нийгмийн амьдралын өөрчлөх зохицуулах аргагүй тийм бодит харилцааны дэвшилт чиг хандлагатай зөрчилдөөд байна уу? Эсвэл нэгэнт үзэж онгороож нийгмийн дэвшлийг саатуулж буй тийм согог хоцрогдолтой зөрчилдөөд байна уу? гэдгийг нь ялгаж зааглах ёстой. Энэ бол судалгаа мэдээллийн хамгийн чухал зангилаа мөн. Үүнийг хууль тогтоогчид сайн бодолцох ёстой юм. Гэхдээ цаг үеийн шаардлага нэрээр дутуу дулимаг хууль гаргаад түүнийгээ хэрэгжж ч амжаагүй байхад ойр ойрхон нэмэлт өөрчлөлт оруулах, засварлах, эсвэл ирээдүйд улс орны эдийн засагт нэмэртэй нэрээр цагаа олоогүй, иргэд хүлээж авах, ойлгох чадваргүй, эсхүл үндэсний аюулгүй байдалд харшлах хуулийг гарган удалгүй хүчингүй болгох нь Улсын Их Хурлын ажлын дутагдал гэхээс өөр яалтай бишээ. Гэхдээ ямар ч хуулинд тодорхой цаг үе, тодорхой хүрээнд үйлчлээд хүчингүй болж өөрчлөгдөх заалтууд орж болно гэдгийг үгүйсгэж болохгүй юм.

Хууль амьдралын холбоо оновчтой байхад хууль санаачлагчид онцгой үүрэгтэй. Нийгмийн харилцааны өөр бусад бүх субъект хууль санаачлахтай

¹ Г.Мунуубазар Нийгмийн харилцаа ба төрийн хуулийн уялдаа холбооны эрх зүйн философиин зарим асуудал* Шинэ толь сэтгүүл 1998 оны дугаар 4, хуудас 60

холбогдсон санал бодлоо зөвхөн хуулиар хууль санаачлах эрх бүхий субъектээр дамжуулан уламжлах боломжтой. Ийм нөхцөлд хууль санаачлагчид нь санаачилж буй хуулийнхаа төсөлтэй холбогдох бүх төрлийн судалгаа мэдээлэл, давлагаа санал зэргийг нэгтгэн зохион байгуулж төсөлд тусгах асуудлыг хууль батлагдах технологийн дамжлагын бүх шатанд хариуцах болно.

Хуулийн хэрэгцээг урьдчилан тодорхойлох нь хэд хэдэн ач холбогдолтой гэж судлаачид үзэж байна. Үүнд:

1. Хуулийн төслийг чанартай боловсруулахад
2. Нийгмийн сэтгэл зүйн уур амьсгалыг урьдчилан төлөвшүүлдэхэд
3. Хуулийн төсөлд шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлж улсын төсөлд тусгах
4. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах зэрэг болно.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажил нь тухайн ажиллагааг явуулахад баримтлах өөрийн гэсэн үндсэн зарчимтай байна. Энэ зарчмуудад: Хууль ёсны байх, ил тод байх, шийжлэх ухааны үндэслэлтэй байх, нийгэм, төр, иргэдийн нийтлэг хэрэгцээ, ашиг сонирхлыг харгалзан үзэх зарчмууд орно. Түүнчлэн шударга ёс, ардчилсан ёс, энэрэнгүй ёсны зэрэг түгээмэл зарчмуудыг удирдлага болгон үйл ажиллагаа явуулах ёстой.

Хууль ёсны зарчим: Үндсэн хуульд нийцсэн байх, хуулиуд хоорондоо зөрчилгүй байх, хууль дотооддоо зөрчилгүй байх, хууль бүтээх үйл ажиллагаа хуулийн хүрээнд явагдах зэргээс үүдэн гарна.

Ил тод байх: Хууль тогтоомж хүртээмжтэй байж аль болох олон нийтийн санаа бодлод тулгуурласан тэдний хүсэл зорилт нийцсэн байхын зэрэгцээ олон түмэн түүнийг мэдэж үйл ажиллагааныхаа нэг гол чиг баримжаа болгож байх зэргээс үүдэн гарна.

Шийжлэх ухааны үндэслэлтэй байх: Зохицуулах гэж буй тухайн нийгмийн харилцааг сайтар судалсан байх, бусад орны туршлага хуулийн практикийг судалсан байх, мөн олон талт нарийн судалгаанд үндэслэсэн байх явдал юм.

Бодитой байх зарчим: Хууль эрх зүйн хэм хэмжээ нь тухайн түүхэн цаг үеийн объектив шаардлагыг зохиистойгоор тусгасан байх учиртай. Хууль тогтоомж нь цаг үеэсээ хэт түрүүлэх буюу хэт хоцорч гарах нь нийгмийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг.

Нийгэм, төр, иргэдийн нийтлэг хэрэгцээ, ашиг сонирхлыг харгалзан үзэх зарчим: Тухайн хэм хэмжээ нь нийгэмд бүхэлд нь үйлчлэн нөлөөлдөг учраас үндэсний аюулгүй байдал, үндэстэн ард түмний нийтлэг эрх ашгийг заавал тусгах ёстой. Үндэсний эрх ашгийг зөрчсөн хууль гарвал тэр нь эргээд эрх зүйн мөн чанарт харшлах эрх зүйг (хууль тогтоомжийг) бүтээх үйл явц нь төрийн үйл ажиллагаанд ч нөлөөлдөг. Мөн түүнчлэн салбарын эсхүл аль нэг байгууллага, хэсэг бүлэг хүмүүсийн явцуу эрх ашигт илт захирагдсан хууль гарч байгаа нь нийтлэг эрх ашигтай нийцэх ёстой гэдэг зарчимтай харилцдаг. Төрөөс эрх зүйн хэм хэмжээг тогтоохдоо нийгмийн харилцааны

зохицуулалтыг бий болгодог учраас түүнийг төр нь үйл ажиллагаандаа баримтлах зарчим болгоно.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажил нь хууль тогтоомжийн төсөл боловсруулахыг санаачилсан байх хоёр үндэслэлээр хэрэгжиж эхлэнэ.

Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн нь бүрэн эрхийнхээ дагуу санаачлах хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг хариуцна. Засгийн газар нь бүрэн эрхийнхээ дагуу санаачлах хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг төрийн захиргааны холбогдох төв байгууллагаар дамжуулан хэрэгжүүлдэг. Төрийн захиргааны төв байгууллага нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл, холбогдох төлөвлөгөөний дагуу буюу Засгийн газрын даалгавраар өөрийн үйл ажиллагааны зохих хүрээ, эрхэлсэн салбарт хамаарах асуудлаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг хариуцан зохион байгуулдаг.

Төсөл боловсруулахыг тухайн хууль тогтоомжийг хэрэгжүүлдэг ёстой байгууллага нь боловсруулах, түүнчлэн түүнд холбогдолгүй хөндлөнгийн этгээд боловсруулах гэж хоёр үндсэн ангилалд хувааж болно.

"Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг дараах ээлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:

1. Хуулийн төслийг хууль санаачлагч өөрөө боловсруулах,
2. Холбогдох байгууллагын эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг
3. Хуулийн этгээд, иргэнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлдэг

Мөн хууль тогтоомжийн төслөөр уралдаан зарлаж, сонгон шалгаруулах ээлбэр ч байж болно. Хууль тогтоомжийн төслийг ганц хувилбараар боловсруулах албагүй бөгөөд хэд хэдэн ч хувилбараар хэдэн ч субьект боловсруулж болно. Гэхдээ санаачлагч Улсын Их Хуралд нэг л төсөл өргөн барих ёстой. Төслийг боловсруулахад шинэчлэлийн хэсэг томилж, тухайн салбарт мэргэвсэн эрдэмтэн, мэргэжилтнүүдийг татан оролцуулах, эрдэмтэд болон практикийн ажилтан, олон түмний саналыг авах, гадаад орнуудын туршлагыг судлах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлийг ашиглах, судалгаа явуулах зэргээр аль болох өргөн хүрээтэй тодорхой чиглэсэн зорилготой ажиллагаануудыг хийх хэрэгтэй. Учир нь хууль бүтээх үйл ажиллагаанд хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажиллагаа чухал байр эзлэх бөгөөд түүний чанараас хууль бүтээх үйл ажиллагааны хувь заяа шалтгаална. Төслийг зохих түвшинд, шаардлага хангаж боловсруулснаар хууль бүтээх ажиллагааны дараа дараагийн шатуудад цаг бага тарж шуурхай нийдмэрлэх, улмаар батлагдсан хууль тогтоомж хэрэгжих бодит нохиолыг бүрдүүлдэг.

Хуулийн төсөл нь дараахь нийтлэг шаардлагыг хангасан байх.

Үүнийг Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлдэг журмын тухай Монгол Улсын хуулийн 12 дугаар зүйлд дэлгэрэнгүй зааж өгсөн байдаг. Энэхүү шаардлагын талаар товч тайлбарлая.

1. Үндсэн хуульд нийцсэн, бусад хууль болон Монгол Улсын олон улсын гэрээний заалттай уялдан байх ёстой. Ямар ч хууль Үндсэн хуулийн хүрээнд гарах бөгөөд бусад хуультай харьцуулж орхигдсон харилцааг зохицуулахад чиглэгднэ. Хэрэв уг төсөл бусад хууль, олон улсын гэрээтэй зөрчидөхөөр байвал тэр хуульд нэмэлт өөрчлөлт оруулах эхлэл төслөө түүнд нийцүүлдэг чиглэлийг барина гэсэн үг юм.

2. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг аль болох бүрэн тусгаж тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс халнагүй байвал зохино. Үүний тулд уг хуулиар зохицуулах асуудлын жагсаалт нарийвчлан гаргаж анализ хийх хэрэгтэй юм.
3. Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилдөхгүй байх, хэм хэмжээ тогтоогоогүй тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байвал зүгээр. Зүйл заалт нь давхардсан эсхүл нэг нь нөгөөгөө үгүйсгэх, утга ойлгомжгүй байхаас аль болох зайлсхийвэл зохилтой.
4. Бусад хуулийн заалтыг давхардуулан заалгүйгээр шаардлагатай бол түүнийг иш татах, энэ тохиолдолд иштэлийг тодорхой хийж, хуулийн бүрэн нэрийг заавал заах хэрэгтэй юм.
5. Хуулийн зорилт, тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хамрах хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогчдоос удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл (гипотез), тэдгээрийг биелүүлэх журам, эрх, үүрэг (диспозици), онцгойлон үзэх нөхцөл байдал, эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ зэрэг ойлголтуудыг гарцаагүй тусгах.
6. Шаардлагатай тохиолдолд хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хуулийг дагаж мөрдөх журмын тухай хэм хэмжээ, хууль, хуулийн зүйл, заалтыг хүчингүй болгох, хасах, бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг тусгаж байвал зохино.

Ялангуяа хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг тодорхой судалгаа, бодлогын үндсэн дээр тогтоож баймаар байна.

Өнөөгийн практикаас үзвэл хуулийн төслийг ихэвчлэн уг асуудлыг төрийн өмнө харууцаж төрийн байгууллага боловсруулж байна. Энэ нь зарим талаар сайн боловч хэт өөрийн эрх ашгийг нэрхийлдэг муу талтай. Иймд төслийг сонирхогч бус этгээд боловсруулах нь зүйтэй гэж үздэг. Нэгэнт сонирхогч бус этгээд төсөл боловсруулж байгаа нөхцөлд уг төслийг мэргэжлийн олон нийтээр заавал хэлэлцүүлж, тэдний саналыг авах ёстой. Мэргэжлийн олон нийт гэж сонирхогч этгээдүүд, эрдэм шинжилгээний байгууллагыг хэлдэг байна. Хуулийн төслийг түүний үзэл баримтлалыг үндэслэн боловсруулна. Хууль тогтоомжийн төслийг боловсруулах явцад иргэд, байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, мэргэжлийн хүмүүс, эрдэм шинжилгээний байгууллагыг өргөнөөр татан оролдуулж тэдний санал дүгнэлтийг төсөл боловсруулах эхний үеэс эхлэн байнга авч төсөл боловсруулахад харгалзан үзэх нь зүйтэй.

Төслийг боловсруулах явцад уг хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг боловсруулах ажлын явцыг хууль санаачлагчид байнга танилцуулан удирдаж чиглээ авч ажиллах ёстой. Хууль тогтоомжийн төслийг боловсруулж дуусмагц нам, тусгай газрын болон шаардлагатай тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны саналыг авна. Шаардлагатай гэж үзвэл төсөлд Засгийн газрын бус байгууллагын саналыг авч тусгана. Улс, олон нийтийн болон бусад байгууллага, тэдгээрийн албан тушаалтан, иргэд нь төсөлтэй танилцах, санал өгөх, ажлын хэсэгт орж ажиллах, өөрийн үйл ажиллагааны чиглэлээр судалгаа, тайлан мэдээ, шаардлагатай баримтыг

гаргаж өгөх зэрэг хэлбэрээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажилд оролцоно. Хуулийн төсөл боловсруулагч нь уг хуулиар зохицуулах нийгмийн харилцааг бүрэн дүүрэн мэдэхийн аргагүй байдаг. Төслийг амьдралд нийцүүлэн нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангахын тулд төсөл боловсруулагч шаардлагатай гэж үзвэл хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд тавьж Улсын Их Хурал чуулганаараа хэлэлцэж шийдвэрлэнэ. Мөн хуулийн төслийг нийт ард түмнээр буюу нийгмийн тодорхой бүлэг, ажил мэргэжлийн хүмүүсийн хэмжээнд эсхүл тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд хэлэлцүүлж болно.

Улсын Их Хурал шийдвэртээ төслийг ямар хүрээнд хэлэлцүүлэх болон түүнтэй холбогдон гарах заралыг хэрхэн санхүүжүүлэхийг тодорхой зааж өгдөг. Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай Улсын Их Хурлын шийдвэрийг үндэслэн Засгийн газар хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж, түүний дүнг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх явцад танилцуулна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулдаг. Ард нийтээр төсөл хэлэлцүүлэх ажиллагааг мэдээлэл сурталчилгааны болон бусад олон арга хэлбэрээр зохион байгуулан саналыг авдаг. Жишээ нь: сонинд нийтлэх, радио телевизээр шууд төсөлтэй холбогдсон асуудлаар шууд яриуцлага явуулах, анкетын судалгаа явуулах, эрдэм шинжилгээ, практикийн бага хурал зохион байгуулах зэрэг болно. Хуулийн төслийг мэргэжлийн олон нийтээр хэлэлцүүлэх үед санал зөрөлдөх асуудал гарч ирж болно. Тэгвэл тэдгээр талуудыг хооронд зөвшилцүүлэх, семинар зөвлөлгөөн зохион байгуулах, харилцан буулт хийлгэх, цаашилбал хөндлөнгийн экспертнээ томилох зэрэг хэлбэрээр эцсийн шийдвэрийг хамгийн зөв гаргаж төсөлд тусгах нь чухал юм.

Хуулийн төсөл боловсруулахын өмнө түүний үзэл баримтлалыг тодорхойлно. Энэ нь хуулийн үр нөлөөг дээшлүүлэх чухал хүчин зүйл болж өгдөг.

Хуулийн үзэл баримтлалд дараахь асуудлыг тусгасан байх нь зүйтэй. Тухайн хуулийн үндсэн зорилтыг тодорхойлох, хуулийн эрх зүй, улс төр, эдийн засгийн зорилтыг оновчтой томъёолох нь төслийн бусад асуудлыг тодорхойлох тулгуур үндэслэл болно. Ялангуяа томоохон хуулийн төсөл боловсруулахад ганцхан зорилтоор хязгаарлахгүй байх нь зүйтэй.

А) тухайн хуулийн үндсэн зорилтыг тодорхойлох

Хуулийн эрх зүй, улс төр, эдийн засгийн зорилтыг оновчтой томъёолох нь төслийн бусад асуудлыг тодорхойлох тулгуур үндэслэл болно. Ялангуяа томоохон хуулийн төсөл боловсруулахад ганцхан зорилтоор хязгаарлахгүй байх нь зүйтэй. Юуны өмнө хуулийн үндсэн зорилтыг, дараа нь хоёрдогч шинжтэй бусад зорилтыг томъёолох шаардлагатай. Зорилт тус бүр нь харьцангуй бие даасан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх боловч бүхэлдээ үндсэн зорилтыг хангахад чиглэсэн байна. Нэг хуульд хоорондоо уялдаа муутай хэд хэдэн зорилт тавих нь цэгцтэй хууль гаргах, түүний биелэлтэнд хяналт тавих ажлыг хүндрүүлж, эцэстээ хуулийн үр нөлөөг бууруулахад хүргэж болзошгүйг анхаарах нь зүйтэй. Хуулийн төсөлд тусгагдаж буй зорилт хоорондоо нягт уялдсан, бие биеэ үгүйсгээгүй, харьцаат тэнцэл нь зөв тогтоогдсон байвал зохино.

Б) хууль гаргах шаардлага, үндэслэлийг заах

Хуулийн зорилтыг оновчтой тодорхойлох нь хууль гаргах шаардлага, үндэслэлийг зөв томъёолох чухал хөшүүрэг болно. Хууль гаргах шаардлага, үндэслэлийг тодорхойлохдоо ямар нэг салбар, байгууллага, хувь хүний үзэл бодлын үүднээс биш, нийгмийн хөгжил, шаардлагаар урган гарсан асуудлыг онол, практикийн талаас үндэслэх ёстой. Хуулийн төсөл бэлтгэх эдийн засаг, улс төрийн учир шалтгаан нь эрх зүйн шинжтэй шалтгаантай олонхи тохиолдолд нягт холбоотой байна. Жишээ нь: Шинэ Үндсэн хууль батлагдсаны дараа бүх хуулийг түүнд нийцүүлэн шинэчлэх шаардлага зүй ёсоор гарсан. Хууль гаргах шалтгааныг үндэслэхдээ заавал шинэ хууль гаргах бус үйлчилж байгаа хуулийг үр дүнтэй хэрэглэх, түүнд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль хэрэглэх тайлбар гаргах, хууль хэрэгжүүлэх явдлыг сайжруулахаар бусад арга хэмжээ авах зэргээр эрх зүйн бусад арга хэрэгслийн тусламжтайгаар асуудлыг шийдвэрлэх боломж байгаа эсэхийг онцгой анхаарвал зохино.

В) Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох.

Хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг зохих эс үүсвэрээр нь эртнээс нарийн тооцож төлөвлөхгүй бол тэр нь хуулийн хэрэгжилт, үр нөлөөнд муугаар нөлөөлдөг тул түүнийг тооцоо судалгаагүйгээр бүдүүн тоймоор гаргаж болохгүй. Тодорхой зардлыг тооцож гаргах нь бэрхшээлтэй байх боломж түүнийг зөв тооцоолохын тулд байгаа бүхий л арга хэрэгсэл, бололцоог ашиглах хэрэгтэй.

Энэхүү зардлын тооцоо судалгаа гаргахдаа мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу зарцуулж байгаа нийт хөрөнгийн хэмжээ, хамрагдаж буй хүний тоог асуудлын төрлөөр тооцоохын хамт улсын төсвөөс гаргаж байгаа болон үйлдвэрийн газар, байгууллагын хөрөнгөөс зарцуулж байгаа хөрөнгийн хэмжээг сүүлийн жилүүдээр нарийвчлан тооцож зохих дүгнэлт хийх, түүнчлэн хуулийг хэрэгжүүлэхэд нэмж шаардагдах хөрөнгийн хэмжээ, хамрагдах хүний тоог хуулийн зүйл тус бүр дээр тооцож, түүнийг нөхөх эх үүсвэр, улсын төсвөөс гаргах хөрөнгийн хэмжээг тодорхойлсон байх гэх мэт.

Г) Хуулийн зэрэг, сөрөг үр дагаврыг урьдчилан тодорхойлох

Шинжлэх ухааны онол, мэргэжлийн хүмүүс, статистикийн болон шинжлэх ухаан-техникийн мэдээллийн албадын тусалцаанд тулгуурлан тухайн хуулийг хэрэгжүүлснээр гарах зэрэг, сөрөг үр дагаврыг үзэл баримтлалд тусгасан байх шаардлагатай. Түүнчлэн тухайн хуулийн талаархи өөр санал, сонирхогч байгууллагуудын үзэл, байр суурийг харьцуулан гаргах нь зүйтэй. Энэ нь бодит үзэвгийг тогтооход мэтгэлзлэх зарчим хэрэгжих нэг гол нөхцөл юм.

Д) хуулийн төслийн зарчмын заалтуудыг боловсруулах

Энэ шатанд юуны өмнө хуулийг төслийн бүтцийг урьдчилан тогтооно. Бүтцийг тогтооходоо ерөнхийгөөс тусгай руу шилжих чиглэлийг барих бөгөөд тэгэхдээ түүний хамгийн ерөнхий бүтцийг эхэлж гаргана. Хуулийн зорилтыг хамгийн үр дүнтэй хэрэгжүүлэхэд эрх зүйн тодорхой арга хэмжээг төсөөлөн төлөвлөж, оновчтой, гол чиг шугамыг боловсруулсан байх шаардлагатай. Жишээ нь: - хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд хариуцлагыг голлох уу, өөр арга хэрэгслийг гол болгох уу гэдгийг тогтоох хэрэгтэй. Гэхдээ хэт загварчилж, нэг талыг барьсан өрөөсгөл хандлага гаргахгүй байхад анхаарвал зохино.

Е) Хуулийн хэрэгжилт, үр нөлөөг хангах арга хэрэгслийг урьдчилан тооцох нь түүний үзэл баримтлал бэлтгэх шатанд анхааран шийдвэрлэх асуудал юм. Тунхагласан, уриалсан, тодорхой бус заалттай, хариуцлагын болон шаардлагатай бусад арга хэрэгслийг тусгаагүй хууль хэрэгжих баталгаа муутай байдаг. Иймд хуулийн үзэл баримтлалд түүний биелэлтийг хянан шалгах арга хэрэгсэл, зөрчил гаргагчдад хүлээлтгэх хариуцлага, уг арга хэмжээг хүлээлтгэх байгууллага, албан тушаалтан, журмыг зааж эрх хэмжээг нь тогтоох шаардлагатай.

Нөхцөл байдлаас шалтгаалан хуулийн биелэлтийг хангах арга хэрэгслийг тухайн хууль, заримыг бусад нийтлэг хуульд (тухайлбал Эрүүийн хуульд) эсхүл уг хуулийн дагуу гарах эрх зүйн бусад баримт бичигт тусгаж болох юм. Хариуцлагыг хуулийн биелэлт хангах ганц арга хэрэгсэл гэж үзэж болохгүй. Хариуцлага нь эрх зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг хангах олон арга хэрэгслийн зөвхөн нэг нь юм. Түүнээс гадна эдийн засаг, зохион байгуулалт, эрх зүй, ёс суртахууны (хяналт шалгалт, гомдол гаргах, маргаан хянан шийдвэрлэх зэрэг) аргууд байдгийг анхааран үзэж аль үр нөлөөтэйг нь сонгож авах хэрэгтэй. Зарим хуулийн биелэлтийг хангах арга хэрэгслийг бие даан хэсэг, бүлэг болгон хуулийн бүтцэд тусгаж болно.

Ё) Тухайн хууль болон бусад хууль, эрх зүйн акттай хэрхэн уялдах, хууль тогтоомжийн нэгдсэн системд ямар байр эзлэхийг тодорхойлох нь хуулийн үзэл баримтлалыг шинэжлэх ухааны үндэстэй хийх нэг чухал нөхцөл юм. Энд тухайн хуулийн төсөл бусад хууль тогтоомж, олон улсын гэрээтэй хэрхэн уялдаж байгаа, хуулийг хэрэгжүүлэхийн тулд эрх зүйн ямар баримт бичгийг аль байгууллага боловсруулж гаргах шаардлагатай зэргийг тодруулсан байх шаардлагатай.

Хуулийн үзэл баримтлалыг хууль бэлтгэх ажлыг шууд хариуцан зохион байуулж байгаа байгууллага (ажлын хэсэг) боловсруулна. Эрдэм шинжилгээний байгууллага, хувь хүнтэй гэрээ байгуулах замаар буюу тэдгээртэй хамтран хуулийн үзэл баримтлал бэлтгэх нь үр дүнтэй байдаг.

ХУУЛЬ БҮТЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЕХНИКНИЙН ЭНГИЙН ДҮРМУҮД

РОЛЬФ КНИПЕР-ВЛАДИМИР НАЗАРЯН

“Очерки к проблеме законодательной техники”

бүтээлээс орлуулсан *магистронт Насанжаргалын ЭНХСАЙХАН*

Нэгдүгээр бүлэг: *Хэм хэмжээ тогтоосон эрх зүйн баримт бичгийг албан ёсоор батлах*

1. Хууль бүтээх үйл ажиллагааны техникийн тухай өндөрлөлт Хууль тогтоох үйл ажиллагааны үр дүнд нийтээр датаж мөрдөгдөх хүчин чадалтай болж, зохицуулах гэж буй нийгмийн харилцаагаа хамарч чадсан эрх зүйн хэм хэмжээ бүхий баримт бичиг нь цаг үе, нөхцөл байдалд нийцсэн, тодорхой, ойлгомжтой байх швэжийг агуулсан байх учиртай.

Хууль бүтээх үйл ажиллагааны техник нь хуулийн төсөл болон бусад эрх зүйн хэм хэмжээ тогтоосон баримт бичиг, түүний төслийг бүтэц, хэлбэрийн хувьд өмнө дурьдсан шаардлагад нийцүүдэх зорилго бүхий боловсруулалтын арга, арга барил, аргачлалуудын бүрдэлээс тогтдог.

Хууль бүтээх үйл ажиллагааны техникийн бүрдэлдхүүн хэсгүүд:

1. Хэм хэмжээ тогтоосон баримт бичгийн төслийг бүрдүүдэх аргачлал
2. Хэм хэмжээ тогтоосон баримт бичгийн төслийг засах, өөрчлөх, нэмэлт оруулах горим
3. Хэм хэмжээ тогтоосон баримт бичгийн төслийг ийм баримт бичгүүдийг нэгтгэх арга барил, түүнийг хэлбэрийг бүрэн болон хэсэгчлэн хүчингүй болгох
4. Хэм хэмжээ тогтоосон баримт бичгийн төслийг зүйл, хэсэг бүрд хууль тогтоогчийн бодол санааг төгс тогтоодор илтгэн харуулах арга, аргачлал, арга барил
5. Хэм хэмжээ тогтоосон баримт бичгийн төслийг бүтцийг тодорхойлох арга, агуулгыг төгс илэрхийлэх байдал
6. Хэм хэмжээ тогтоосон баримт бичгийн төслийг хэл зүйн дүрэм, тухайлбал, хууль зүйн нэр томъёог шингэх
7. Хэм хэмжээ тогтоосон баримт бичгийн төслийг хөрвүүлэхэд тавигдах шаардлагууд

2. Хууль бүтээх техникийн учир хэлбэрдэл: Хууль бүтээх үйл ажиллагааны техник, түүний хөгжлийн түвшин нь хууль тогтоомжийн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдралд үйлчлэх нөлөөллийг тодорхойлоход онцгой ач холбогдолтой байдаг.

Хууль бүтээх үйл ажиллагааны техникт тавигдах шаардлагуудыг хэлбэрэлтгүй салхи мөрдөх явдал нь эрх зүйн зохицуулалтын механизм

хөгжид, төгс төгөөдөр болохтой уялдан, хууль болон эрх зүйн дэг журмыг тус улсын хэмжээнд хамгийн дээд хүчин чадалтай гэдгийг батлах хууль тогтоогчийн хүсэл эрмэлзлэлийн нэрхийлтэд болно.

Хууль бүтээх үйл ажиллагааны техникийн өнөөгийн түвшин нь хууль тогтоомжийн төгс чанар, хууль, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад баримт бичгийн агуулгын ойлгомжтой тодорхой байдал, тэдгээрийг хууль тогтоогчийн хүсэл зоригт бүрэн нийцсэн зэргийн баталгаа болдог.

3. Эрх зүйн хэм хэмжээ тогтоосон баримт бичгийн төслийг (цаашид төсөл гэж) боловсруулах үед гарч болзошгүй нийтлэг алдаанууд:

- төсөл нь нэр томъёоны хувьд нэгдмэл биш байх, тодорхой бус, ойлгомжгүй нэр томъёо ашиглах,
- төсөл нь дотооддоо болон хүчин төгөлдөр бусад эрх зүйн хэм хэмжээний тогтоосон эрх зүйн баримт бичигтэй зохицуулах нийгмийн харилцааны хувьд адил хэрнээ харилцан холбоогүй байх, эсхүл бие биетэйгээ зөрчилдөх,
- тодорхой асуудлын талаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид дүн шинжилгээ, тооцоо судалгаа хангалттай хийгээгүйгээс гарах алдаа,
- үйлчилж байгаа хэм хэмжээнд нэмэлт өөрчлөлт хийхийн оронд уг харилцааг давахар зохицуулсан шинэ эрхзүйн баримт бичиг батлан гаргаснаас бий болох алдаа,
- өргөн агуулга бүхий асуудлыг зохицуулахаар түүний агуулгад үл тохирох явцуу, салбарын эрх ашгийг хамарсан чухамдаа "жижиг хүрээний" эрх зүйн баримт бичиг гаргаснаас бий болох алдаа,
- нэг асуудлыг зохицуулахаар хэд хэдэн эрх зүйн баримт бичиг батлах, эсхүл нэг эрх зүйн баримт бичигт тодорхой нэг асуудлыг дахин дахин дурдаж, нурунсан байх,

4. Эрх зүйн баримт бичгийн төсөлд төлөгдөх үндсэн шаардлагаууд:

- Эрх зүйн зохицуулалт нь тодорхой, ойлгомжтой байх ёстой, Хийсвэр, ерөнхий байдлаар тогтоосон хэм хэмжээ бүхий эрх зүйн баримт бичгийг ойлгож хэрэглэхэд түвэгтэй болно,
- Эрх зүйн баримт бичгийн бүлэг, зүйл хэсгүүдийн агуулга, найруулга, утга санааны уялдаа холбоо, логик дэс дарааллыг хатуу баримтална.
- Хууль тогтоомжийн систем болон бусад эрх зүйн баримт бичүүдтэй зөрчилдөхгүй байх,
- Эрх зүйн зохицуулалтын хүрээнд ач холбогдлоо алдаж яваа эрх зүйн хэм хэмжээтэй агуулгын хувьд адил, эсхүл хэлбэрийн төдий үйлчлэх хэм хэмжээ батлан гаргахнаас татгалзах,
- Эрх зүйн баримт бичгийн үг хэллэг нийтэд ойлгомжтой, тодорхой байх. Хуулийг зөвхөн хуульчид, судлаачдад биш нийгмийн гишүүн бүрт ойлгомжтой байдлаар тогтоох нь зүйтэй.
- Эрх зүйн баримт бичгийн агуулгад нэр томъёо нь тохирсон, ойлгомжтой, тодорхой байх,
- Баримт материал хангалттай байх. Зөвхөн нэг асуудлаар хэд хэдэн эрх зүйн баримт бичигт судалгаа, тооцоо хийсэн байна.

- Хууль бүтээх үйл ажиллагааны техникийн дүрмүүдийг хэлбэрэлтгүй, үр дүнтэй биелүүлэх,
- 5. Эрх зүйн баримт бичгийг албан ёсны болгох:
 - Эрх зүйн баримт бичгийг мэдээлэх, нийтлэх эрх бүхий хуулийн этгээд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хугацаа тодорхой байх,
 - Эрх зүйн баримт бичгийг гадаадад илрэх хэлбэр буюу нэр,(тушаал, зарлиг, хууль гэх мэт) дугаар
 - Батлан гаргаж буй субъект, түүний эрх бүхий этгээдийн гарын үсэг
- 6. Хэм хэмжээний актын нэрд тавигдах шаардлага:
 - Эрх зүйн баримт бичгийн нэр нь эрх зүйн баримт бичгийн зохицуулах нийгмийн харилцааны хүрээ, төрлийг заана.
 - Эрх зүйн баримт бичгийн үйлчлэх хүрээ, хэлбэрийг тодорхойлно.
 - Эрх зүйн баримт бичгийн зохицуулах харилцааны хүрээнд судалгааны баримт материалыг зөв сонгох боломж олгоно.
 - Эрх зүйн баримт бичгийн агуулгыг ойлгож танилцах урьдчилсан шат, төдийгүй хууль тогтоомжийг системчлэх чухал хэрэглүүр болно.
- 7. Хууль тогтоогчийн санаа зориг ба эрх зүйн баримт бичгийн нэрийн харилцаа хэлбоог илэрхийлэх аргууд:
 - Хэрэв хууль тогтоогч улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдралын аль нэг хүрээг бүхэлд нь зохицуулахыг эрмэлзэж байгаа үед эрх зүйн баримт бичгийн нэр нь "... арга хэмжээний тухай..." гэсэн агуулгатай байна.
 - Хэрэв хууль тогтоогч өмнөх зохицуулалтыг өөрчлөн, өөр хэм хэмжээ тогтоож байгаа бол "... өөрчлөх тухай...", "... сайжруулах тухай..." гэж,
 - Хэрэв хууль тогтоогч урьд нь зохицуулалтгүй байсан харилцааг зохицуулахаар шинэ хэм хэмжээ тогтоож байгаа бол "... байгууллагын тухай...", "... зохицуулалтын тухай..." гэж,
 - Хэрэв хууль тогтоогч эрх зүйн зохицуулалтыг зогсоож, эрх зүйн баримт бичгийг хүчингүй болгож байгаа бол "... зогсоох тухай...", "... хүчингүй болгох тухай..." гэх мэтээр,
 - Хэрэв хууль тогтоогч аль нэг байгууллагын эрх зүйн байдлыг тогтоох гэж байгаа бол "... эрх зүйн байдлын тухай...", "... дүрэм..." гэж,
 - Ямар нэг байгууллагыг татан буулгаж байгаа бол "... татан буулгах тухай..." гэж,
 - Хэрэв хууль тогтоогч процессын харилцааг зохицуулах гэж байгаа бол хуулийн нэрийг "... журмын тухай...", "... ажиллагааны тухай..." гэж төгсгөхөөр,
 - Хэрэв эрх зүйн баримт бичигт ямар нэг эрх зүйн зөрчлөлд хүтээлгэх хариуцлагыг тогтоосон, түүнийг хэрэглэх журмыг тодорхойлсон бол "... хариуцлагын тухай...", "... хариуцлагыг чангатгах тухай..." гэж,
 - Эрх зүйн баримт бичгийг шинэчлэн буюу өөрчлөн найруулж буй бол "... батлах тухай...", "... өөрчлөх тухай...", "... нэмэлт оруулах тухай..." гэж,

- Хэрэв хууль тогтоогч ямар нэг асуудалд анхварал хандуулах, сануулахыг эрмэлзэж байгаа бол "... шаардлагын тухай ...", "... сэргийлэх тухай ..." гэж.
- Хэрэв эрх зүйн баримт бичиг нь хуулийн дээд хүчин чадалтай эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангахад чиглэгдэж байгаа бол "... биелүүлэх арга замын тухай ...", "... биелүүлэхтэй холбогдсон арга хэмжээний тухай ..." эсхүл "... дүрэм ...", "... журам ..." гэж тус тус нэрлэнэ.

Эрх зүйн баримт бичгийн нэр нь тодорхой, тохиромжтой, зохицуулах нийгмийн харилцааны төрөл, хүрээг шууд илэрхийлсэн байна. Эрх зүйн баримт бичгийн нэр нь анх уншихад л түүнийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх субъектүүдийг илэрхийлж, агуулгыг тодорхойлсон байх бөгөөд түүнийг тогтоох, хууль зүйн системчлэлийг (кодефикация) хялбаршуулахад чухал ач холбогдолтой.

Эрх зүйн баримт бичиг нь бүлэг, хэсгүүдтэй бол унших, ойлгоход хялбар болгох зорилгоор бүлэг хэсэг бүрд нэр өгч болно.

8. Хэм хэмжээний актын удиртгал хэсэг: Удиртгал хэсэг нь эрх зүйн баримт бичгийн бие даасан, бүрэлдэхүүн хэсэг мөн. Энэ хэсэг нь түүний зорилго, батлан гаргах үндэслэл болсон нийгэм, улс төрийн нөхцөл байдлыг тодорхойлдог төдийгүй бүлэг, хэсгүүдийг хооронд нь холбож өгдөг чухал хэсэг юм.

Хэрэв эрх зүйн баримт бичиг нь нийгмийн харилцааг зохицуулж байгаа бол түүнийг батлан гаргах болсон шалтгаан, зорилгыг "... зорилготой ...", "... зорилго нь оршино ..." гэх мэтчилэн тодорхойлдог.

Бодлогын чанартай асуудлуудыг зохицуулж байгаа эрх зүйн баримт бичгийн удиртгал хэсэгт түүний нийгмийн ач холбогдлыг тодорхойлно.

9. Хэм хэмжээний актын бүрэлдэхүүн хэсгүүд: бүлэг, хэсэг, зүйл, заалт. Эрх зүйн баримт бичгийг бүлэг, зүйл, хэсэгт хуваах нь түүнийг системтэй ойлгож хэрэглэхэд ач холбогдолтой. Ингэхдээ бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулгын хувьд ерөнхийгөөс тусгай руу чиглэх байдлаар бүлэглэх бөгөөд (бүлэг, дэд бүлэг, анги, хэсэг, зүйл, заалт гэх мэтчилэн) нэг бүлэгт хэсэг, зүйл, заалт завал багтах, үүний дараа шинэ бүлэг нээх зарчмыг баримтална.

10. Хуулийн ерөнхий ба тусгай ангш: Хуулийг ерөнхий ба тусгай ангид хувааж үзэх болсон явдал нь хууль бүтээх үйл ажиллагааны техникний том ололт юм. Энэ нь хэм хэмжээнүүдийг нурилах, давтах явдалаас урьдчилан сэргийлээд зогсохгүй зарчмын шинжтэй хэм хэмжээнүүдийг бусад хэм хэмжээнээс зааглах боломжийг олгодог.

Ерөнхий анги нь өөр зүйл заалтаас олон дахин иш татах явдлыг багасгаж, эрх зүйн баримт бичгийн үндсэн агуулга, үйлчлэх хүрээг зөв тодорхойлоход тусална.

Бүх эрх зүйн баримт бичгийг ерөнхий ба тусгай ангид хувааж шаардлагагүй хэдий ч тэдгээрийг зарчмын ач холбогдолтой зүйл, хэсгийг тэдгээрийн эхэн хэсэгт оруулах нь зүйтэй.

11. Хэм хэмжээний актын лавсралт: нь ихэвчлэн:

- өөрчлөгдсөн буюу хүчингүй болсон эрх зүйн баримт бичгийн жагсаалт
- албан тушаалтан, байгууллага, гүйцэтгэх ажил болон бусад зүйлсийн жагсаалт

- тооцооны тариф, таблиц, график, схем
- баримт бичиг, маягтын загвар зэрэг хэлбэртэй байдаг.

12. Хэм хэмжээний актын зүйл заалтууд: Эрх зүйн баримт бичгийн системчлэлд эрх зүйн баримт бичгүүдийн эзлэх байр суурь нь түүний үйлчлэлийн шинжээр нь тодорхойлогдоно.

Эрх зүйн баримт бичгийг зүйлүүдэд хувааж үзэх нь актыг хэрэглэх, тайлбарлах, өөр хэсэгт иш татах, хууль тогтоомжийг системчлэхэд ач холбогдолтой гэж үздэг.

Зүйлүүдэд эрх зүйн хэм хэмжээнүүд агуулагдана.

Эрх зүйн баримт бичигт субъектын зан үйлийг тодорхойлсон хэм хэмжээнээс гадна:

- Эрх зүйн нийтлэг зарчмууд
- Нийгмийн харилцаанд оролцогчид бузуу эрх зүйн субъект
- Аль нэг байгууллагын дотоод бүтэц
- Ямар нэг эрхзүйн ойлголтын агуулга, шинж

Эдгээр нь нийгмийн амьдралыг зохицуулах хэрэгсэл болдог. Иймд эрх зүйн баримт бичигт эрх зүйн хэм хэмжээнээс гадна уриалсан, чилүүлсэн, таниулсан зэрэг нэмэлт шинжтэй, эрх зүйн хэм хэмжээний гол агуулгыг тодорхой болгож, эрх зүйн баримт бичгийн бүрэлдэхүүнд ордог хэсгүүд байдаг.

13. Эрх зүйн баримт бичиг дэх хэм хэмжээний бус байдлууд: Төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан олонхи эрх зүйн баримт бичгүүд нь эрх зүйн хэм хэмжээний ба хэм хэмжээний бус шинжийг агуулсан байдаг.

Тухайн эрх зүйн баримт бичгийг дагаж мөрдөж буй субъект нь тухай бүрд нь аль нь хэм хэмжээний тогтоосон баримт бичиг, аль нь хэм хэмжээний бус буюу индивидуаль шинжтэй байгааг тогтоох ёстой.

Индивидуаль шинжтэй баримт бичиг нь нэг удаа үйлчлэх шинжтэй бөгөөд ихэвчлэн захиргааны эрх зүйн харилцаанд голлон илэрдэг. Энэ тохиолдолд нэг ижил асуудлаар хэд хэдэн эрх зүйн баримт бичиг гаргаж болно.

14. Тодорхой хугацаанд үйлчлэх хүчингүй болох эрх зүйн баримт бичигт байнга үйлчлэх хэм хэмжээг тогтоох явдал нь түүний үйлчлэлд тодорхойгүй байдлыг бай болгоно.

Байнга үйлчлэх хэм хэмжээнүүдийн агуулга, шинж нь өөртөө тодорхой бус хугацаанд нийгмийн амьдралыг зохицуулах агуулгыг илэрхийлэхдэг ч түүнийг агуулж байгаа эрх зүйн баримт бичиг нь тодорхой хугацааны дараа хүчингүй болсноор уг хэм хэмжээ ч мөн адил хүчингүй болоход хүргэнэ. Өөрөөр хэлбэл эдгээр хэм хэмжээнүүдийг нэг дор тогтоосноор хоорондоо зөрчилдөг, байнга үйлчлэх хэм хэмжээний ач холбогдол алдагдана.

Иймд эдгээр хэм хэмжээнүүдийг туслаа эрх зүйн баримт бичгүүдээр батлан гаргах нь зүйтэй. Хэрэв хууль тогтоох байгууллага байнга үйлчлэх хэм хэмжээг, тодорхой хугацаанд үйлчлэх эрх зүйн баримт бичигт тусгах зайлшгүй шаардлага гарвал түүнийг тусгай бүлэг болгон оруулах, мөн байнга үйлчлэх хэм хэмжээ болохыг уг актад тогтоож өгөх учиртай байна.

15. Байнга үйлчлэх эрх зүйн баримт бичигт тодорхой хугацаанд үйлчлэх хэм хэмжээг тогтоож болохгүй. Энэ төрлийн хэм хэмжээг тусдаа эрх зүйн баримт бичгээр тогтоох юмуу эсхүл бие даасан бүлэг болгон оруулж, тодорхой хугацаанд үйлчлэх болохыг зааж өгөх нь зүйтэй байдаг.

18. Хэм хэмжээг тогтоосон баримт бичгийг тайлбарлах: Нэр томъёоны тайлбар буюу тухайн эрх зүйн баримт бичиг дэх нэр томъёог хэрхэн ойлгох тухай хэсэг бол эрх зүйн баримт бичгийн бүтцийн бие даасан элементүүдийн нэг болно.

1920,1930-аад онуудад ихэнх хуульчид эрх зүйн баримт бичгийг хэрэглэхэд дэлгэрэнгүй тайлбар зайлшгүй шаардлагатай гэж үзэж байв. Үүний үр дүнд өнөөгийн үйлчилж байгаа зарим хууль бүрэн тайлбарлагдсан байна. Эрх зүйн баримт бичгийг тайлбарлахдаа бусад ойролцоо төсөөтэй зүйлүүдэд оруулах замаар тайлбарладаг уламжлал байсан.

Хэм хэмжээг тогтоосон баримт бичгийг тайлбарлах тухай:

- хэм хэмжээг үйлчлэх хүрээгээр нь өргөтгөж буюу явууруулж тайлбарлах
- эрх зүйн нийтлэг журамд үл нийцсэн зүйл байгаа эсэхийг хянах
- аль нэг нэр томъёо, эсхүл уг зүйлийг бүхэлд нь тодруулах, ойлгомжтой болгох
- уг хэм хэмжээг хэрэглэх нөхцлийг тодорхойлох
- зүйлийг бүхэлд нь болон зарим нэг заалт, хэм хэмжээг хүчингүй болгох
- өөр зүйл юмуу эсхүл өөр эрх зүйн баримт бичигт шилжүүлэх
- асуудлыг ямар байгууллага шийдвэрлэх, хэний эрх хэмжээнд хамаарахыг зааж өгөх,
- бие даасан хэм хэмжээ тогтоох.

Хэм хэмжээг тайлбарлахдаа өргөн хүрээгээр тайлбарлахаас аль болох татгалзах нь зүйтэй байдаг. Учир нь ийм тайлбар хууль тогтоомжийг ойлгомжтой, эрх зүйн баримт бичгийн бүтцийг алдагдуулах, түүнийг ойлгож, хэрэглэхэд саад учруулдаг байна.

Хэдийгээр хууль тайлбарлах нь хуулийг зөв ойлгож, нэг мөр хэрэглэхэд чиглэгддэг боловч онцгой тохиолдолд үүнийг хэрэглэх нь зүйтэй. Ялангуяа нэг зүйлд хэд хэдэн тайлбар хийхээс татгалзах учиртай.

Дараахи тохиолдолд тайлбар зайлшгүй хийнэ:

- хууль тогтоогч хэм хэмжээний актыг тайлбарлахдаа түүнд ашиглагдсан нэр томъёог тодруулдаг.
- тусгай тайлбар шаардсан хэм хэмжээ зүйлд байгаа бол
- хууль тогтоох байгууллага зайлшгүй тайлбарлах шаардлагатай гэж үзсэн үед

ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ НЬ ИХ АДАРМААТАЙ, ЧИМХЛҮҮР АЖИЛ (бичиг дурсамж)

Осорын АМАРХҮҮ

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор

Өнөөгөөс өмнөх цаг хугацаа, түүхийн үйл явцын онго төрх, дүрс байдлыг бүгдийг хурц тод харуулах зорилго тавиагүй ч гэсэн өөрөө хуулийн төсөл боловсруулах ажилд амьдрал, хөдөлмөрийнхөө 30 гаруй жилийг зориулсан болохоор мэдэх, төсөөлөх хэмжээнд товчхон өгүүлсү.

Хууль бол төрийн бодлогыг илэрхийлдэг нэг төрлийн баримт бичиг болдог болохоор түүнийг бүр төслөөс нь боловсруулах, шүүн тунгааж хэлэлцэх, батлан тогтоож гарын үсгээр баталгаажуулах үе шат бүр нь төрийн албаны чанарыг шалгах нэг ёсны үзүүдэлт гэж хэлж болно. Ингэхдээ мэдлэг арвин, тал бүрийн хариуцлага сайтай байхыг цаг ямагт шаарддаг нь ойлгомжтой.

Хуулийн төслийг зохиолч, яруу найрагч, нэр хүндтэй жүжигчид, эмч, сурган хүмүүжүүлэгчид гэх мэтийн тодорхой нарийн мэргэжлийн хэн бүхэн барьж аваад хийгчдэггүй, мэргэшсэн, дадлагажиж туршилагжсан хэн нэгэн л гол төлөв оролдож, тэрлүүлж, бүтээж чаддаг гэж хэлэхэд хэтрүүлдэг үл болно. "Шаварт унасан шарын эзэн"-ийг өнөөгөөс арваад жилийн өмнө хуульч-мэргэжилтэн л голлож төлөөлдөг байсан бол одоо парламентчид ачааных нь хамаг хүндийг үүрдэг эзэн болов. Энэ бол төр, хууль цаазны жам ёсных нь хөгжил зөв голдиролдоо орсны тод илрэл.

Бидний үед хуулийн төсөл боловсруулах, тэр төслөө холбогдох шат шатанд хэлэлцүүлж, саналынх нь үндсэн дээр дахин боловсруулж эргүүлж танилцуулах, таалагдаагүй бол дахинд боловсруулах гэх мэтээр үргэлжилсэн үйл ажиллагаа их урт хугацааг тууздаг байв. Төслийн анхны хэлэлцүүлэг Сайд нарын Зөвлөлийн хуралдаан, удаах нь МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны хуралдаан, гуравдахь нь Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан, эцсийнх нь Ардын Их Хурлын чуулган гэсэн хэд хэдэн шатыг дэс дараалан дамжиж байж хууль батлагддаг байсан. Харин хуулийг Ардын Их Хурлын тэргүүлэгчид батласан нөхцөлд нэг шат хасагдана. Төсөл боловсруулагч энэ бүх шат дамжлага бүрийн ажлыг өөрөө биечлэн хариуцдаг хатуу үүрэгтэй байлаа. Энэ нь тухайн үеийн ажил хариуцах чадвар, сахилга, хариуцлагын нэг ёсны шалгуур болж байсан юм. Тиймээс ч төсөл боловсруулагчийн хувийнх нь хичээл зүтгэлийг илүүтэй шаарддаг байв.

Тийм болохоор уг ажлыг их адармаатай, чимхлүүр гэж бие сэтгэл, хүч бололцоогоороо би нэгэнтээ мэдэрсэн юм. Ингэж хэлэхдээ уйдсан, халивчрч залхсан утгаар огт биш, санах сэрэх, сурах мэдэхэд ихээхэн хүч түдхэл өгч байсанд урамшдаг, өөдрөг сэтгэл санаагаа л илчилж байгаа нь тэр.

Хуулийн төсөл боловсруулах ажилд гол төлөв дагнаж зүтгэсэн хугацаанд төр, засгийн удирдах байгууллага, албан тушаалтны үүрэг даалгавраар ажлын хэсгийг толгойлж буюу бүрэлдэхүүнд нь орж төслийг боловсруулж батлагдсан хуулийн тоо өнөөдөр зууд ойртож очсон нь мөнхий хувийн тэмдэглэлд үлдээнийг харахад сэтгэл өег, хангалуун яваагаа нуугтаад яахав.

Бидний үед хуульч бүхэн төсөл боловсруулдаггүй, харин Шүүх яамны тухайн ажил эрхэлсэн хэдэн мэргэжилтэн, Сайд нарын Зөвлөлийн хуулийн хэлтэс, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн хуулийн хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэнд уг ажил тохоогддог байлаа. Энэ нь цөөхөн хүний хүрээнд ажил хийгддэг гэсэн үг. Тийм болохоор тэдэнд их өндөр, заримдаа бүр чадал боломжоос хэтэрсэн ч гэж хэлж болох шаардлага ч тавигдана гээч. Заримыг тоймлон өгүүлбэл:

Тал бүрийн мэдлэг сайтай байх. Хууль зүйн бүх салбаруудын тэгш мэдлэгийг шинэжлэх ухааны үндэслэлтэй эзэмшиж, тэдгээрийн хоорондын уялдаа холбооны шалтгаалцаж бүрийг онол, арга зүйн хувьд нягт уяж холбох, ингэж байж хуулиудын хэм хэмжээ өөр хоорондоо зөрчилдөхгүй, давхардахгүй, бас хийдэл "цоорхой" гаргахгүй байх нөхцөл бүрдэж гэдэг зарчмыг чанд баримталдаг байв. Үүний тулд эрх зүйн салбар бүрийн онол, арга зүйн ном, зохиол, сурах бичгийг хүртэл олон дахин, байн байн сөхөн үзэж, уншиж судалсна, бас бүх хууль, зарлиг, тогтоолуудыг ч нэг нэгдгүй уншина, тэмдэглэл хөтөлнө.

Гадаад орны, ялангуяа Зөвлөлт Холбоот Улсын хуулиуд, ном зохиолыг илүүтэй судалсна. Болгар, Герман, Чех-Словак зэрэг тэр үеийн социалист орнуудын хуулиудаас ч бас "будаа иднэ".

Орос хэл сайн эзэмшсэн байхыг мэдээллийн тэргүүлэх шаардлага хэмээн үзнэ. Хуулийн төслүүдийг Орос хэлээр заавал давхар хийнэ. Гол учир нь төслийг Улс төрийн Товчооны бодлон Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэхийн өмнө Ю.Цэдэнбал гуай зөвхөн Орос хэл дээрхийг уншиж, улаан, хөх алаг болтол нь зурж тэмдэглээд саналаа олон минут, заримдаа цаг гаруй ч хэлж байдаг нь санаанд тодхон байна.

Тэр бүхнийг бид гараараа тэмдэглэж авна, харин сүүл хэрд магнитофонд бичдэг болсон билээ. Ер нь Ю.Цэдэнбал гуай хуулийн төсөл бүрийг маш сайн уншдаг, ЗХУ-ын холбогдох хуулиудтай заавал харьцуулж үздэг байсан нь түүний санал бодлоос нь илт харагддаг байлаа. Улс төрийн Товчооны гишүүдээс Ц.Дүгэрсүрэн, Н.Жагварал, Д.Моломжамц гуай нар төслийг сайтар уншиж судалсан нь илүүтэй мэдрэгддэг байсан юм. Тэд бидний тайлбар, танилцуулгыг ч их анхааралтай сонсож, зарим үед харилцан яриа болдог байсан нь багагүй урам зориг оруулдагсан.

Эдийн засгийн мэдлэг, тооцоо, судалгаа сайтай байхыг үргэлж шаардана. Төслийн хэлэлцүүлгийн хамгийн хүнд даваа Сайд нарын Зөвлөлийн хуралдаан. Энэ даваа эдийн засаг, тооцооны түвшинг шигшиж өгнө. Унах, бүдрэх нь олон ч гэсэн хуульч бидэнд их зүйл мэдүүлд, сануулж, туршлагажуулж. "хаширааж" өгсөн нь өнөөгийн зах зээлийн эдийн засгийн нөхцөлд ч "хуучин" хэмээн шоовдорлогдон "ад үзэгдэхээргүй" ач тусгаа өгчээ.

Төслийн эдийн засаг, тооцоо судалгаа нь хууль амьдралд хэрхэн нийцэн хэрэгжихийг урьдаас үнэн зөв төсөөлөх арга болдог байлаа. Зарим төсөлд эдийн засгийн тооцоо судалгаа нь өмнөх байдлыг эаж өөрчлөх, илүү ямар үр

дүн өгөх, түүндээ чухам хэдийд хүрсэн байх зэргийг холбогдох яам, газар, эрдэм шинжилгээний байгууллагаар гаргуулж хавсаргадаг арга ажиллагаа ч байсан юм. Бидний тийм арга ажиллагааг тухайн үед Сайд нарын Зөвлөлийн тэргүүд байсан Ж.Батмөнх, Д.Содином нар талархалтайгаар үздэг, шашид улам нарийвчлалтай болгох, амьдралын жишээ баримтаар нотолгоожуулахыг анхааруулан зөвлөдөг байлаа. 1983 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Шүүх Яамны 1982 оны ажлын тайлан хэлэлцэхэд Ж.Батмөнх гуай өөрийн биеэр оролцож, хэлсэн үгэндээ: "Та нарын хийж буй төсөл амьдрал сайн мэдэхгүй, эдийн засгийн тооцоо хангалттай хийхгүй байгаагаас хууль болсон хойноо бөгөөд насалж байгааг сайдаасаа эхлээд мэргэжилтнүүдээ хүртэл толгойноосоо бүү салга, ажил, анхаарлаасаа өчүүхэн ч гэсэн битгий холдуул" гэж цохон тэмдэглэж байсан нь миний хувийн тэмдэглэлд үлджээ.

Маш нэгт иймбай, хэнуур ажиллаж байх. Төслийн өгүүдээр бүрийг төдийгүй, үг үеэг, нэг, таслал бүрийг "долоо хэмжиж, нэг огтол" гэсэн шаардлага тавьдаг байлаа. Энэ бол мөн чанартаа төслийн хэллэг, бичлэг, нэр томъёо хэнд ч төвөггүй ойлгогдохоор өрж хайрцаглагдсан байх ёстой гэсэн үг. Тухайн шаардлага нь зөвхөн хуульд өөрт нь л байдаг техник ажиллагаанд ч (хэсэг, бүтнийг нэрлэх, зүйл, заалтыг дугаарлах, шинэ буюу улаан мөрнөөс эхлэх, өгүүдээр дуусалд үргэлжлүүлэх гэх мэт) нэг адил хатуухан байсан юм. Таслал тавиагүй буюу бичлэгээс орхиндсоныг анхааралгүйгээр удирдлагуудад тараачихсан тохиолдолд ч хүндхэн зэмлэл хүртэж, нүүр улайх үе гарч л байлаа. Нэгэн тохиолдол санаанаас огт гардаггүй юм.

"Хөдөө аж ахуйн нэгдлийн өрх" гэж хууль зүйн хувьд юу вэ? гэсэн төсөл хийж танилцуулах үүргийг Ю.Цэдэнбал гуай надад өглөө. Хэд хоног нухаж байж нэг төсөл хийж аваад эргэж танилцуулав. Энэ бол 1977 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр байж. Миний өгсөн төсөлд нэг таслал орхинджээ. Түүнээс үүдэн Ю.Цэдэнбал гуай таслалын учир холбогдалыг надад тайлж хэлэхдээ: "Таслал бол хуулийнхан утга агуулгаар хүнийг өршөөж, эсвэл шаазалж болдог хүчтэй тэмдэг байгаа юм" гээд нэг хуудас шаас авч хөх балын хандаагаар "помидовать нельзя казнить" гэсэн гурван орос үг бичээд таслалын нэг хувилбар нь "помидовать" гэсэн үгийн ард, нөгөө хувилбар нь "нельзя" гэсэн үгийн ардарт тус тус байршуулаад "за чи үүнийг унш, юу гэж ойлгож байна?" гэж асуугаад учрыг тайлбарлаж өгсөн юм. Түүнийг нь Шарав-иш гуай (орос хэлний орчуулагч) бид хоёр анхааралтай харж, "Даргаа би сайн ойлголоо, дахиад ийм алдаа хийхгүй ээ" гэж хэлэхэд "их сайн байна" хэмээн тас тас хөхөрч байж билээ.

Дээр дурдсан бүхнийг нуриури өгүүлдэхдээ хуучныг эргэн санагалзах, магтан дуулах, өмнөг өвчлөн гойчлох ямар нэг санаа бодол, үзэл баримтлал агуулаагүй гэдгээ уншигч авгай нартаа андгайлж байна. Гагцхүү түүхэн хуудасыг эргэн харж, санаа авах зүйл нэгээхэн ч байж болох алгуур хувьсал, хөгжлийн үүднээс дурсамж төдий тэмдэглэснээ өмсү.

Хуулийн төсөл боловсруулдаг бидний үеийн арга ажиллагааг тэр үедээ ч шүүмжлэлтэй авч үзэж, өөрчлөн шинэчлэх шаардлагатай болсныг байн байн ярихдаг байлаа. Хууль тогтоох байгууллага өнөөгийнх шиг байнгын ажиллагаатай Парламентын хэлбэрээр төлөвшил тогтох чадаагүй байснаас улбаалан хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх ачааны гол жин нь Шүүх яамны сайд, Сайд нарын Зөвлөлийн хуулийн хэлтсийн даргын нуруун дээр дардаг байсанд дутагдлын гол нь оршиж

байлаа. Тиймээс ч төсөл боловсруулах ажил цөөн хэдхэн хүний үүрэг мэт болж хувирсан юм. Тэр нь зүй зохист байдалд тохирохгүй байлаа. Дутагдлыг даван туулж, шинэчлэл, өөрчлөлт хийх арга замыг тэр үед бид хирдээ л хайж санал бодлоо хэлж, бичиж нийтлүүлж байсан юм. Жишээ нь зөвхөн миний бие л гэхэд АИХ-д хууль зүйн байнгын хороо байгуулах, Ардын Их Хурлыг их, бага хоёр танхимтай болгож, бага танхимыг хориод хүний бүрэлдэхүүнтэйгээр, хуулийн төсөл боловсруулдаг, хэлэлцдэг, батлуулахаар их танхимд өргөн мэдүүлдэг, хууль тогтоомжийн шинэчлэлийн бодлого боловсруулдаг үүрэгтэйгээр байнга (тогтмол) ажиллуулах, өөр бас хувилбарын саналуудаа нийтлүүлж байв. ("Хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь", "Хөдөлмөр" сонин, 1981.11.21-ний 131-д; "Шинэчлэл, арчиллыг эрх зүйн талаар хангах асуудал", "Ухуулагч" сэтгүүл, 1987 оны №8-д; "Шинэчлэлийн үеийн эрх зүйн ажил", "Үнэн" сонин, 1988 оны 4 дүгээр сарын 24-ний дугаарт; "Хууль тогтоомжийн шинэчлэл", "Ардын төр" сэтгүүл 1989 оны №6-д.)

Хуулийн төсөл боловсруулдаг цөөн хэдхэн хүний хийсэн зүйлд найдах, итгэх хандлага дээр доргүй бий болж, оруулсан төсөл онцон өөрчлөлтгүй хялбархан батлагддаг гэм арилж чадахгүй байв. Энэ нь хуулийн чанарт үргэлж сайнаар нөлөөлөөгүй нь мэдээж. Ардын Их Хурлын депутатуудад болон АИХ-ын Тэргүүлэгчдэд тараасан төсөл концепцийн зөрүү, "горимын санал"-гүйгээр л батлагдчихдаг хэвшмэл байдал тогтсон байлаа.

Ардын Их Хурлын чуулганаар хууль батлахад төслийн тухай нэг дарга илтгэл тавьж, урьдаас зориуд бичиж бэлтгэж өгсөн үгний хоёр, гурван депутат юндэр дээрээ уншин сонсож, бусад депутатууд ердөө л гар өргөх төдий л үүрэг гүйцэтгэдэг байлаа. Одоо энэ байдал үндсээрээ арилж өөрчлөгджээ.

Парламентад хуулийн төслийг хэлэлцэж, батлаж байгаа арга ажиллагааг хөндлөнгөөс харж суухад эрх зүйт төрийн хууль тогтоох үйл ажиллагаа онолд, практикийн хувьд үнэхээр дэлхий дахины жишигт хүрч чаджээ гэсэн сэтгэгдэл төрж, баярлан бахах юм. Хуулийн төслийг зүйл, заалт бүрээр нь анхны, хоёрдахь, эцсийн хэлэлцүүлэг гэж хэд хэдэн удаа нягтлан тунгааж, гишүүд үзэл бодлоо илэн далаангүй, чөлөөтэй хэлж, олонхийн саналаар хууль төрлөг боллоо. Энэ бол Монголын төрийн хууль тогтоох ажиллагаа эхнээсээ эцсийнхээ үе шатыг хүртэл ардчилсан ёсоор шинэчлэгдэж чадсаны илрэл мөн.

Өнөөдөр Засгийн газар Улсын Их Хуралд хуулийн төсөл өргөн барихын тулд холбогдох бүтэц, бүрэлдэхүүн, мэргэжлийн хүчийг өргөнөөр хамруулан ажиллуулж, хуралдаанаараа хянан хэлэлцэж, эцсийн хариуцлагыг танхимын зарчмаар хүлээдэг болсон нь хуулийн төслийн чанарт тавих шаардлага болов. Засгийн газрын өргөн барьсан төслийн хувьд ч, хууль санаачлагчийнхаа хувьд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс болон Улсын Их Хурлын гишүүдээс өргөн барьсан төслийг ч гэсэн Парламентын ажлын зохион байгуулалтын бүтэц болсон ажлын хэсэг, байнгын хороодод тал бүрээс нь нухацтай авч хэлэлцэж байгаа нь төсөл бэлтгэх ажилд гарсан шинэ өөрчлөлт мөн.

Үүний үр дүнд төслийн сайн, муу талыг олон ургальч үзлээр ил тод шигшин гаргах, үзэл баримтлалын зөрүүг тодруулах, горимын саналын ач тусыг уралдуулах, төслийг Засгийн газарт буюу санаачлагчид нь буцаах зэрэг жинхэнэ ардчилсан ёсны ажил хэрэгч үйл ажиллагаа бодит байдал болж

эргэлт буцалтгүй төлөвшин. Ингэснээр хуулийн төсөл боловсруулах төрт бсны ардчилсан үйл ажиллагаа өмнөх нийгмийнхээс чанарын үндсэн дэвшилд илжж, төрийн бодлогыг хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийн зорилгод нийцүүлэн зөв зохистойгоор тодорхойлон батлан гаргах сайхан боломж бүрдсэн байна.

Байдлыг ийнхүү үнэлэн дүгнэхдээ сүүлийн үеийн хуулиуд ямар нэгэн учир дутагдалгүй, чанарын өндөр түвшинд бүтээгдсэн гэсэн дүн тавиагүй гэдгээ энэхүү ялдамд тэмдэглэн хэлэхийг хүснэ. Хууль бүхний чанар чансаа хүн амын хүсэн хүлээж буй шаардлагад хүрэхгүй байна. Ганцхан жингээ хэлэхэд олон тооны хуулиуд батлагдсанаас хойш хэдхэн сар, нэг хоёр жил хүрээ үү үгүй юу нэмэлт, өөрчлөлт арга буюу хийгдэх тохиолдол их болжээ. Зарим хуулийг нэмэлт, өөрчлөлтөөр нь энгийн иргэд төдийгүй, эрдэмтэд, судлаачид ч учрыг нь олж ойлгоход хүндрэлтэй болчихжээ. Энэ бол хуулийн чанар ямар байгаагийн тодорхой үзүүлэлт гэсэн үг.

Гол учир шалтгаан нь хууль тогтоох эрх эдэлдэг парламентч бүрийн мэдлэг чадвар, дадлага туршлага жигдрээгүйд, мөн улс орны эдийн засаг, нийгэм, соёлын байгуулалтын бүхний л амьдралыг тольдон удирддаг Засгийн газрын хариуцлага тогтворжиж төлөвших нь учир дутагдалтай байгаад оршиж буй бололтой. Улсын Их Хурлын шинэ болон шинэвтэр гишүүд хоёр, гурван ч удаа төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдон ажиллаж байгаа андуудынхаа хуримтлуулсан туршлага, олж авсан мэдлэг чадвараас уйгагүй суралцахын төлөө хичээн зүтгэх, нөгөөдүүл нь ч харамгүй тусалж дэмжих хамтын ажиллагаа их ач тус үзүүлдэг гэдэгт итгэж яадгаа эцэст нь дурдав.

ЭХ ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН БҮЛГИЙН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН СИСТЕМИЙН ТОВЧ ТҮҮХ

Дитрих НЕЛЛЕ
Хууль зүйн ухааны доктор

1. Оршил
2. Ромын эрх зүй
3. Угсаатны ба бүс нутгийн эрх зүй
4. Хууль, эрх зүйн ном, хууль цааз
5. Шинэ үеийн хууль тогтоомж
6. Тулгамдсан асуудлууд
7. Төгсгөлийн үг

1. Оршил: Эх газрын эрх зүйн бүлгийг англи хэлнээ "civil law countries" хэмээн нэрлэх нь ихээхэн тохиолддог ба иргэний эрх зүй нь энэхүү эрх зүйн системд гол цөм нь мэт харагддаг. Үнэн хэрэгтээ иргэдийн өдөр тутмын амьдралд, ялангуяа эдийн засгийн амьдралд чухал ач холбогдол бүхий иргэний эрх зүй нь өөрөө эрх зүйн хөгжилд асар том түлхэц өгсөн бөгөөд өнөөдөр "хоёр дахь үндсэн хууль" хэмээн нэрлэгдэх болсон. Тийм ч учраас Ромын эрх зүйн үеэс өнөөдрийг хүртэлх хугацаанд иргэний эрх зүйн хөгжиж ирсэн ерөнхий чиг, хандлагуудыг дахин нэг эргэн харах нь ихээхэн сонирхолтой болно.

2. Ромын эрх зүй: Ромын эрх зүй нь институтын хэмээх системийг боловсруулсан /К.Муциус¹, Нерац¹ ба Гайус¹/ бөгөөд энэ нь 534 оны Юстинианы хуулийн институтүүдэд уламжлагдсан¹ бөгөөд тэр үеэс эхлэн Юстинианы хууль нь Ромын эрх зүйн гол бүтээл болсон юм. Энэ системийн дагуу матери нь *personae* (хувь хүн, гэр бүлийн эрх зүй), *res* (эд юмсын, өв залгамжлалын болон үүргийн эрх зүй) ба *actiones* (нэхэмжлэлийн шаардлага, нэн ялангуяа процессийн эрх зүй) гэсэн гурван хэсэгт хуваагдана. Хэдийгээр ромын хуульчид үүргийн эрх зүйг ихээхэн хөгжүүлдсэн¹ бөгөөд үүргийн эрх зүйн ерөнхий зарчим, эрх зүйн институтийг боловсруулахад асар их зүйлийг хийж гүйцэтгэсэн² боловч эдгээр үндсэн зарчим, институтийг нэгтгэсэн, хэлбэрийн хувьд тодорхой зааж өгсөн тохиолдлууд болох худалдах, худалдан авах тухай эсвэл стимуляциас салгаж, зааглаж өгсөн үүргийн эрх зүйн тод төгсгөл бүхий ерөнхий хэсэг дутагдаж байсан. Гэхдээ практикт тэргүүлэх ач холбогдолтой худалдах, худалдан авах эрхийн хүрээнд боловсрогдсон үндсэн зарчмуудыг бусад гэрээнд³ тусгасан нь зарим нэг тэнцвэржүүлэлтийг хангасан. Үүний зэрэгтээ сүүлд иргэний хуулийг кодексчилох бололцоо бий болгосон эртний суурийг нөгөөх хувь хүний гэгдэх эрх зүй маань тавьж өгсөн. *Corpus Iuris Civilis*, Дягэстэн болон Кодексийн бусад хэсгийн ангилал нь системчилэл гэхээсээ илүү түүхэн уламжлалд чиглэсэн байсан.

3. Угсаатны ба бус нутгийн эрх зүй: Өрнөд Ромын эзэнт гүрэн мөхөж герман угсаатнууд хүчирхэгжиж ирэхэд эрх зүйн гол гол үндэс, сууриуд нь өөрчлөгдөх болсон. МЭ 5-р зууны сүүлчээс хувь хүнд чиглэдэг зарчмаас (хэрэглэх эрхийг тухайн хүний харьяалагдах угсаатны эрхээр тодорхойлдог) угсаатны эрхийг бичгээр тэмдэглэдэг хэлбэрт шилжсэн.

Германуудын хууль, эрх зүй нь өрнийн готуудын *Codex Eurici* гэгдэх 475 оны бичгэн хэлбэрт орсон хууль байсан бөгөөд өнөөдөр түүний зөвхөн зарим нэг хэсгүүд нь хадгалагдан үлдсэн юм¹¹. Үлдсэн хэсгүүдээс нь хоорондоо уялдаа холбоо бүхий гэрээний эрх зүй байсан болох нь харагдах боловч эрүүгийн эрх зүйн элементүүд орсон байсныг үзэж болно. Өрнийн готуудын ром албат нарын хувьд хүчин төгөлдөр үйлчилж байсан хувилбар болох *Lex Romana Visigothorum* бүрэн уламжлагдсан¹². Энэ нь эсдээрээ бус олсон газраараа ангилагдсан байх бөгөөд иргэн, эрүү, ийнтийн эрх зүйн болон сүм хийдийн эрх зүйн салбаруудыг өргөн хүрээгээр хамарсан байдаг.

Хувь хүнд чиглэсэн зарчмаас бус нутгийн зарчимд шилжсэн үйл явцыг 7-р зуунд Испанид гарсан *Fuero Juzgo*¹³-той холбож үздэг. Энэ нь *Lex Romana Visigothorum* -ыг авч үзсэн бөгөөд эрх зүйн матернар ангилагдаагүй болохыг тогтоосон ба хураангуйлсан бүтээлүүд нь бие даасан хэлбэрээр хэсэгчлэн хадгалагдаж үлдсэн. Гэхдээ *Leges* (ихэс дээдсийн эрх¹⁴ Теодозинусын кодекс болон туужууд) ба *Ius* (Хуульчдын эрх=Гайус, Паулуус, Грегорианусын кодекс, Хермогенианусын кодекс, Папиниан) гэж үндсэнд нь хоёр хуваасан байдаг¹⁵. *Lex Romana Visigothorum* нь илүү өргөн хүрээг зохицуулсан бөгөөд ийнтийн, эрүүгийн болон сүм хийдийн эрх зүй зэргийг хамарсан хууль юм¹⁶.

Ижил төстэй бүтцийг германуудын дараа дараагийн хууль тогтоомжид ажиглаж болох бөгөөд 8-р зууны дунд үед бичигдсэн *Lex Baiuvariorum*-д¹⁶ тод ул мөр үлдсэн байдаг.

4. Хууль, эрх зүйн ном, хууль цааз: 13-р зуун хүрч байж Ромын эрх зүй Италийн дээд сургуулиудад дахин эрчимтэй заагдаж эхэлсний нөлөөнд европын эрх зүйн хөгжилд мэдэгдэхүйц ахицууд гарсан. Энэ нь европын бусад хэсэгт аль болох дэлгэрэнгүй, гол гол эрх зүйн эх сурвалжуудыг бичиж тэмдэглэдэг байх хандлагыг бий болгосон.

Энэ үеийн хамгийн гол баримт бичгийн нэг нь 13-р зууны эхээр Германы төв хэсэгт бий болсон *Sachsenspiegel* юм.

Хэдийгээр энэ нь тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эрх зүйн хэв заншлуудыг хувь хүний гараар бичиж тэмдэглэсэн төдий зүйл байсанч энэхүү бүтээл олон түмний анхаарлыг ихэд татсан юм. Германы олон нутагт ижил төстэй *Spiegel*-үүд бичигдсэн. Улмаар Заксен мужийн нутгаас хол давж зүүн зүгт, ялангуяа Киев, Балтийн тэнгэсийн бүсэд тархсан. 1794 онд пруссийн Мужийн ерөнхий хууль гарч үйлчилж эхэлснээр Германд *Sachsenspiegel*-ийн ач холбогдол үгүй болсон боловч 1900 оны Иргэний хууль гартал Анхальт болон Тюринген мужуудад мөрдөгдөж байсан. *Sachsenspiegel* нь гурван хэсгээс бүрдэж байсан ба эдгээр нь: оршил, мужийн эрх болон язгууртны эрх юм; гэхдээ эрх зүйн ерөнхий хандлага нь мужийн эрхэд төвлөрч байсан. Өнөөдөр бидний ялгаж ойлгодог эрх зүйн салбаруудыг тэр хуулинд тусгаарлаж өгөөгүй байсан ба эрх зүйн нилээд өргөн хүрээг хамарсан эрүүгийн эрх зүй, шүүхийн зохион байгуулалтын болон процессийн эрх зүй мөн иргэний эрх зүйн

асуудлуудыг /энд ялангуяа гэр бүлийн эрх зүй, өв залгамжлал, хөрөнгийн эрх зүй, эрх зүйн чадамж зэрэг орно/ тусгасан байдаг.

Үүний зэрэгцээ Испанид 13-р зууны дунд үед *Fuero Real* гэгдэх хууль, эрх зүйн томоохон эмхэтгэл бий болсон¹⁷. Энэ нь 5 бүлгээс бүрдсэн, ямар нэгэн гарчиггүй байх бөгөөд янз бүрийн эрх зүйн салбарын зохицуулалтуудыг агууласан байдаг. Тухайлбал: худалдах, худалдан авах болон солилцоотой холбоотой хэсгүүд нь гуравдугаар бүлэгт асран хамгаалагч тогтоохтой холбоотой хэсгийн дараа мөн өв залгамжлалтай холбоотой зохицуулалтууд нь бэлэглэл, язгууртнуудын эрхтэй холбоотой хэсгийн өмнө орсон байдаг. *Fuero Real* нь *Sachsenspiegel*-тэй харьцуулахад ихээхэн даруухан бүтээл бөгөөд харин үүнээс хэдхэн жилийн дараа нилээд шинэлэг, ирээдүйг харсан хууль, эрх зүйн бүтээл болох *Leyes de Partidas* гарсан байдаг.

Европод явагдаж байсан энэхүү эрх зүйн хөгжилтэй цаг хугацааны хувьд бараг нэг зэрэг дорно зүгт олон мянган километрийн цаана ижил төстэй үйл явц болж байсан нь сонирхолтой. Тэнд Монголд Чингис Хааны зарлигаар *Yasa* (мөн Их Засаг) монголын анхны бичмэл хууль болж гарсан байдаг. Энэхүү хуулийн бүрэн агуулга нь харамсалтай нь сэргээгдэх боломжгүй бөгөөд зөвхөн бүрэн бус текстүүд нь үлдсэн¹⁸.

Зохицуулагдсан гол зүйлүүд нь захиргаа, цэргийн болон эрүүгийн эрх зүй, сүүлд эрүүд ахуйн болон сахинга баттай холбоотой асуудлууд орсон¹⁹. Нүүдэлчдийн нийгмийн²⁰ шаардлагад нийцүүлсэн байдаг ба энэ нь гадаадын эрх зүйн ямар нэгэн загвар²¹ бус цэвэр монгол бүтээл болохыг харуулж байна.

Сүүлд гарсан монголчуудын хуулинд нь гол төлөв орон нутгийн шонхтэй зүйлүүд байсан ба бага хэмжээгээр хадгалагдаж үлдсэн. Бус нутгийн ач холбогдол бүхий цэвэр монголын хамгийн сүүлчийн бүтээл нь 1709 оны Халх журам юм²². 1921 он хүртэл нийслэл хотын орчим амьдарч байсан дор хаяж 100000 монгол иргэдэд хүчин төгөлдөр үйлчилж байсан²³.

Агуулгын хувьд энд 17-р зууны нийгэм, эдийн засаг болон улс төрийн бүхий л асуудлыг тусгасан²⁴. Тухайн цаг үеийн европын эрх зүйн олон бүтээлийн нэгэн адил нарийн системчилсэн ангилалгүй байв. Нэгдүгээр бүлэг нь голчлон Богд Гэгээн (Хаан), лям нарын эрх мэдэл болон бэлчээрийн зохион байгуулалтын асуудлыг зохицуулсан, хоёрдугаар бүлэг нь гэр бүлийн эрх зүй, гуравдугаар бүлэг нь эрүүгийн эрх зүй, дөрөвдүгээр бүлэг нь өв залгамжлал, тавдугаар бүлэг нь процессийн эрх зүй, зургаадугаар бүлэг нь үүргийн болон эд юмсын эрх зүй мөн долдугаар бүлэг нь арми, цэргийн асуудлыг хамарсан байх боловч энэхүү хуулийн бүх хэсгүүдэд нь эрүүгийн эрх зүйн элементүүд орсон байдаг.

5. Шинэ үеийн хууль, тогтоомж: Шинэ цагийн хууль, тогтоомжийн хөгжлийг эргээд л Испанид холбож үзэх хэрэгтэй болно. *Fuero Real* гарсны дараахан Альфонс X Хааны²⁵ удирдлаган доор хууль тогтоомжийн шинэ бүтээл бичигдэж эхлээд 1265 онд дууссан²⁶. Тодорхой ангилал, системчлэлд хүрэх гэсэн оролдлогын хажуугаар ард түмний эрхээс ромын эрх зүйд шилжсэн, ялангуяа Юстинианы хуульд агуулаараа эргэж ойртсон байдал төд харагдана²⁷. Энэхүү *Leyes de Partidas* гэгдэх хуулийн долоон хэсгийн дөрөвт нь шүүх, эд юмсын, гэр бүлийн болон үүргийн эрх зүй мөн өв залгамжлалын асуудлууд хамрагдсан байдаг. Энэ нь эдийн засгийн харилцаа өргөжиж

иргэний эрх зүйн ач холбогдлыг өсөж буйг тодотгож байна. Энэхүү томоохон хууль, эрх зүйн бүтээлийн нэгэн тэмдэглүүштэй зүйл бол испани хэдийг кастили аалгуутай нэг хэмжээнд авч үздэг болсон явдал юм.

Мөн дараагийн зуунуудад ч гэсэн орон нутгийн эрх зүй нь хэн заншлын болон ромын эрх зүйн зарим хэсгүүдээс илүү хүчтэй байсан. Үндсэн өөрчлөлтүүд нь 18 ба 19-р зууны зааг дээр хийгдсэн бөгөөд тэр үед хууль, тогтоомжийг ихээхэн эрчимтэй гаргаж байсан бөгөөд хууль тогтоогчид нь харин өөр өөр арга замаар хэрэгжүүлж байжээ.

Энэ үеийн томоохон бүтээлүүдийн анхных нь 1756 оны *Codex Maximilianicus Bavaricus Civilis* мөн²⁹. Энэхүү хууль нь 1616 оны Бавари мужийн хуулийн нэгэн адил ромын эрх зүйд тулгуурласан байсан ба аль болох агуулгын хувьд тодорхой, олон нийтэд ойлгомжтой байдлаар зохицуулахыг хичээсэн байдаг³⁰. Мөн энэхүү хууль нь шинэ цагийн хуулиудын дотор иргэний эрх зүйд голчлон хандсан хамгийн эхний хуулиудын нэг гэдгийг тэмдэглүүштэй. Системчлэлийн хувьд энэ хууль ромын институтад тулгуурласан нь тодорхой харагдана; гэхдээ процессийн эрх зүйг бүүр тусад нь гаргасан байх бөгөөд хувь хүний эрх зүйг институтад "res" хэмээх ерөнхий ойлголтод хамаарах эд юмсын эрх зүй, өв залгамжлал ба бэлэглэл мөн гэрээний эрх зүй зэрэг хэсгүүдийг тус бүрд нь бие даасан бүлэг болгон зэрэгцүүлж тавьсан байна. Өмнө нь дурьдсан хуулиудаас хамгийн анх энэ СМВС-д үүргийн ерөнхий ангийн зохицуулалтуудыг тусдаа хэсэг болгосон³¹. Энэхүү хууль нь тухайн үед эрх зүйн шинжлэх ухааны хувьд нэн таатай орчинд бий болсон болох нь хууль гарснаас хойш удалгүй дэлгэрэнгүй эрдэм шинжилгээний тайлбараар баяжуулагдсанаас харагдана³².

1794 оны пруссийн Мужийн ерөнхий хууль нь Баварийн шинэчлэл болох Иргэний эрх зүйг бие даалгасан туршлагыг аваагүй, харин бүх материйг хуучин загварын дагуу нэгэн бүхэл зүйлийн дор томъёолсон. Аль болох хийдлэгүй хийх гэсэн оролдлого нь ямар нэгэн тайлбар, эрх зүйн сургалт хийх орон зай үлдээгээгүй тул амьдралд нийцэхгүй болох нь удалгүй харагдсан. Ангиллын хувьд хоёрхон нэргүй хэсэгт хуваагдсан тус бүр нь 23 ба 20 гарчигтай бөгөөд энэ нь ромын эрх зүйн институтын системтэй харьцуулахад ихээхэн тодорхой бус юм. Хувь хүнд бие хүнийх нь хувьд чиглэсэн эхний бүлэгт нь иргэний эрх зүй байх ба гэр бүлийн эрх зүй ороогүй байна; хувь хүнийг нийгмийн нэг гишүүн гэдгээр нь авч үзсэн хоёрдугаар бүлэгт нь эрүүгийн болон нийтийн эрх зүйн зохицуулалтууд өөр бусад үлдсэн бүх эрх зүйн материйн хамт орсон байдаг. Худалдах, худалдан авах болон солилцоо нь эхний бүлгийн эхний хоёр гарчиган доор орсон. Гэхдээ маш их өргөн хүрээг хамарсан тавдугаар бүлэг нь энэ хоёр гэрээнд мөн хамаарах юм.

19-р зуун гэхэд Испани дэлхийд эзэлж байсан өөрийн улс төр, эдийн засгийн байр суурна төдийгүй хууль, эрх зүйн салбар дах тэргүүлэх нөлөөгөө алдсан юм. 1805 оны *Novissima Recopilation* гэгдэх нэгэн томоохон хуулиар их өргөн хүрээг хамруулах гэсэн оролдлого нь хэсэгчилэн бүтэлтэй болсон хэдийг хуульч хүний хувьд ч аль нь ямар тохиолдлыг зохицуулж байгаа эсэхийг ойлгоход бэрхшээлтэй болгосон. Мэргэжлийн хувьд дутагдалтай зэрэгцээ янз бүрийн үүсэл гаралтай хуулийн текстүүдийн хоорондын уялдаа холбоо байхгүй. *Novissima Recopilation* нь 12 бүлэгтэй бүтээл бөгөөд иргэний эрх зүйн зохицуулалтууд нь 10-р бүлэгт төвлөрсөн байх ба энд өв залгамжлал

болон үүргийн эрх зүй орсон байдаг. Эртний испанийн эрх зүйд амх удаа үүргийн эрх зүйн өмнө ерөнхий ангийг оруулсан боловч үндсэндээ энэ нь ерөнхий утгатай өгүүлбэрүүдийг зэрэгцүүлж бичсэн байх ба ямар нэгэн нэгдмэл системийг хөгжүүлэх тухай асуудлыг энд харгалзсангүй. Гэр бүлийн эрх зүйг мөн энэ 10-р бүлэгт гэрээний эрх зүйн нэг хэсэг болгосон бөгөөд эд юмсын эрх зүйн холбогдолтой зохицуулалтууд огт байхгүй юм. 11-р бүлэгт иргэний процессийн заалтууд орсон байдаг. Мөн тухайн үеийн эдийн засгийн холбогдолтой зохицуулалтууд нь 11-р бүлэгт орсон бөгөөд энд худалдаа, мөнгө тухай, уул уурхайн ажилтай холбоотой заалтууд оржээ.

Хэдийгээр 1756 оны Баварийн Кодекс нь үлгэр жишээ бүхий шинэчлэлүүдийг агуулсан байсан боловч Бавариас гадагш зохих анхаарлыг хүлээж чадаагүй юм. Тэгээд 19-р зууны эхээр францын Code Napoleon хүчин төгөлдөр болсноор эрх зүйн хөгжлийн цоо шинэ эрин үе эхэлсэн гэж үздэг. Энэ хууль, тогтоомжийн бүтээлд эрх зүйн гол гол материйг системчилсэн, нягт уялдаа холбоотойгоор зохицуулах гэсэн хүсэл эрмэлзэл нь өнөөдрийг хүртэл эх газрын эрх зүйн системийн үндсэн тулгуур зарчим хэвээр үлдсэн³¹. Энэхүү бүтээл асар их амжилтанд хүрсэний нотолгоо нь өнөөгийн хууль, тогтоомжтой харьцуулахад батлагдсанаасаа хойш 200 жилийн дараа багахан өөрчлөгдөж хүчин төгөлдөр хэвээр байгаа явдал мөн. Тийм ч учраас энэ хууль бөгөөд хутацаанд олон оронд загвар хууль болж³² францын эрх зүйн шинжлэх ухаан удаан хугацаагаар олон улсын тавцанд тэргүүлэх байдалтай болсонд гайхах зүйл үгүй. Жишээлбэл; Ангуан дэ Сант-Иосифын хуулийн эмхэтгэлүүдэд Наполеоны кодексийг тухайн үеийн бүх иргэний хуулиудыг франц хэлнээ харьцуулж тавьсан нь тэр үеийн дэлхий даяар хамгийн тархсан жишээ бүтээл юм³³.

Наполеоны кодексоос хойш иргэний эрх зүй нь бие даан кодексчилдөг болсон бөгөөд энэ нь дэлхий нийтийн стандарт болсон. Мөн ромын институтын системийн нөлөөлөл бүхий дотоод бүтэц нь эх газрын эрх зүйн бүлгийн цаашдын хууль, тогтоомжид ч хадгалагдаж үлдсэн. Оршлын дараа эхний бүлэгт хувь хүнд чиглэсэн эрх зүйн зохицуулалтууд орсон, дараагийн хоёр бүлэгт эд юмсын эрх зүй (эд юмс, эд хөрөнгө, хуулийн дагуу эд хөрөнгө олж авах, эд хөрөнгийн хязгаарлагдмал эрх) буюу эд хөрөнгө олж авах эрх (ялангуяа өв залгамжлал, бэлэглэл ба гэрээний эрх зүй) орсон; Cambaceres-ийн анхны төслийн 4-р хэсэг нь процессийн³⁴ тухай байсан боловч явцдаа тэр нь өөрчлөгдөж иргэний процессийн эрх зүйг баварийн кодекстэй нэгэн адилаар тусдаа кодификаци болгосон³⁵. Харин гэрээний эрх зүй нь үүргийн ерөнхий ангийн дараа орсон байдаг. Эх газрын эрх зүйн бүлгийн дараа дараагийн бүхий л хуулиуд үүнтэй нэгэн адилаар хийгдсэн.

Герман хэл дээр бүтээгдсэн тэр үеийн гуравдахь том хууль нь бол Баварийн Кодекс болон пруссийн Мужийн ерөнхий хуулийн дараа орох 1811 оны австрийн *Иргэний ерөнхий хууль* юм. Ялангуяа пруссийн Мужийн хуультай харьцуулахад тохиолдлын шинэ чанартай зохицуулалтаас татгалзсан бөгөөд Кантын нөлөөгөөр илүү уян хатан ерөнхий заалтуудтай тул энэ хууль нь шүүгчдэд илүү их орон зай өгсөн байдаг. Энэхүү уян хатан байдал нь өнөөдрийг хүртэл энэ хууль хүчин төгөлдөр байгаагийн гол шалтгаан мөн бөгөөд 1914 ба 1916 онуудад хэсэгчилсэн шинэчлэлүүд хийгдсэн болоод германы Иргэний хуулинд уламжлагдсан юм. Австрийн Иргэний ерөнхий хууль нь роман эрх зүйн уламжлалд ихээхэн хэмжээгээр тулгуурласан, хувь

этгээдэд чиглэсэн зохицуулалтууд бүхий ерөнхий ангид нь харин дараах хоёр хэсэгтээ хамаарах нийтлэг зохицуулалтууд орсон байдаг.

Германд бараг хагас зуун жилийн дараа гүн гүнзгий шинэтгэлийн үйл явц эхэлсэн. Урт удаан хугацаанд тархай бутархай улс төр, эдийн засгийн хувьд сул дорой жижиг улсууд пруссийн далбаан дор дахин нэгдсэнээр томоохон орон зайд чөлөөтэй аригжаа, худалдаа эрхлэх боломж бий болсон нь улсаа үйлдвэржүүлэх үсрэлт бүхий процессыг эхлүүллэн. Гэхдээ эхэндээ энэхүү шинэ нөхцөл байдал нь үнэхээр доо шинэ эрх зүйн үндсийг шаардаж байгаа эсэх эсвэл эрх зүйгээ зөвхөн зөв тайлбарлах, сургалтын арга хэмжээ зохион байгуулах хэлбэрээр асуудлыг шийдвэрлэж болох эсэх нь ихээхэн маргаантай байсан. Эдийн засгийн амьдрал идэвхжихийн хэрээр эдийн засгийн хөгжлийн амжилтын баталгаа болох тийм эрх зүйн орчин зайлшгүй хэрэгтэй болох нь удалгүй тодорхой болсон. Урьдын адил энэ нь хатуу эсэргүүцэлтэй тулгарч байсан ба шинэ хууль нь гагцхүү олон улсын шинжлэх ухааны маш өндөр түвшинд боловсруулагдаж хүлээн зөвшөөрөгдсөнөөр амжилтад хүрэх боломж нь бий болох нь мөн ойлгомжтой байсан. 1900 оны германы Иргэний хуулийг боловсруулахад хамгийн чухал үндэс суурь нь тухайн үед яригдаж байсан цорын ганц бөгөөд германд нилээд их маргаантай байсан ромын эрх зүйг нарийвчлан судалсан явдал юм. Мөн тэр үед бараг зуу шахаж явсан Наполеоны кодексын сул талуудыг нь тогтоож хуулиа системчлэл, логикийн хувьд боловсронгуй болгох боломж олдсон юм.

Тэр үеэс хойш германы хуульчдын хувьд ойлгомжтой бөгөөд зайлшгүй хийгдсэн шинэчлэлүүд нь гэнэт үүргийн болон эд юмсын эрх зүйн хоорондын харилцааг нарийвчлан тодорхойлсон, тэр бүлийн эрх зүйг нэгтгэсэн болон хамгийн анхны бөгөөд нийт хуулиндаа хамаарах ерөнхий ангийг бий болгосон зэрэг юм¹⁴.

Германы Иргэний хууль батлагдсан нь цаашдын хууль тогтоомжид асар их нөлөөлсөн. Австрийн Иргэний ерөнхий хуулийн талаар өмнө дурьдсан. Германы Иргэний хуулийн системчлэлд нилээд ойртуулж хийгдсэн хуулиуд бол 1917 оны Бразилийн болон 1966 оны Португалийн иргэний хуулиуд юм. Олон зуун жилийн түүхтэй Герман Оросын эрх зүйн харилцааг энд дурьдах хэрэгтэй бөгөөд хэдийгээр завсар нь улс төрийн томоохон мөргөлдөөнүүд болсон ч гэсэн 1922 оны оросын иргэний хууль дээрх хуулиудын нэгэн адилаар бий болсон юм. Италийн эрх зүйн шинжлэх ухаан юуны өмнө германы Иргэний хуулинд тулгуурласан бөгөөд хуучин 1865 онд Наполеоны кодексоос уламжлалтай Иргэний хуулиа 1942 онд үндсээр өөрчилж шинэчлэн баталсан. Германы Иргэний хуулинд тулгуурласан гэдэг нь ямар нэгэн шүүмжлэлгүйгээр хуулбарласан гэсэн үг биш харин цааш нь хөгжүүлсэн гэж ойлгох хэрэгтэй. *Codice civile* гэгдэх энэхүү хуулийн гол шинэчлэг зүйл нь бол германд ч ихээхэн маргаантай байсан иргэний эрх зүй болон худалдааны эрх зүй гэж хувааж байсныг иргэний хуулиндаа нэгтгэсэн явдал юм. Мөн тухайн үед эрх зүйн шинжлэх ухааны хувьд төдийлөн нарийн судлагдаагүй байсан ба тийм ч учраас германы Иргэний хуулинд тусгагдаагүй байсан хөдөлмөрийн эрх зүйг бие даасан хууль болгож гаргасан байдаг.

Монголд 1913-аас 1918 оны хооронд хүчин төгөлдөр үйлчилж байсан эртний монгол болон манжуурын эрх зүйг системчилж нэгэн шинэ эмхэтгэлд оруулах ажлыг монгол эрдэмтдийн бүлэг гүйцэтгэж байсан¹⁵. Арга барил, агуулгын хувьд энэ нь дундад зууны үеийн кодексчилал¹⁶ байсан ба 1889 он

хүртэл Испанид үйлчилж байсан Novísima Recopilacion⁴¹ гэгдэх хуультай харьцуулж болно. Улсын дотоод гадаад тогтворгүй байдлаас энэ хууль батлагдаагүй бөгөөд ямар нэгэн байдлаар нийтлэгдээгүй юм⁴². Хэдий тийм боловч энэ нь уламжлалт эрх зүй болон 20-р зууны эрх зүйн сэтгэлгээний нэгдлийг харуулсан бүтээл мөн.

1926-1949 оны монголын анхны Иргэний хууль мөн энэ нэгдэлд бүтээгдсэн⁴³. Жишээлбэл; ийнхүү мал сүрэг нь тайж, язгууртны өмчид үлдсэн⁴⁴. Үүний хажуугаар энэ хууль нь оросын эрх зүйд тулгуурлаж эхэлсэн үеийн эхлэл бөгөөд Монгол улс эх газрын эрх зүйн бүлэгт орж буй үеийг тодорхойлдог⁴⁵. Энэ нь мөн Оростой нэгэн адилээр Иргэний хуулиас тусдаа бие даасан Гэр бүлийн хууль 1928 онд батлагдсанаар харагдана⁴⁶. 1926/1929 онд өөрчлөлт, шинэчлэлийн хүнд хэцүү үед батлагдсан Иргэний хууль нь ангилалын хувьд тухайн үеийн ижил хуулиудаас дутмаг бөгөөд иргэний процессийн эрх зүйг мөн өөртөө агуулсан байдаг. Нөгөө талаар яг энэ нохиол байдлууд нь тэр үеийн шинэтгэлийн томоохон баримт бичиг болгодог. Бие даан батлагдсан 10 бүлэг нь дараах сэдвийг хамрана:

1. Өмчийн хүүхэд, ядуу хүмүүсийг асран хамгаалах, хамгаалах
2. Өв залгамжлал
3. Гэр бүлийн эрх зүй
4. Нэгдэл, хамтрал
5. Өмчийн эрх зүй
6. Иргэний хэргийг давж заалдах
7. Эд хөрөнгийн барьцаа
8. Иргэний хэрэг маргаан
9. Гэрээний эрх зүй
10. Иргэний эрхийн үүргийг баталгаажуулах⁴⁸.

Түүнээс хойш хэдэн арван жилийн турш зөвлөлтийн эрх зүйд мөн тулгуурласаар ирсэн. Хэдийгээр зөвлөлтийн хуулиуд хэлбэрийн хувьд Монолд нийцэхээргүй байсанч хууль, тогтоомж гаргах практикдаа үндэс болгосон. Ийнхүү 1961 оны 12-р сарын 8-ны Холбоотын "Зөвлөлт холбоот улсын болон Бүгд найрамдах улсуудын Иргэний хууль, тогтоомжийн үндсэн зарчмууд" гэгдэх хуулийг дагаад 1963 оны 2-р сарын 9-ний Монголын Иргэний хууль гарсан⁴⁹. Ангилалын хувьд тухайн үеийн барууны хуулиудад нилээд ойртсон. Ажиглагдсан нэг зүйл бол энэ гурван бүлэг нь оюуны өмчид зориулагдсан байх ба олон улсын иргэний эрх зүй нь тусдаа нэг хэсэг болон орсон байдаг⁵¹.

Өөрчлөлтийн дараа хуучин социалист орнуудад иргэний эрх зүйн шинэтгэлд ихээхэн анхаарал хандуулсан. Ийнхүү 1994 онд Монголд шинэ Иргэний хууль, мөн 1994/1995 онд төстэй, өргөн цар хүрээтэй оросын Иргэний хууль тус тус батлагдсан⁵². Эдгээр хуулиуд нь эх газрын эрх зүйн системд агуулгын хувьд тулгуурлах төдийгүй⁵³ системчлэлийн хувьд багахан л өөрчлөгдсөн. Энэ хуулийг эдийн засгийн амьдралын шинэ шаардлагад нийцүүлэн, ялангуяа гэрээний шинэ төрлүүдийн оруулсан байхад оюуны өмчтэй холбоотой зохицуулалтууд нь бас л голчлон бие даасан хуулиудад орсон байдаг. Ижил хэлбэрийн хуулиуд жишээлбэл Узбекистан⁵⁴, Киргизид батагдсан. Мөн Гурж⁵⁵, Туркменистаны⁵⁶ Иргэний хуулиуд ойрын хамаатнууд нь юм. Өмнө нэрлэсэн хуулиудтай харьцуулахад эдгээр нь оюуны өмчийн зохицуулалтуудаа тусгай хуулинд хийж өгсөн, шинэлж гэрээний

хэлбэрүүд болох Лийзинг, Франчайзинг зэргийг тусгасан бөгөөд хэрэглэгчдийн эрхийг хамгаалахад ихээхэн анхаарлаа хандуулсан байдаг. Өмчийн эрх зүй мөн эрх зүйн техникийн хувьд илүү нарийн зохицуулагдсан. 1997 оноос хойш боловсруулагдаж буй монголын Иргэний хуулийн шинэ төсөл мөн энэ чиглэлд бэлтгэгдэж байгаа бөгөөд хэрэггүй нарийвчлалаас татгалзах хэлбэрээр, мөн оюуны өмчийн эрх зүйг тусгай бүлэг болгохгүйгээр илүү ойлгомжтой, тодорхой болгохыг эрмэлзсэн юм. Харин ерөнхий ангийг эд юмсын эрх зүйтэй нэг бүлэгт оруулсан нь ухарсан алхам болж байгаа.

6. Тулгамдсан асуудлууд: Ромын эрх зүйн институтын системээс өнөөдрийн монголын иргэний хуулийн төсөл хүртэл их урт зам туулагдсан. Гайхан бахархуштай нэг зүйл нь бол институтын хэмээх энэхүү систем нь 13-р зуунаас 19-р зуун хүртэл хүчтэй өрсөлдөөнд оршин байж өнөөдрийг хүртэл эх газрын эрх зүйн бүлэгт голлох байрыг эзэлж байгаа явдал юм. Сүүлийн хоёр зуун жилийн гол шинэчлэлүүд нь иргэний эрх зүйг бие даасан кодификаци болгосон болон ерөнхий анги бий болгож хувь этгээдийг гэр бүлийн эрх зүйгээс, эд юмсын эрх зүйг өв залгамжлал, үүргийн эрх зүйгээс тус тус зааглаж өгсөн (үүргийн ерөнхий ангийг бий болгох замаар) салгасан, мөн түүнчлэн бусад хуудлааны эрх зүй, хөдөлмөрийн эрх зүй, оюуны өмч болон коллизийн эрхийг нэгтгэсэн зэрэг болно.

Дээрх зүйлүүдийн ихэнх нь эх газрын эрх зүйн бүлэгт нийтээр бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн. Зарим шийдвэрлэгдээгүй байгаа асуудлууд удахгүй хөндөгдөх юм.

Хуулинд ерөнхий ангийг бие даалган норм болгосон⁵⁷ нь илүү тодорхой болгох ба хуулийн бусад хэсгийг ихээхэн хөнгөвчилж өгч байгаа юм⁵⁸; ихэд тархсан хандлага болох Нидерландын загвараар төгсгөлд нь тодорхой тусгай асуудлуудыг нэгэн бүлэг болгон оруулдаг явдал нь хувь этгээдийн болон гэр бүлийн эрх зүй, эд юмсын, үүргийн эрх зүй болон өв залгамжлал гэсэн дөрвөн категорит хуваадаг ангилал нь хангалтгүй болохыг харуулж байна. Нөгөөтэйгүүр ерөнхий анги нь үндсэн зарчмуудаа тодорхойлохоосоо илүү хэт хийсвэр болж хувиран эргээд бие даасан ойлголтуудын хоорондын ялгааг харагдахааргүй болгох аюул бий. Үүний нэг жишээ бол германы Иргэний хуулийн ерөнхий ангийг дотор нь хувааж гэрээний зарим төрлүүдтэй холбоотой зүйлүүдийг оруулж ирсэн байдаг⁵⁹ ба зарим чухал ач холбогдол бүхий ерөнхий зарчмууд ерөнхий хэсгээс гадуур тусгагдсан байх зэрэг болно⁶⁰.

Гэр бүлийн эрх зүйн системчлэл мөн л нэг ижил болж тогтворжиж чадаагүй байна. Германы иргэний хууль гарснаас хойш нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн гэр бүлийн эрх зүйг хувь этгээдийн эрх зүйгээс зааглаж өгсөн нь гол бэрхшээл нь биш юм; хувь этгээдийн эрх зүй нь эцсийн эцэст үүргийн харилцаанд ч өмчийн асуудалд ч эсвэл өв залгамжлалд ч зарчмын ач холбогдолтой. Хуучин социалист орнуудад харин гэр бүлийн эрх зүй нь бие даасан хэлбэртэй болж тогтворжсон байдаг. Энэ нь үнэн хэрэгтээ зөвлөлтийн эхэн үеийн хууль, тогтоомжийн түүхтэй холбоотой нэгэн тохиолдлын зүйлээс шалтгаалсан байдаг⁶¹. Францын Наполеоны кодексе болон австрийн Иргэний ерөнхий хууль зэргээс ялгаатай нь тэнд германы Иргэний хуулийн шийдлийг уламжлан гэр бүлийн эрх зүйн холбогдолтой заалтуудыг нийт кодексечилсэн нэг бүлэг болгож оруулахаар төлөвлөсөн байсан⁶². Сүм хийдийн нөлөөнд ихэд автсан байсан гэр бүлийн хуулийг шинэчлэхийн онцгой ач холбогдол,

хуулийн бүлгүүдийн боловсруулалтын ялгаатай түвшин хэргээс шалтгаалан оросын Иргэний хуулийн өнөөгийн шинэчлэл хийгдэж байгаатай нэгэн адилаар хэсэг хэсгээрээ батаагдахад хүргэсэн⁶⁶. Сүүлд энэхүү зааг нь гэр бүлийн харилцаанд социалист үзэл баримтлал бүхий хүмүүжлийн шинэ чанартай онцлогийг бий болгох шаардлагаар хана болж хувирсан. Ийнхүү өргөжиж байсан зохицуулах хүрээ нь нийтийн эрх зүйн асуудалд хүрсэн⁶⁷. Энэхүү уламжлалыг Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль бусад шилжилтийн орнуудын нэгэн адил үргэлжлүүлж байгаа⁶⁸. Энэ нь өөрийн гэсэн давуу талтай бөгөөд хуульч биш хүмүүст болон туршлага багатай практик ажилтнуудад ном сурах, бичиг ховор байдаг утгаар янз янзын салбарт гэр бүлийн эрх зүйн нормуудад хэрхэн тусгагдаж байдгийг ойлгуулахад дөхөмтэй болгож байгаа юм. Нөгөөтэйгүүр энэ холимог байдал цаашид мөн адил хэвээр байх эсэх нь эргээзэвтэй⁶⁹. Өнөөдөр Монголд тухайлбал хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын эрх, үүрэг мөн эцэг, эхийн эрх, үүрэгтэй холбоотой зохицуулалтууд нь Гэр бүлийн хуулинд байх төдийгүй Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулинд давхар байх жишээтэй⁷⁰. Гэр бүл, гэр бүл салалттай холбоотой үүсдэг өмчийн эрх зүйн үр дагаварыг хэдийнээ Иргэний хуулинд хамааруулчихсан байдаг нь⁷¹ бие даасан, нэгдмэл бүтэц бүхий гэр бүлийн эрх зүйн концепцийг эвдэж байгаа төдийгүй мөн энэ хоёр материйн салшгүй болохыг тов тодорхой хэлж өгч байгаа хэрэг мөн юм.

Гэр бүлийн эрх зүйтэй адилхан байдал *хөдөлмөрийн эрх зүйл* ажиглагдана. Хөдөлмөрийн эрх зүй ба иргэний эрх зүйн хоорондын ялгаварлал нь үндсэндээ бий болсон түүх буюу боловсруулагдсан цаг хугацаагаар тайлбарлагдаж байхад италийн *Codice civile* энэ хоёр зүйлийн хэрхэн амжилттай хослуулж болохыг харуулсан. Гэхдээ олон оронд энэ хоёр нь ялгаж хөгжүүлсэн ба нэгтгэж ойлгох аргагүй харагддаг. Учир нь хөдөлмөрийн эрх зүй нь практикийн өндөр ач холбогдолтой бөгөөд ихээхэн уян хатан матери юм. Гэр бүлийн эрх зүйн нэгэн адил хөдөлмөрийн эрх зүй нь хуучин социалист орнуудад иргэний эрх зүйгээс тусдаа хөгжиж байгаа бөгөөд иргэний эрх зүйн элементүүд, нийтийн эрх зүйн элементүүдийн ялгаа улам бүр гүнзгийрч байна.

Италийн *Codice civile* гэгдэх хуулийн загварчилсанчлан мөн германы Иргэний хуулийн уламжлал авсан зүйл болох худалдааны эрх зүйг тусгаарласан явдал нь цаг хугацааны явцад нийгэм, эдийн засгийн хөгжилд эерэгээр нөлөөлж итали загвар нь зөв болох нь харагдсан⁷². Мөн түүнчлэн иргэний эрх зүйн шинэчлэл зүйлүүд болох хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалахад чиглэсэн зохицуулалтууд, гэрээний шинэ төрлүүд болох Лийзинг, Франчайзинг зэрэг нь орчин үеийн иргэний эрх зүйн хөгжилд хамаарна. Харин оюуны өмчийн зохицуулалтууд нь иргэний кодификацнас улам бүр холдож байна. Энэ нь тухайлбал патентын болон тэмдэг, нэрийн эрх зүйн салбарт материаллаг эрх зүй гэхээсээ илүү процессийн холбогдолтой асуудлууд гарч байгаагаас харагдана⁷³. Коллизийн эрх зүйг бие даалгасан явдал нь нэг давуу талтай бөгөөд энэ нь ямар нэгэн шаардах эрх үүсэхээс аваад гүйцэтгэлдээ хүрэх хүртэл ямар үе шатуудыг дамждаг болох уялдаа холбоотойгоор тодорхой үзүүлдэгт оршино. Нөгөөтэйгүүр коллизийн эрх зүйн аспектүүдийг гол гол хуулиндаа оруулснаар тухайн тохиолдол болгоны үндсэн шинжийг ойлгоход дөхөмтэй. Олон улсын эрх зүйг хуулийнхаа төгсгөлд оруулсан нь сайн шийдэл гэж үздэг.

Энэ бүх зүйлийг авч үзсэний дараа өнөөдрийн боловсруулагдаад байгаа шинэ иргэний хуулийн төсөлд нь монголын эрх зүйн уламжлал болон орчин үеийн олон улсын эрх зүйн шинэчлэх ухааны өнөөгийн байдал хоёрын дундуур хийж буй компромис алхам болох нь ойлгогдоно.

7. Тогссалын үз Дахин нэг эргэж харахад эдийн засгийн хөгжил болон иргэний эрх зүйн шууд холбоо харагдана. Эдийн засгийн харилцаа хөгжихийн зэрэгцээ иргэний эрх зүй ч мөн түргэн хөгжиж ирсэн; заримдаа эдийн засгийн хөгжилд зайлшгүй шаардлагатай эрх зүйн орчныг нь бүрдүүлэх хэлбэрээр, заримдаа зүгээр л эдийн засгийнхаа шаардлагыг дагах хэлбэрээр. Өмнө нь яригдсан зүйлүүдийг эргэж харахад энэхүү процесс нь дуусах болоогүй болох нь ойлгогдоно.

¹Институтын систем нь грек үндэстэй гэж үздэг тухайд, Вийакер, SZRom70 (1953), х.93-, х.115-.

² К.Муциус харин өв залгамжлалын эрх зүйг бие даасан хэсэг болгосон байдаг, Шульд, Түүх, х.187-, 191; Шерилло, Sistema civilistico, х.454-.

³ Лийбе, Хуулийн сургуулиуд, х.232-, Грайнер, Opera Neratii, х.130-, Кнотель, IURA 25 (1974), х.157-

⁴ Гайус, Institutiones; Шульд, Түүх, х.191.

⁵ Дулкайт, /Шварц/ Вальдштайн, Ромын эрх зүйн түүх, 33 III (а), х.229; Шульд, Түүх, х.199:

Гузман Бриго, Sisternatica, х.320; Белло I, х.393-, Zur System weiterer römische Autoren, Шерилло, Sistema civilistico, х.446-.

⁶ Казер, Ромын тусгай эрх зүй, Бд. I, 112 I I, х.474.

⁷ Казер, Ромын тусгай эрх зүй, Бд. I, 112 II, х.474.

⁸ Казер, Ромын тусгай эрх зүй, Бд. I, 112-р зүйлийн I, х.476.

⁹ Ерс/Кункель, Ромын тусгай эрх зүй, 7-р зүйл, х.11.

¹⁰ Дулкайт/Шварц/Вальдштайн, Ромын эрх зүйн түүх, 43-р зүйлийн I 4, х.279; Ленель, Ediktum Perpetuum, х.7; Лийбе, Hermoginianus, х.26-.

¹¹ Monumenta Germaniae Historiae, Legum Sectio I, Бд. I, Цоймер, 1902. Испани орчуулга нь d'Ors, Codex Euricianus, герман орчуулга нь Вольхаунтер, Өрнийн готуудын хуулиуд; Савес, Histotia, х.47-.

¹² Хаенель, Lex Romana Visigothorum, 1849 (дахин хэвлэлт 1962) анхим дарааллаараа (хурайнгуулсан эх сурвалжаар нь дарааллуулсан гэсэн үг); мөн Breviarium Alaricianum, системчилэлд тулгуурласан шинэ журам; Савес, Historia, х.47-.

¹³ Латин/ герман хэл дээр Вольхаунтер, Өрнийн готуудын хуулиуд, х.33-.

¹⁴ Крюгер, Түүх, х.295, 351.

¹⁵ Ангилал нь Коурат, Breviarium Alaricianum, х.IX.

¹⁶ Рауххаунт, Түүх, х.52; Ванцэ, Hispanic-American Law, х.59.

¹⁷ Handbuch Privatrechtsgeschichte I/Armin Wolf, х.671; Рауххаунт, Түүх, х.98.

- ¹⁸ Рязановски, Fundamental Principles of Mongol Law, Qingdao 1937, х.83-; Alinge, Монголын хуулиуд, Лайпциг 1934, х.40-; Хойшерт, Die Gesetzgebung der Qing für die Mongolen im 17. Jahrhundert, Вийзбаден 1998, х.18-.
- ¹⁹ Alinge, Монголын хуулиуд, Лайпциг 1934, х.27-.
- ²⁰ Alinge, Монголын хуулиуд, Лайпциг 1934, х.42-.
- ²¹ Франке/Гвинтчет, The Cambridge History of China, 6, Cambridge 1994, х.453.
- ²² н. Оюунбаяр, Education, Ulan Bator Post, 08.09.1999, х.3-т эзэнт гүрний бүх үндэстэн, ясны ашиг сонирхлыг харгалзсан гэсэн байдаг.
- ²³ Alinge, Монголын хуулиуд, Лайпциг 1934, х.2. Гол текст нь барууны аль нэг хэлэнд орчуулагдаагүй байна.
- ²⁴ Alinge, Монголын хуулиуд, Лайпциг 1934, х.37.
- ²⁵ Цэнджав, Mongolia's old law teaches new lessons, Ulan Bator Post, 29.09.1999, х.4, Рязановски, Fundamental Principles of Mongol Law, Qingdao, 1937, х.57-; Alinge, Монголын хуулиуд, Лайпциг 1934, х.102- мөн 135-.
- ²⁶ Рауххауит, Түүх, х.113: *Lalinde, Iniciacion, 1832-р зүйл; Iglesias Ferreiros, AHDE 50 (1980), х.560.*
- ²⁷ Рауххауит, Түүх, х.112.
- ²⁸ Рауххауит, Түүх, х.125.
- ²⁹ Хууль тогтоомж батлан гаргаж байсан түүхийн хувьд *Вийакер, Privatrechtsgeschichte, х.326-; Фрийдл, СМВС, х.1-;* герман хэл дээр бичигдсэн кодификацийн түүхэн үндсийн хувьд *Гузман Брито, Fijacion, х.54-.*
- ³⁰ Фрийдл, СМВС, х.137; *Шлоссер, Privatrechtsgeschichte, х.52.*
- ³¹ СМВС-ийн 3, 4 ба 12-р зүйлүүд.
- ³² W.X.A.v.Kreittmayr, Anmerkungen über den Chur-bayrischen Codocem Maximilianicum Civilem, 1754 оноос хойш олон удаа шинэчлэгдэн хэвлэгдэж байсан.
- ³³ Lira Urquieta, Introduccion al Godigo civil de Andres Bello, Caracas 1952, х.XIX.
- ³⁴ Германы Бадэн ванлигт (1810), Сицилийн хаант улсад (1819), Швейцарийн Ваадт кантонд (1821), Сардини ба Пимоны хаант улсад (1837), Нидерландад (1938), сүүлд АНУ-ын Луизиана мужид 1808/1828 болон латин америкийн орнуудад нэгэн адил. Францын мэдэлд байсан зарим нутагт, ялангуяа Бельги, Райн мөрний баруун эргийн нутгуудаар болон швейцарийн Женев кантонд Наполеоны кодекс ангилалын хувьд өөрчлөгдөлгүй хүчин дөгөлдөр үйлчилж байсан.
- ³⁵ Сант-Иосиф, Concordance entre les codes civils etrangers et le code francais, 1840 оноос хойш маш олон удаа шинэчлэгдэн хэвлэгдэж байсан, мөн Парис хотноо 1840 онд, Брюссельд 1842 онд, Парис/Лайпциг 1856 болон испани орчуулга нь Мадрид 1852 онд тус тус гарсан.
- ³⁶ Фенет, Recueil I, х.15.
- ³⁷ Энэ хуулинд илүү процессийн болон шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн агуулгатай заалтууд орсон; жишээлбэл нотлох баримттай холбоотой заалтууд 1315-р зүйл эсвэл шүүхийн албадан дуудлага худалдааны тухай заалтууд 2204-р зүйл.
- ³⁸ Эх газрын эрх зүйн бүлгийн хууль тогтоомжийн хөгжил, улс орнуудад хийгдсэн томоохон шинэчлэлүүдийг Неллегийн, Андрэс Беллогийн Чилийн

Иргэний хуулийн үүсэл, нөлөөлөл, Франкфурт, 1987, х.93-, мөн Патти, Ирэгний хуулийн зуун жил: Гэр бүлийн эрх зүй, FamRZ 2000, х.1, 2.

³⁹ Соад, Монголын эрх зүйн хөгжил ба түүний онцлогууд, Шоллер, Хүний эрх ба үндэсний аюулгүй байдал, Мюнхен, 1998, х.27, 35.

⁴⁰ Соад, Монголын эрх зүйн хөгжил ба түүний онцлогууд, Шоллер, Хүний эрх ба үндэсний аюулгүй байдал, Мюнхен, 1998, х.27, 35.

⁴¹ Рауххаупт, Geschichte der spanischen Gesetzesquellen, Хайделбэрг, 1923, х.196, Vance, The Background of Hispanic-American Law, Вашингтон 1937, х.126.

⁴² Соад, Монголын эрх зүйн хөгжил ба түүний онцлогууд, Шоллер, Хүний эрх ба үндэсний аюулгүй байдал, Мюнхен, 1998, х.27, 35.

⁴³ Эртний монгол сэтгэлгээгээр хуулийг хуульчид мэргэжлийн нууц хэмээн үзэж хадгалдаг байсантай холбоотой болов уу, Alinge, Монголын хуулиуд, Лайпциг, 1934, х.36.

⁴⁴ Мөнхжаргал, Ирэгний эрх зүйн түүхэн уламжлал: БНМАУ-ын анхны иргэний хууль, Шиххутуг, 1/2000, х.17-, Сүрэнхүү, Анхны иргэний хуулийн тухай товчон, Шиххутуг, 1/2000, х.18-, Батлер, The Mongolian Legal System, Гаг 1982, х.266, Позняков/Кемпер, Азийн социалист орнуудын иргэний эрх зүй - БНХАУ, БНСАУ, БНМАУ-ын иргэний эрх зүй, Берлин 1959, х.100. Хуулиудын нэг онцлог нь жирийн ирэгдэд энгийн жишээгээр хуулийг ойлгуулах, Позняков/Кемпер, Азийн социалист орнуудын иргэний эрх зүй - БНХАУ, БНСАУ, БНМАУ-ын иргэний эрх зүй, Берлин 1959, х.101. 19-р зууны латин америкийн эрх зүйд адилхан байдлаар хуульчлах явдал байсан, Нелле, Андрес Беллогийн Чилийн иргэний хуулийн үүсэл, нөлөөлөл, Франкфурт, 1987.

⁴⁵ Чимид, Тохирсон эрх зүйн системдээ тулгуурлах нь эрх зүйн шинэтгэлийн амжилтын үндэс мөн, Улаанбаатар, х.15, Poucha8 Mongolia, International Encyclopedia of Civil Law, Тюбинген 1974, х.М-86. Монголын эрх зүй нь 1922 оны оросын иргэний хуулийн нэгэн адил хувийн хэвшлийг тусгасан байдаг, Брендель, Оросын Ирэгний хууль, JOR XXXVI (1995), х.205.

⁴⁶ Соад, Монголын эрх зүйн хөгжил, түүний онцлогууд, Шоллер, Хүний эрх ба үндэсний аюулгүй байдал, Мюнхен 1998, х.27, 38.

⁴⁷ Alinge, Монголын хуулиуд, Лайпциг 1934, х.61.

⁴⁸ Сүрэнхүү, Анхны иргэний хуулийн тухай товчоон, 1/2000, х.18-.

⁴⁹ Шрёдер, Das neue Bürgerliche Gesetzbuch der Russischen Sowjetrepublik, ROW 1965, х.1. Zur Vorgeschichte des Rahmengesetzes, Толстой, Богуславски/Книппер, Wege zu neuem Recht, Берлин 1998, х.159, 160-.

⁵⁰ Батлер, The Mongolian Legal System, Гаг 1982, х.266, Poucha, Mongolia: International Encyclopedia of Civil Law, Тюбинген 1974, м-87-, Амарсанаа, Монголын иргэний хууль, тогтоомжийн өнөөгийн байдал: Богуславски/Книппер, Wege zu neuem Recht, Берлин 1998, х.86-.

⁵¹ Батлер, The Mongolian Legal System, Гаг 1982, х.268-.

⁵² Бергманн/Глэкнер, WiRO 1995, х.445-, Шмидт/Вебер, WiRO 1996, х.86-.

⁵³ Бергманн/Глэкнер, WiRO 1995, х.445.

⁵⁴ Рахманкулов/Азиев/Убайдуллаев: Богуславски/Книпперийн, Wege zu neuem Recht, Берлин 1998, х.35-.

⁵⁵ Чантурна: Богуславски/Книпперийн, Wege zu neuem Recht, Берлин 1998, х.35-.

⁵⁶ Кадыров: Богуславски/Книпперийн, *Wege zu neuem Recht*, Берлин 1998, х.89-, Книппер, WiRO 2000, х.53-.

⁵⁷ Нэгэн Ерөнхий алгн бий болгосон санхүүг хувьд, *Вийакер*, *Privatrechtsgeschichte*, х.318-, мөн *Шварц*, *SZRom* 42 (1921), х.588-.

⁵⁸ Хэж, *AcP* 146 (1941), х.8.

⁵⁹ Энэ талаар *Белло* 1847 оны төсөлтэй холбогдуулж хоон хэлэлцэх хугацаа гэж мэт зарим тодорхой асуудлууд үүргийн эрх зүйтэй холбогддог болохоороо дөрөвдүгээр бүлэгт орсон биш харин кодекечилдлын төсөлд хамаарах учраас орсон гэж тайлбарласан байдаг, *Белло*, *Obras Completas XIII*, х.1377.

⁶⁰ Вийакер, *Privatrechtsgeschichte*, х.487; Сри-ийн (1984) компромисс шийдэл (хэлллийг бие даасан бүлэг болгосон) нь энэ сөрөг талыг үгүй болгож чадахгүй бөгөөд харин ч бүр сөрөг нөлөөг ихэсгэж байгаа: Тодорхой гэрээгүүдийн хувьд эрх зүйн үйлдэл, шаардах эрх, шаардах эрхийн үндэслэлтэй холбоотой заалтууд (сүүлийнх нь мөн л гэрээний ерөнхий хэсэг, нэрлэгдсэн гэрээнд хуваагдсан байдаг) хамтдаа уншигддаг байх ёстой.

⁶¹ Вийакер, *Privatrechtsgeschichte*, х.488.

⁶² Ваелер, *Neues sowjetisches Familienrecht*, *FamRZ* 1968, 557, 559, FN 34.

⁶³ Паттн, *FamRZ* 2000, Германы Иргэний хуулийн 100 жил: Гэр бүлийн эрх зүй, х.1, 2. Гэхдээ эдгээр хуулиудад Гэр бүлийн эрх зүй нь иргэний эрх зүйд хамаарах тухай огт дурыдагддаггүй байдаг, Паттн, 1926/1929 оны монголын Иргэний хууль нь мөн энэ шийдлийг дагасан байдаг, Батлер, *The Mongolian Legal System*, Гаар 1982, х.383.

⁶⁴ Ваелер, *Neues sowjetisches Familienrecht*, *FamRZ* 1968, 557, 559.

⁶⁵ Фройнд, *Das Zivilrecht in der Sowjetunion*, Манххайм 1927, х.9-.

⁶⁶ Бергмани/Глэкнер, *WiRO* 1995, х.445-, Шмидт/Вебер, *WiRO* 1996, х.86-.

⁶⁷ Социалист бүлгийн орнуудад нийтийн болон хувийн өмч ялгаа байхгүй гэж үздэг байсан, Давид/Трасмани/Вестен, *Einführung in die großen Rechtssysteme der Gegenwart*, 2 дах хэвлэл, Мюнхен 1998, др.200.

⁶⁸ Орос: Липпонт, Оросын Гэр бүлийн болон Олон иргэний эрх зүй байдлын талаар, *FamRZ* 1998, х.663, Чехид: Бохата, *JOR* 1999 (XL), 37-, Унгар: Загель-Грандэ, *Оттоуа*, *ROW* 1997, 1-, Туркменистанд: Книппер, *WiRO* 2000, х.53, 54.

⁶⁹ Дараагийн нэг холмдсон зүйл нь процессийн зохицуулалтууд юм, гэр бүлийн нухай хуулийн 23-р зүйлийн 2.

⁷⁰ Чехид энэ асуудал ихээхэн шүүмжлэлтэй байгаа, Бохата, *JOR* 1999 (XL), 37, 55, мөн Украин дах байдлыг харьцуулж болно; Довгерт/Кушечова: Богуславски, Книпперийн, *Wege zu neuem Recht*, Берлин 1998, х.99, 109. Бүүр социалист үеэс өнөөдрийг хүрсэн бусад шүүмжлэлүүдийг, Ваелер, *Neues sowjetisches Familienrecht*, *FamRZ* 1968, 557, 559.

⁷¹ Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 10 ба дараах зүйлүүд.

⁷² Оросын шинэ Гэр бүлийн хуулийн 38-р зүйл системчиллийн хувьд илүү зөвөөр энэ салбар хэсгийг тусгасан, мөн хуучин БНАГУ-ын Гэр бүлийн хуулийн 13-р зүйлд нэгэн адил.

⁷³ Книппер: Богуславски/Книпперийн *Wege zu neuem Recht*, Берлин 1998, х.136, 137.

⁷⁴ Бергмани/Глэкнер, *WiRO* 1995, х.477, Книппер, *WiRO* 2000, х.55.

ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДИЙН ЭД ХӨРӨНГНИЙН ХАРИЛЦААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Дамбадаржаагийн ОЮУНЦЭЦЭГ

"Шихихутуу" Хууль Зүйн Дээд Сургуулийн захирал

Хууль зүйн ухааны магистр

Нэг. Гэр бүлийн гишүүд өмчийн харилцааны субъект болох нь.

Орчин үед гэр бүл, эх, нялхсын тухай асуудал нь зөвхөн нэг улс үндэстний бус дэлхий нийтийн шинж чанартай асуудал болон хурцаар тавигдаж байна. Энэ нь нийгэм, улс төр, эдийн засгийн болон бусад үйл ажиллагаа даяарчлах чиг хандлагатай холбоотой. Иймээс ч Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 1948 оны 12 дугаар сарын 10-нд баталсан "Хүний эрхийн түгээмэл тунхаглал"-д: эрэгтэй, эмэгтэй хоёр хүн чөлөөтэй, харилцан бүрэн зөвшөөрсөн нөхцөлд гэрлэж болно. Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй¹ гэж заасан байна. Мөн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын фактад /1996, 1974/ "Нийгмийн үндсэн нэгжийн хувьд, мөн гишүүдийн, нзи ялангуяа хүүхдийн өсч бойжих, аж төрөх жам ёсны орчныг нь хувьд гэр бүлийг нийгмийн хүрээнд үүргээ бүрэн хариуцаж чадахуйцаар хамгаалж, тэтгэн дэмжих ёстой"² гэж тунхагласан юм.

Монгол Улсын Үндсэн хуульд: "Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн эрх ашиг сонирхлыг төр хамгаална."³ гэж гэр бүлийн харилцааны хүрээнд дэх суурь зарчмыг тунхаглан бэхжүүлсэн. Энэхүү зарчмыг нийгмийн амьдралын тодорхой хүрээнд улам нарийвган тодотгож, бусад хуулиудаар гэр бүлийн гишүүдийн эрх, ашиг сонирхлыг хангах, хамгаалах чиглэлээр олон зохицуулалтыг тогтоожээ.

Гэр бүлийг бэхжүүлэх, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгө, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, үр хүүхдийн эрх ашгийг хамгаалах нь өнөө үед нийгмийн ач холбогдол бүхий чухал асуудал болон тавигдаж, эд асуудалд хандах төр, олон нийт, судлаачдын хандлага улам өргөсөх болов.

Гэр бүлийн хүрээнд дэх эд хөрөнгийн харилцаа, түүнд хүүхдийн оролцоо, эдлэх эрхийн талаар манайд тухайлан судалсан судалгаа, бичиж нийтлүүлсэн бүтээл бараг байхгүй гэж хэлж болно. Харин гэр бүлийн хуулийн тайлбар⁴, гарын авлага⁵ хэвлэгдэж байсан.

¹ Хүний эрх: Олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн эмгэгэл. УБ, 1996, 5 дая тал.

² Мөн эмгэгэл

³ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйл.

⁴ Гэр бүлийн хуулийн тайлбар. Ред Д. Бундуй, Н. Чинбат. УБ, 1984

⁵ Т. Манжаргал, Гэр бүлийн эрх зүй УБ, 1986

Гэр бүлийн доторхи эд хөрөнгийн харилцаанд гэрлэгддээс гадна гэр бүлийн бусад гишүүд ч оролцдог. Үүнтэй уялдан гэр бүлийн гишүүн гэдэгт хэн багтах вэ? гэдгийг тодруулан авч үзье.

Гэр бүл ба гэр бүлийн гишүүдийн талаар XIX зууны Оросын нэрт иргэний эрх зүйч Г.Ф.Шершеневич: Гэр бүл бол эхнэр, нөхөр, хүүхдийн байнгын хамтын амьдралын орчин, өөрөөр хэлбэл гэрлэлтээр холбогдсон этгээдүүдийн нэгдэл юм¹ гэж бичсэн нь гэр бүл, түүний гишүүдийн холбоосыг биологийн талаас нь тодорхойлсон явдал хэмээн ойлгож болох юм.

Монгол улсын Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.4-т Гэр бүлийн гишүүн гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл садангийн хүнийг тооцно гэж анх удаа тодорхойлжээ.

Монгол Улсын шинэчлэн найруулсан Иргэний хууль, Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томъёоны дагалга болон бусад хуульч, эрдэмтэд, судлаачдын бичсэн ном зохиолд бичсэн тодорхойлолтуудаас үндэслэн гэр бүлийн гишүүн гэсэн ойлголтын агуулгыг илэрхийлэх шинжүүдийг дараахь байдлаар тодорхойлон авч үзэж болох юм. Үүнд:

1. Гэрлэлт буюу төрлийн холбоо
2. Байнгын хамтын амьдрал ба хамтын ахуй
3. Бие биенийхээ өмнө харилцан эдлэх эрх, хүдээх үүрэг
4. Эд хөрөнгийн болон сэтгэл санааны нийтлэг хэрэгцээ, эрх ашиг
5. Өрхийн доторх ам бүлийн албан ёсны бүртгэл гэх мэт шинжүүдийг

нэрлэж болно. Эдгээрээс дүгнэн үзвэл, "Гэр бүлийн гишүүн гэдэг нь өөр хоорондоо эд хөрөнгийн болон амни хувийн шинжтэй эрх үүргээр холбогдсон байнгын хамтын, хамтын ахуйтай материаллаг болон оюун санааны нийтлэг хэрэгцээ, ашиг сонирхолтой, өрхийн ам бүлийн албан ёсны бүртгэлд бүртгэгдсэн, гэрлэлт буюу төрлийн холбоонд үндэслэсэн хүмүүсийн нэгдэл" юм гэж тодорхойлж болох юм.

Гэр бүлийн гишүүдийн хооронд олон төрлийн харилцаа үүсэх бөгөөд тэдгээрийн салшгүй нэг чухал хэсэг нь эд хөрөнгийн харилцаа, түүнд үндэслэн үүсч хэрэгжих эрх, үүргийн тухай асуудал болно.

Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгө, өөрөөр хэлбэл гэр бүл эд хөрөнгөтэй байх, түүнийгээ захиран зарцуулах, өмчлөх, өв залгамжлуулах гэх мэт асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжид тусган, хэрхэн зохицуулж ирснийг авч үзье.

Монголд 1926 оноос эхлэн Иргэний хуулийг Засгийн газрын хууль тогтоох комиссоос эрхлэн боловсруулж бүлэг, бүлгээр баталж 1929 онд Шүүх яамнаас анх удаа системчлэн хэвлүүлсэн юм.²

Уг хуулийн 61 дүгээр зүйлд: Эр эм бололцсон этгээдүүд урьдын хувийн хогшил нь тус тус байхаас гадна, эр эм бололцсоны хойно хураасан зүйлүүдийг хамтын хөрөнгө хогшилд тооцмой. Хэрэв хамтын хөрөнгө хогшилыг завсар хураахад үл тохирон тэмцэх зүйл гарваас шүүх таслах газраас тогтоовоос зохимой" гэж заажээ. Энд нэг зүйлийг зориуд тэмдэглэхэд, 1926 оноос өмнөх хууль тогтоомж, эртний Монголын хууль цаазын дурсгалт

¹ Ард түмнээс юуны өмнө чухалчлан танилцаж биелүүбээс зохих хууль, дүрмүүдийг эмхэтгэсэн дэвтэр. 1929.УБ.Шүүх яамны хэвлэл, монгол бичгээр/ Монгол Улсын анхны иргэний хууль. 2000 он.

бичгүүд, "Их засаг", "Халх журам", "1640 оны Монгол ойрдмн цааз" гэх мэт хуулиудад гэр бүлийн өмч, өв өвлөх талаар ямар нэг заалт байгаагүй гэсэн хэрэг биш юм. Энэ талаар судалсан нь ч бий.

Дээрх Иргэний хуулийн заалтаас харахад гэр бүл дэх эд хөрөнгийг нэгдүгээрт, гэрлэгчдийн гэр бүл болохоос өмнөх, хоёрдугаарт, гэр бүл болсны дараа бий болсон эд хөрөнгө гэж хоёр хувааж хуульчилсан бөгөөд энэ нь монголын хууль цаазны түүхэнд анх удаа тусгасан хэрэг юм. Түүнчлэн энэ хуулийн 61 дүгээр зүйл: "Эр эм хоёр алтвал хогшлын тухай завсарт хууль ёсоор гэрээ, хэлэлцээр байгуулж болмой" гэж заасан нь өнөөдөр бидний бичиж, яриад байгаа "эд хөрөнгийн гэрээ"-гэй дүйцэхүйц ойлголт гэж үзэж болно.

Энэ хуулийн гэр бүлийн эрхийн заалтууд манай дараа дараагийн хууль тогтоомжид уламжлагдан заагдсан ба үүнийг 1951 оны Гэрлэлт, гэр бүлийн тухай хууль, 1973 оны Гэр бүлийн тухай хууль, 1999 оны Гэр бүлийн тухай хуульд тусгагдсан зохицуулалт, түүний мөн чанараар тус тус тодорхойлж болох юм.

Гэр бүлийн тухай Монгол Улсын хуулийг 1999 онд Улсын Их Хурлын чуулганаар баталсан нь гэр бүлийн бие даасан хуулийн 3 дэх нь болсон бөгөөд тэдгээрээс нэлээд өвөрмөц шинэжтэй байгаа нь "Гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг Иргэний хуулиар зохицуулна" гэснээс өөр эд хөрөнгөтэй холбоотой заалт байхгүй байгаагаар холбоотой юм.

Үүнтэй холбоотойгоор Хууль зүйн шинжлэх ухаанд гэр бүлийн эрх зүйн залэх байр суурийг онолын хоёр чиглэлээр тайлбарлаж болно. Энэ нь, нэгдүгээрт, гэр бүлийн эрх зүй нь иргэний эрх зүйн нэг дэд салбар,¹ хоёрдугаарт, бие даасан салбар шинжлэх ухаан.² Миний бие дээрх концепцийн хоёр дахь чиглэлийг баримталсан болно.

Гэр бүлийн өмчийн эрх нь хууль зүйн шинжлэх ухаанд томоохон ойлголт, институт болох өмчийн эрхийн салшгүй хэсэг мөн. Иймээс гэр бүлийн эд хөрөнгө бий болох, түүнийг өмчлөх, ашиглах, захиран зарцуулах ажиллагааг өмчийн эрх зүйн онол, сэтгэлтээ, практик үйл явцаас салагдид авч үзэж болдоггүй. Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйл болон Иргэний хуулийн 80,90 дүгээр зүйлийг үндэслэн, гэр бүл дэх эд хөрөнгийг:

- а. Гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран өмчлөх дундын эд хөрөнгө
- б. Гэр бүлийн гишүүдийн хуваарьт эд хөрөнгө гэж хоёр хувааж үзнэ.

Эдгээр ангилалд хамаарах эд хөрөнгийг Иргэний хуулиас харж болох юм. Түүнчлэн Иргэний хуулийн 98 дугаар зүйлийн 4-д "Гэр бүлийн хөдөлмөрийн чадвартай гишүүнд оногдох эд хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо гэр бүлийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгө бүрэлдэхэд оруулсан түүний хөдөлмөрийн оролцоо, хөрөнгийн хэмжээг харгалзан багаасгах, эсхүл олгохгүй байхаар шүүх шийдвэрлэж болно" гээд дээрх заалт хамаарахгүй нөхцөл байдалд "Цэргийн жинхэнэ алба хаах, сургуульд суралцах, удаан хугацаагаар өмчлөх зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар дундаа хамтран өмчлөх эд хөрөнгө бүрэлдэхэд хөдөлмөрөөр буюу хөрөнгөөр оролцож чадаагүй бол" гэж заажээ. Энэ заалтад гэр ахуйн ажил эрхэлсэн,

¹ В.А.Резицка. Семейное право. М.1971. ст 9.

Е.М.Ворожейкин. Семейное право как самостоятельная отрасль права "Сов.гос.и.право"1967.№ 4

² Гражданское право. Часть 3. Под ред А.П.Сергеев, Ю.К.Толстой. М.1998. ст 205.

Т.Мөнхжаргал. Гэр бүлийн эрх зүй. 1996. УБ. 4 дэх тал.

хүүхдээ асарч хүмүүжүүлсэн гишүүний хөдөлмөрийг үнэлэх агуулгатай заалт оруулаагүй байна. Өөрөөр хэлбэл, "хөдөлмөрийн оролцоо" гэдэг ойлголтод хүүхэд асарсан, гэр ахуйн амжалт эрхэлсэн гэдэг ойлголт хамааралтай юу гэдэг нь ойлгомжгүй байгаа юм.

Гэр бүлийн хуваарьт болон дундын эд хөрөнгийн талаарх Өрнөдийн болон ОХУ, эрх зүйн нжил тогтолцоо бүхий ХБНГУ-ын хууль тогтоомжуудад тусгагдсан үзэл баримтлал болон энэ талаарх хуульч, эрдэмтдийн үзэл бодлыг авч үзэх нь сонирхолтой болов уу.

ОХУ-ын Иргэний хуулийн 34 дүгээр зүйлийн 1-д "Хамтын амьдралын явцад тэдгээрийн бий болгосон хөрөнгө нь дундын өмч болно". Хэрэв эхнэр нь гэрийн аж ахуй эрхлэх, хүүхэд асран бие даасан цалин, орлогогүй нөхцөлд гэрлэгсдийн худалдан авсан эд хөрөнгө нь дундын эд хөрөнгө болно /ОХУ-ын Иргэний хуулийн 39 дүгээр зүйлийн 1/ гэсэн заалтыг харж болох юм.

ОХУ-ын Иргэний хууль болон манай улсын Иргэний хуулийн зохих заалтуудыг харьцуулахад дундын болон хуваарьт өмчид хамаарах эд хөрөнгөнд тухайлбал, дундын өмчид оюуны өмчийн орлого, хуваарьт өмчид үнэт хэрэглэл, тансаг хэрэгслэний зүйлс хамаарахгүй гэсэн онцлог заалтууд байгаа ч /ОХУ-д/ дундын өмч нь гэрлэгчдийн хуваарьт эд хөрөнгөөс ялгагдах гол ялгаа нь "гэрлэгчээс хойш" гэдэг ойлголттой холбоотой гэдэгтэй аль аль нь санал нийлж байгаа юм.

Гэрлэгчид гэрлэхээс өмнө олж авсан орон сууц /гэр, хашаа, байшин/-ыг гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөд тооцож болохоор өөрчилсөн нь үгэхээр ул суурьтай, эмэгтэйчүүд, хүүхдийн эрх ашгийг хамгаалсан практик ач холбогдолтой заалт болсон билээ.

Гэр бүлийн гишүүд нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг эзэмшиж, ашиглах, захиран зарцуулах адил эрхтэй бөгөөд хоорондоо харилцан тохиролцсоны үндсэн дээр эд хөрөнгөө ашиглаж, захиран зарцуулдаг. Харин зөвшөөрлийг амаар бус бичгээр авч нотариатаар гэрчлүүлсэн байвал зохимжтой бөгөөд хуульд ийм заалт оруулж өгөх нь зөв юм.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 1425 дугаар зүйлд "Гэрлэгсдийн хэн нэг нь дундын эд хөрөнгөөс хэн нэгэнд бэлэглэх тохиолдолд нөгөөгийнхөө зөвшөөрлийг заавал авна. Энд ёс суртахууны аливаа хэм хэмжээ үйлчлэхгүй" гэж заасан байна.

Сүүлийн үед иргэн, гэр бүлийн эрх зүйн шинжлэх ухаанд ихээхэн яригдаж байгаа асуудлын нэг бол "эд хөрөнгийн гэрээ" болно.

Ф.Энгельс: "Өрх гэр, хувийн өмч, төрийн үүсэл" хэмээх зохиолдоо "Гэрлэлт нь хөрөнгөтний ойлголтоор гэрээ, хууль ёсны хэлэлцээр, тэгэхдээ энэ нь хоёр хүний насан туршийнх нь бие сэтгэлийн хувь заяаг шийдвэрлэх учраас бүх гэрээ, хэлэлцээрүүдийн дотроос хамгийн чухал нь юм"¹ гэж бичсэн байна.

Францын Иргэний хуулийн "Эд хөрөнгийн гэрээ ба гэр бүл бологсдын өмчийн харилцаа" гэсэн дөрөвдүгээр бүлгийн 1387 дугаар зүйлд: "Талууд гэрээндээ өөрөөр заагаагүй бол хуулиар зохицуулна", 1536 дугаар зүйлд: "Хэрэв талууд гэрээндээ хуваарьт эд хөрөнгийн талаар заасан бол тэд өөрсдийн хөрөнгийг эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бүрэн эрхтэй" гэжээ.

¹ К.Маркс, Ф.Энгельс. Зохиолуудын 23-р боть. 375 дэлг талд

ХБНГУ-ын Иргэний хуулийн "Гэр бүлийн эрх" гэсэн I дүгээр бүлэгт "Талууд /гэрлэгчид/ өөрсдийн эд хөрөнгийн харилцааг эд хөрөнгийн гэрээнд тохиролцож, нотариатаар гэрчлүүлнэ" гэж заасан байдаг.

ОХУ-ын гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд "Эд хөрөнгийн гэрээ нь гэр бүл болж байгаа, эсвэл гэрлэгчдийн эд хөрөнгийг өмчлөх эрх болон үүргийг заасан, гэрлэлт цуцалсан тохиолдолд тэдгээр эд хөрөнгийг маргаангүйгээр гэр бүлийн гишүүдэд хуваарилах тухай баримт бичиг юм" гэжээ. ОХУ-ын эрдэмтэн А.А.Иванов "Гэрлэлтийн гэрээ нь хоёр талын, урьдчилан тохиролцсон /консенсуальный/ байх бөгөөд гэрээг зөрчсөн тохиолдолд кариуцлага хэрэглэх гэрээний нэг төрөл" гэж бичсэн байна.

Эдгээрээс нэгтгэн дүгнэвэл:

Нээв, Гэрлэлтийн гэрээ нь гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах эрх зүйн боломжтой хэлбэр,

Хоёрт, Гэрээ байгуулах эсэх нь тэдний сайн дурын хэрэг,

Гуравт, Нэгэнт байгуулсан гэрээг өөрчилж болох мөн хэдийд ч цуцалж болох гэсэн утга санаа ндэрхийлэгдэж байна.

Манайд 1926 оны Иргэний хуульд гэрээний зохицуулалтын асуудал байсан ч практик үйл явц болоогүй юм. Одоогийн дагаж мөрдөж байгаа Иргэний хуулийн 168¹ дугаар зүйлд гэрлэгчдийн эд хөрөнгийн гэрээг зохицуулсан ч энэ нь зөвхөн гэрлэлтээ бүртгүүлэхийн өмнө байгуулахаар заасан нь учир дутагдалтай юм уу гэж үзэж байна.

Гэрээгээр эд хөрөнгийн бус харилцааг зохицуулахгүй байх ёстой бөгөөд хүүхдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн нөхцлийг зориуд оруулах нь зөв юм. Иймээс нэр томъёоны асуудал дээр хуульд заасан "Гэрлэгчдийн эд хөрөнгийн гэрээ"-г "Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн гэрээ" гэж өөрчлөх нь зүйтэй болов уу.

Гэрээг өөрчилж, цуцалж болно. Гэрээг цуцалснаар гэрлэгчдийн эд хөрөнгийн харилцааг хууль тогтоомжоор зохицуулах үр дагавар гарч ирнэ.

Хоёр. Гэр бүлийн өмчийн харилцаанд хүүхдийн оролцоо.

Гэр бүлийн эд хөрөнгийг ашиглах, захиран зарцуулах болон түүнийг гэр бүлийн гишүүдэд оногдох хэсгийг тодорхойлоход хүүхдийн эрх ашгийг онцлон авч үзэх хэрэгтэй юм. Энэ нь улс орны ирээдүйн хувь заяа бидний үр хүүхдийн хүмүүжил, боловсрол, тэдний эдийн засаг, эрх зүйн найдвартай баталгааг бий болгохыг шаардаж байна. Хүүхдийн асуудал бол манай орны төдийгүй олон улсын чанартай чухал асуудал бөгөөд 1989 оны "Хүүхдийн эрхийн тухай конвенц"-д: хүүхэд нь гэр бүлийнхээ дотор аз жаргалтай, хайр халамжтай бие биенээ ойлгодог нөхцөлд өсч бойжиж гэмээ нь бүрэн төгс, өв тэгш хөгжинэ чадна. Хүүхэд нь бие бялдрын болон оюун ухааны хувьд төгс, боловсронгуй байдгийг харгалзан, түүнийг төрөхийн өмнө ч, төрсний дараа ч тусгай асрамж, хамгаалалтыг, үүний дотор эрх зүйн зохих хамгаалалтыг шаарддаг² гэж оршил хэсэгтээ заагаад 27 дугаар зүйлдээ: Хүүхэд бүр өөрийн бие бялдрын, оюун ухааны, ёс суртахууны болон нийгмийн хөгжлийг хангахуйц түвшинд амьдрах эрхтэй. Эцэг, эх буюу хүүхдийг хүмүүжүүлж

¹ Гражданское право. III часть. Под ред. А.П.Сергеев, Ю.К.Толстой. М. 1996. 245 дахь талд

² Хүний эрх. Олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхэтгэл. 1998. УБ., 88-р талд.

байгаа бусад хүмүүс хүүхдийн өсөлт бойжилтод шаардагдахуйц амьдралын нөхцлийг өөрийн авьяас чадвар, санхүүгийн боломжийн хэрээр хангах явдлыг үндсэнд нь хариуцана² гэж заасан юм.

Хүүхдийн эрх, эрх чөлөөт эд хөрөнгөгүйгээр төсөөлөх аргагүй юм. Хүүхэд төрсөн цагаасаа, зарим тохиолдолд эхийн хэвлийд байхдаа гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийн өмчлөгч субъект байна. Энэ эрхийг хэн ч хязгаарлахгүй юм. Мөн хүүхэд хуваарьт эд хөрөнгөтэй байж болно. Жишээ нь, бэлэг дурсгал, нэр дээр нь хадгалуулсан мөнгө болон бусад хуваарьт өмч хамаарна. Мөн өв залгамжлал /хууль ба гэрээслэлээр/ -аар хүлээн авсан эд хөрөнгө хуваарьт өмч байна.

Өнөөдөр манай улсад гэр бүл салалт харьцангуй өсөх хандлагатай байгаагийн зэрэгцээ энэ нь эцсийн бүлэгт үр хүүхэд өмчрөх, эд хөрөнгө, сэтгэл санаагаар гачигдах үндсэн шалтгаан болсоор байна. Гэр бүл салалт нь объектив, субъектив шалтгаантай байна. Улс орныг бүхэлд нь хамарсан амьжиргааны доройтол, ажиггүйдэл, гуйлагчлал ихсэж, үндэсний үйлдвэрлэл сэргэхгүй, үнийн өсөлт, архидалт, сахилга, дэг журамгүй байдал, гэмт хэргийн өсөлт гэх мэт нийгэм, эдийн засгийн сөрөг үзэгдлийг тэмчиж, тэсвэрлэхгүйгээр гэр бүл салж байгаа нь объектив шалтгаан болж байна.

Харин гэрлэгчдийн өөрсдийн хувийн зан чанар, зохион байгуулалт, гэр бүл төлөвлөлтийн байдал нь гэр бүл салах субъектив шалтгаан болдог.

Гэр бүл салалтад нөлөөлж байгаа нийгмийн дээрх нөхцөл, сөрөг үзэгдлийг багасгах, сааруулах талаар бодлогын шинжтэй арга хэмжээ авах шаардлагатай байна гэж үзэж байна.

Гэр бүл цуцлах үед хүүхдийн эрх ашгийг хамгаалах асуудал нэн тэргүүнд тавигдах ёстой. Учир нь шүүхийн шийдвэрлэх асуудал нэг нь хүүхдийн асрамж, эрх ашиг болон тэтгэлэг байдаг. Эцэг эх салсан ч салаагүй ч, эцэг эх байх эрх нь хасагдсан ч үр хүүхдээ тэжсэн тэтгэх үүргээ хэвдээ ч чөлөөлөгдөх учиргүй. Энэ нэгдүгээрт, хүүхдийг хэнийх нь талд үлдээх асуудал бөгөөд эд материалын асуудлыг гол болгохоос гадна хүүхдийн сэтгэл санааны байдлыг илүүтэй харгалзан үзэх нь зөв юм.

Тэтгэлгийн хэмжээ, хэлбэр, түүнийг олгох хугацааг одоогийн дагаж мөрдөж байгаа Гэр бүлийн хуулийн 40, 41 дүгээр туйлд заасан журмаар тогтоожээ. Гэрлэгчдийн хэн нэг нь тэтгэлэг нэхэмжилсэн тохиолдолд уг харилцаа үүсэх бөгөөд хэдэн хүүхэдтэй, хэн нь өөр дээрээ авч байгаагаас бас шалгаалдаг байна.

Шүүхэд эд хөрөнгийн маргааныг шийдвэрлэхэд гэрлэгчид болон гэр бүлийн бусад гишүүдэд тэгш хандах зарчмыг баримтлах үүрэгтэй. Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс хүүхдэд ногдох хэсэг, хүүхдийн хуваарьт эд хөрөнгийг олгохоор шийдвэрлэдэг. Энэ практикийг буруу гэх үндэсгүй боловч зөвхөн хүүхдийн эрх ашгийг онцгойлон үзэж дараах нөхцөл байдлыг зайлшгүй анхаарч харах шаардлага амьдралаас урган гардаг.

1. Хүүхэд эрүүл мэндийн хувьд сул дорой, байнгын эмчилгээ, сувилгаа, асаргаа шаардлагатай бол хүүхдэд оногдох эд хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж болох ба энэ талаар хуульд тусгах,

² Мөн эцэгтэй, 60-р талд.

2. Хүүхдийн насны байдлыг харгалзах шаардлагатай. Жишээ нь, 3 ба 15 насны хүүхдийн илж, уух, хэрэглэх зүйл, мөн хүмүүжлийн хувьд ч зөрөө их бөгөөд ногдох эд хөрөнгөд ялгавартай хандах талаар хуульд тусгах,
3. Эд хөрөнгийн гэрээг байгуулахдаа хүүхдэд ногдох дундын болон хуваарьт хөрөнгийн талаар тодорхой зааж өгөх, энэ талаар хуульд тусгайлан заалт оруулах,
4. Гэрлэлт цуцлах үед гэрлэгчид эд хөрөнгийн маргаангүй гэж шүүхэд мэдүүлсэн тохиолдолд шүүх давхар хяналт тавих ёстой. Учир нь гэр бүл салалтын ихэнх хувь нь гэр бүлийн хүчирхийллээс болдог гэдгийг анхаарах ёстой.
5. Дэлхийн жишгт хүүхдийн хуваарьт эд хөрөнгө нь түүний ирээдүйд эзлэх байр суурь, амьдралын хэрэгцээ, баталгаа болдог учир хүүхдийн эрх ашгийг төрөөс хамгаалдаг байна. Энэ ч учраас насанд хүрээгүй хүмүүсийн эрх ашгийг хамгаалдаг, тэдний эд хөрөнгийг бүртгэн, хяналт тавьдаг гуравдагч этгээдийг бий болгож, холбогдох харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Гурав. Гэр бүлийн гишүүд /хүүхэд/-ийн өмчийн эрхийн хамгаалалтыг боловсронгуй болгох асуудалд.

Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн эрхийн хамгаалалтыг боловсронгуй болгоход хамгийн их анхаарал татсан нарийн, адармаатай зүйл бол гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийг хуваарилах явдал юм.

Монгол Улсын Иргэний хуульд хүүхдийг хамтран өмчлөх дундын өмчийн субъект байхаар тусгасан нь нэг талаас шударга, дэвшилтэй, тэдгээрийн эрх ашигт нийцсэн мэт боловч энэ хоёрдмол үр дагаврыг бий болгох шударга бус зохицуулалт ч байж болох талтай.

Учир нь нэг талаас хүүхэд гэр бүлийн эд хөрөнгийг бий болгоход ямар нэгэн хувь нэмэр оруулаагүй, гагцхүү түүнийг эзэмших, ашиглах, үр шимийг нь хүртэж байсан мөртлөө орх тусгаарлах болохоор гэр бүлийн эд хөрөнгөөс өөрт оногдох хэсгээ тодорхойлуулж авч байхад нөгөө хэсэг нь гэр бүлийн хамтын хөдөлмөрт цэг, эхийн адил оролцож, түүнчлэн дангаараа хөдөлмөр, аж ахуй эрхэлж хувь нэмэр оруулан эд хөрөнгөөс оногдох хэсгээ тодорхойлуулж авч байх жишээтэй.

Гэр бүлийн хамтран өмчлэх дундын эд хөрөнгийг гэр бүлийн бүх гишүүд ижил хэмжээгээр эзэмшэж, ашиглаж, үр шимийг нь хүртэж болох боловч захиран зарцуулах эрхийг нь гагцхүү гэрлэгчид эдлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Иймд “Гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө” гэсэн нэр томъёог “Гэрлэгчдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө” гэж өөрчлөх, харин хуваарьт эд хөрөнгийн хувьд гэр бүлийн гишүүдийн хуваарьт эд хөрөнгө гэх нь илүү үндэслэлтэй болов уу? хэмээн Д.Наранчимэг судлаачийн үзэснэлд бүрэн тал өгөх үндэстэй байна.

Өв залгамжлал, гэр бүлийн гишүүдийн хамтран эрхлэн хөтөлдөг аж ахуйн нэгжийн эд хөрөнгө болон хадгаламжид буй эд хөрөнгийн эрх нь гэр

бүлийн гишүүдийн эд хөрөнгийн эрхийн нарийн зохицуулалт шаардлагатай харилцаа юм.

Гэрлэгсдийн дундын эд хөрөнгийг хуваарилах талаар эрдэмтэд чухам хэрхэн үздэгийг товч авч үзье. Оросын хуульч, хууль зүйн ухааны доктор, профессор А.П.Сергеев, Ю.К.Толстой нар үзэхдээ: Хадгаламжид байгаа мөнгийг хуваахад хэнийх нь нэр дээр байна, түүнд нь өгдөг, харин тэрхүү мөнгөөр эд хөрөнгө худалдаж авахаар тэнцүү хуваадаг шударга биш практикийг зохицуулах хэрэгтэй. Мөн үнэт эдлэл, тансаг хэрэгслэл, үнэт чулуу, урлагийн үнэт бүтээлийг дундын хөрөнгө гэж үзэж хуваана.²

ОХУ-ын Гэр бүлийн хуулийн 3 дугаар бүлгийн 39 дүгээр зүйлд "Гэрлэгсэд салж байгаа үед тэдний өр ч мөн эд хөрөнгө хуваасан процентоор хуваагдана". Германы Иргэний хуулийн 1475 дугаар зүйлд "Гэр бүлийн гишүүдийн дундын эд хөрөнгийг хуваахдаа тэргүүн ээлжинд тэдний өрийг төлж барагдуулна."³ гэж заажээ.

Монгол Улсын одоогийн шүүхийн практикт гэрлэлтийг цуцлах, үүнтэй холбоотойгоор гэр бүл бологсдын эд хөрөнгийн маргааныг шийдвэрлэхэд ихээхэн бэрхшээл учирч байна.

Энэ нь:

1. Хоёр талаас анх оруулсан хөрөнгийг тооцох,
2. Гэрлэснээс хойш дундын эд хөрөнгийг хэрхэн яаж бий болгосон, захиран зарцуулсныг тодорхойлоход бэрх байна.
3. Дундын эд хөрөнгийг хуваарилах талаар хуулинд нарийн тодорхой зааж тусгаагүй, ялангуяа өмчийн объект болох оюуны өмч, үнэт цаас, хувьцаа, үнэт эдлэл, урлагийн нэрт бүтээлүүд, аж ахуйн нэгжийн хөрөнгө зэргийг хэрхэн хуваарилах талаар хуульчлах болон албан ёсны тайлбар хийх хэрэгтэй байна.

Гэр бүлийн харилцаанаас үүссэн эд хөрөнгийн маргаантай хэргийг шийдвэрлэх шүүхийн ажиллагаа удаашрах, хуулийн хугацаа алдах, иргэд хохирох явдал байгаагийн сацуу энэ нь гэр бүлийн харилцаанаас үүссэн бусад маргааныг оновчтой, бодитой, түргэн шуурхай шийдвэрлэхэд муугаар нөлөөлж байна. Эдгээрийг даван туулахад "Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн гэрээ"-г амьдрал дээр бодитой байгуулах нь шүүхийн үйл ажиллагаа хөнгөн, шуурхай, иргэд өөрсдөө хохиролгүй байх нөхцөл бүрдээд зогсохгүй өмчлөх эрхийг баталгаатай хангах болно.

ДАМПУУРЛЫН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛД

Ганболдын АМАРЖАРГАЛАН

МУИС-ын ХЗДС-ийн магистрант.

Нэг: Дампуурлын тухай ойлголт, дампуурлын хуулийн зорилго
хэмээх ерөнхий асуудалд

Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжин орсонтой холбогдон зохицуулах шаардлагатай шинэ шинэ харилцаа бий болсоны нэг нь дампуурал, түүний эрх зүйн харилцаа билээ. Аж ахуйн нэгжийн дампуурлын тухай хууль 1991 оны 7 дугаар сарын 1-ны өдөр батлагдан гарсан нь манай орны хувьд зах зээлд шилжин ороход зохих ёсны үүргийг гүйцэтгэсэн нь мэдээж. Улсын Их Хурлаас 1997 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Дампуурлын тухай Монгол Улсын хуулийг дахин шинэчлэн найруулж баталсан нь хууль хэрэгжүүлэхэд тулгарч байсан хүндрэл бэрхшээлийг даван туулах зорилготой холбоотой юм. Гэвч энэхүү хуулийг бүрэн төгс, боловсронгуй хууль болсон гэж үзэх нь учир дутагдалтай байснаас цаашид судлан шинжлэх ажлаа эхэлсэн билээ.

"Дампуурал" гэдэг нь монгол хэлний үг зүйн үүднээс хоосорсон, устсан, ажлаа алдсан гэсэн утгатай¹ юм.

Манай улсад 13 дугаар зууны үед дагаж мөрдөж байсан "Их засаг" хуульд "ямар нэгэн хүн эд таваар дам авч, худалдаа хийж гурван удаа алдлаас цагалсугай" гэж заасан байжээ.

Хууль зүйн үүднээс дампуурал гэдэг үгний хэрхэн тайлбарласныг гадаадын болон монголын судлаач, эрдэмтдийн бүтээлээс товчхон харъя.

"Дампуурал гэдгийг хамгийн энгийнээр өгүүлбэл аж ахуйн нэгж сайн ажиллавал оршин тогтнох, муу ажиллавал устана гэсэн ойлголт ...Аж ахуйн нэгжийг дампуурсанд тооцох эрх зүйн үндэслэл нь төлбөрийн чадваргүй болох явдал юм"², "...Аж ахуйн нэгжийг дампуурсанд тооцох хууль зүйн үндэслэл нь түүний төлбөрийн чадваргүй болох явдал юм, аж ахуйн нэгж өөрийн хөрөнгөтэй түүгээрээ хүлээсэн үүргээ хариуцдаг. Аж ахуйн нэгж нь зах зээлд ганцаар оршин тогтнож байдаггүй, үйл ажиллагаагаа явуулахын тулд өдөр тутам бусадтай харилцаж гэрээ, хэлцэл байгуулдаг, өөрөөр хэлбэл бусдын өмнө үүрэг хүлээдэг. Гэтэл бусдын өмнө хүлээсэн төлбөр тооцооны үүргээ хугацаанд нь биелүүлж чадахгүй бол төлбөрийн чадваргүй гэж үзнэ"³ гэж монголын эрдэмтэн, судлаачид үзсэн байдаг бол "Төлбөрийн чадваргүй гэдэг нь үүрэг хүлээгчийг "туйлын" төлбөрийн чадваргүй хэмээн шүүх

¹ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966, 186 дахь талд

² Т.Мөнхжаргал, Ц.Цолмон. Бизнесийн эрх зүй. УБ., 2000, 66, 68 дахь талд

³ Д.Дүгэржав. Бизнесийн эрх зүй. УБ., 1997, 36 дахь талд

тогтоохыг ойлгоно"⁵ гэсэн байх ба энд "туйлын" гэсэн ойлголт гарч ирж байгаа юм.

Эрх зүйн харилцаанд орж байгаа этгээд бусдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байх тохиолдол олон бий. Үүрэг хүлээгч буюу хариуцагчийн эд хөрөнгө пассив нь активаас давж, үйл ажиллагаагаа хэвийн явуулах хугацаа нь болсон, төлбөрийн үүргийг биелүүлдэх боломжгүй нөхцөлд хариуцагч "туйлын" төлбөрийн чадваргүй байдалд ордог байна.

Төлбөрийн чадваргүй байдал гэдэг нэр томъёотой ихэвчлэн ижил утгаар хэрэглэгддэг "банкротство" хэмээх итали гаралтай үг нь төлбөрийн чадваргүй хариуцагч нь нэхэмжлэгч этгээдэд кохирол учруулсан эрүүгийн шийтгэлт үйлдлийг хийсэн байх гэсэн явцуу, тусгай ач холбогдолтой зарим нэг төлбөрийн чадваргүй байдлыг илэрхийлдэг гэдгийг анхаарах хэрэгтэйг мөн дурдсан нь бий.⁶

"Дампуурал гэдэг нь санхүүгийн үүрэг хариуцлагаа хүлээх боломжгүй болсон хувь хүн, аж ахуйн нэгж өрөө хөнгөлүүлэх, чөлөөлүүлэх талаар шүүхэд хандаж байгаа хууль зүйн үйл ажиллагаа"⁷ гэж үзсэн хэсэг байдаг ч, "Дампуурал нь дампуурлын актын дагуу /1986/ зохицуулагдаж байгаа, дампуурал, төлбөрийн чадваргүй байдалтай холбоотой хууль зүйн процесс. Өрөө төлөх боломжгүй болсон дампуурагч этгээд, түүний эсрэг шүүхэд нэхэмжлэгч этгээдийн харилцаа"⁸ гэж томъёолсон нь бий.

Хууль зүйн үүднээс тайлбарласан тодорхойлолтуудыг харахад, төлбөрийн чадваргүй байдал гэдэг нь дампуурлын гол үзүүлтэл болж байна.

Дампуурлын хууль нь өөрийн эрх хэмжээний хүрээнд харьцангуй бие даасан ба зайлшгүй хэрэгжигдэн батлагдах ёстой хуульд зүй ёсоор ордог нь түүний эрх зүй, нийгэм, эдийн засгийн хувьд зайлшгүй шинж чанарыг харуулж байна.

Хэдийгээр "зайлшгүй" шинжтэй ч нийгэм, эдийн засгийн тухайн тохиолдолд үүрэг гүйцэтгэх түвшин өөр өөр байсан нь ойлгомжтой. Өөрөөр хэлбэл, тухайн үеийн нийгэм, эдийн засаг, эрх зүйн харилцаа, тэдгээрийн орчин хууль хэрэгжих чухал нөхцөл болдог гэж үзэж болох юм. Дампуурлын хууль байнга хэрэгждэг, хэрэгцээтэй байсан уу гэвэл хараахан үгүй. Энд АНУ-ыг жишээ болгоё.

Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 8.4-т "Нэгдсэн Улсын нийт нутаг дэвсгэрт нэгэн адил үйлчлэх дампуурлын хуулийг батлах эрхийг Конгресс эдэлнэ" гэсэн нь бий.⁹

Түүхэн үүднээс авч үзвэл, АНУ-ын Үндсэн хуульд заасан энэ заалт нь 1800 оны үед ховорхон биелэгдэж байсан бөгөөд дампуурлын талаарх Холбооны хууль тогтоомж 1800, 1841 онд мөн 1867 онд батлагдсан нь эдийн засгийн онцгой хямралтай холбогдон гарсан байна. Гэвч нийтийн хямралыг илүүтэйгээр судлан, шинжилсний дүнд улс төрийн даралт шахалтаас хамааран цөөхөн хэдэн жил хэрэгжсэн уг хуулийг хүчингүй болгосон байна.

⁵ Гражданское и торговое право капиталистических государств. Под ред. Е.А.Васильев. М., 1993, стр. 441

⁶ Гражданское и торговое право капиталистических государств. Под ред. Е.А.Васильев. М., 1993, стр. 441

⁷ Understanding business. G. Nicols, Mc Hugh, Mc Hugh. USA., 1987, Part VII. 740

⁸ English for Contract and Company law. Chartrand, Millar&Wiltshire. London., 1997, 156

⁹ АНУ-ын Үндсэн хууль. Орчуулсан Д.Цолмон. 2000. 29 дэх галд

Энэ байдал 1898 онд Конгресс дампуурлын тухай ерөнхий хуулийг баталтал үргэлжилсэн бөгөөд, 1938 онд гол чухал нэмэлт, өөрчлөлтийг оруулсан ба 1978 онд мөн адил нэмэлт өөрчлөлт орж, 1982 онд одоогийн хэвээр үлдсэн байна. Ингэснээр Конгресс дампуурлын хуульд саад болж байсан хүчин зүйлсийг, аж ахуй эрхлэгчдэд харуулсан бөгөөд энэ хуулиараа өр төлөгчийг сэргээн босгох /дахин хөрөнгөжүүлэх/ асуудлыг хурцаар тавьсан байна.¹

1991 онд батлагдсан Аж ахуйн нэгжийн дампуурлын тухай хуультай харьцуулахад одоо мөрдөгдөж байгаа хууль нь дахин хөрөнгөжүүлэх асуудалд илүүтэйгээр анхаарсан нь харатгаж байна.

Эх сурвалж. Дампуурлын эрх зүйн хүрээнд эрх зүйн хэм хэмжээ, гол эх сурвалж нь дампуурлын хууль гэдэгтэй санал нэг байдаг.

Дампуурлын асуудлыг зохицуулсан анхны хууль XVI зуунаас эхтэй. Энэ нь эрүүгийн эрхийн шинжтэй хэм хэмжээг зохицуулсан худалдааны харилцаанд илүү хамааралтай байв. XX зууны эхний хагаст дампуурлын хуулийн зорилт нь эд хөрөнгийн дампуурал, кредиторт хуваарилах бэлэн мөнгөний асуудалд бүхий л анхаарлаа хандуулж байсан бол өнөө үед хууль тогтоомж нь илүүтэйгээр үйлдвэрлэлийн удирдлагын системийг өөрчлөх замаар хариуцагчийн үйлдвэрлэл, үйл ажиллагааг хамгаалахад чиглэсэн цогц хэм хэмжээг агуулсан байна. Энэ зорилгодоо хүрэхийн тулд, орчин үеийн хууль тогтоомж, доорх практикийн чухал асуудлуудыг шийдвэрлэж буй ихэнх оронд хэрэглэж буй энэ бүрийн хууль зүй-техникийн арга барилыг ашигладаг.

Францад 1983 оноос, Германд 1870 оноос, Швейцарьт 1889 оноос, Англид 1914 онд /Bankruptcy act of 1914/, ОХУ-д 1898 оноос дампуурлын хуулийн эхлэл тавигдсан ба хуулийг шинэчлэн боловсруулах ажил өрнөсөн байна.²

Ер нь дампуурал гэдгийг өргөн утгаар нь авч үзвэл, аливаа айл өрх, аж ахуйн нэгж, цаашилбал үзэс гүрэн амьдрал аж ахуйгаа өвсгөө самбаатай эрхлэвэл өсөж өндийж, өнгөтэй өөдтэй явах, хэрэв тэгэж чадахгүй бол зүс царай, хүчин чадал нь буурсаар үгүйрэн хоосрох тухай л ойлголт юм гэж манай эрдэмтэн судлаач Т.Мөнхжаргал өөрийн бүтээлдээ үзсэн байдаг.³

Дампуурлын асуудлыг шийдвэрлэхэд хоёр гол чиглэл хандлага гарч ирж байгаа ба эхнийх нь төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг татан буулгаж дампууруулах, нөгөө нь төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлж, сэргээн босгоход чиглэдэг. 1991 онд батлагдсан Аж ахуйн нэгжийн дампуурлын тухай хууль гол нь төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг татан буулгахыг урьтал болгодог байсан ба одоогийн дагаж мөрдөж байгаа хуулийг батлахын өмнө Хууль зүйн яам /тэр үеийн нэрээр/ Аж ахуйн нэгжийн дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн талаар зарим компаний удирдлага болон шүүгч, эдийн засагчдын дунд социологийн судалгаа явуулж үзэхэд судалгаанд хамрагдагчдын 30 хувь нь хууль амьдралд

¹ Congressional quarterly's. Quite to Congress. Third edition, 1982. Ed. Michael D. Wormser. Part II, 367.

² Гражданское и торговое право капиталистических государств. Под ред. Е.А.Васильева. М., 1993, стр. 442-443

³ Т.Мөнхжаргал Аж ахуйн нэгжийн дампуурал. УБ., 1993 он, 4 дүг талд

нийцэхгүй, нийгмийн өнөөгийн эрэлт хэрэгцээгээс хоцорсон, 40 хувь нь хуулийг өөрчлөх шаардлагатай гэж үзсэн байжээ.⁴

Дампуурлын тухай хуульд зааснаар өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүнтэй үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд нь биелүүлээгүй бол тухайн хуулийн этгээдийг төлбөрийн чадваргүйд тооцдог.⁵ Дампуурсанд тооцох гол үзүүлэлт нь төлбөрийн чадваргүй байдал гэж үздэг учир "өөрийн хөрөнгө" гэсэн ойлголтыг зөв тодорхойлох хэрэгтэй юм.

Дампуурлын тухай хуулиар, өөрийн хөрөнгө гэдгийг хариуцагчийн үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн үнийн дүнгээс бусдад төлөх нийт эзэл, өр төлбөрийн хассаны зөрүү хэмээн ойлгоно гэж тодорхойлсон бол өөрийн хөрөнгийг тооцоходоо, шүүх төлбөрийн чадваргүй болсон аж ахуйн нэгж, байгууллагын хамгийн сүүлд татварын байгууллагад гаргасан тайлам, тэнцэл, түүнийг баталгаажуулсан шинжилгээ, дүгнэлтийг үндэслэн үндсэн ба эргэлтийн нийт хөрөнгийн үнийн дүнгээс бусдад төлөх өр төлбөрийн хэмжээг тогтоосныг хамруулж ойлгоно⁶ гэж тайлбарласан нь бий.

Энэ бүхнээс үүдэн *Дампуурал гэдгийг* эдийн засаг-өмчийн харилцаанд оролцогч аж ахуйн нэгж, байгууллага хууль болон гэрээний дагуу бусдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй, өөрөөр хэлбэл төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд шүүх дампуурлын хэрэг үүсгэн түүнийг татан буулгахыг хэлнэ гэж тодорхойлж болох юм.

Дампуурлын ажиллагааны зорилго нь хариуцагчийн хөрөнгийг цуглуулах болон хуваарилах, бусдын өмнө хүлээсэн үүргийг хангуулах, хариуцагчийг цаашид нэхэмжлэгчдийн өмнө хүлээх үүргээс чөлөөлөхөд оршино.

Төлбөрийн чадваргүй болсон аж ахуйн нэгжийг хуулийн дагуу дампуурсан гэж зарлаж татан буулгах ажиллагааны зорилго нь:

1. Нэхэмжлэгчдийн болон тухайн аж ахуйн нэгжийн хувьцаа эзэмшигчдийн алдагдлыг багасгах,
2. өр төлбөр нь өөрийн эд хөрөнгөөсөө давсан аж ахуйн нэгжийг татан буулгах,
3. хэрэв боломжтой бол тухайн аж ахуйн нэгжийг бизнест нь хэвээр үлдээх,
4. чадваргүй менежерийг өөрчлөх ба чадвартай, шилдэг менежерт компанидаа хэвээр ажиллах боломж олгох,
5. бизнес дэх санхүүгийн сахилга батыг тогтоох болон нягтлан бодох бүртгэлийг зохих ёсоор хөтлүүлэх,
6. төлбөрийн чадваргүй болж дампуурагч аж ахуйн нэгжийг шүүхийн хяналтын дор байлгах хугацааг багасгах,
7. эд хөрөнгийг баталгаат буюу давуу эрхтэй нэхэмжлэгч, баталгаат бус-энгийн нэхэмжлэгчдийн хооронд шударгаар хуваарилах зэрэг юм.

⁴ Арван нэгэн аж ахуйн нэгжийг дампууруулсан. Эсгийг газрын мэдээ сонин, 1997 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн дугаар 205.

⁵ Дампуурлын тухай Монгол улсын хууль, Төрийн мэдээлэл сэтгүүд, 1998 оны №1

⁶ Дампуурлын тухай Монгол улсын хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай Монгол улсын Дэд шүүхийн 2000 оны 1 дүгээр сарын 19-ны өдрийн 01 дүгээр тогтоол.

Өрнөдод /тухайлбал Голландад/ дампуурлын хуулийн сонгодог зорилго нь татан буулгах, донцлох зорилго нь өөрчлөн байгуулах гэж дүгнэж үздэг.¹

Германы эрдэмтэн Манфред Вальц, Хенри Шейфман нарын тодорхойлсноор орчин үеийн дампуурлын хуулийн гол дөрвөн зорилго нь:

1. Төлбөрт гаргуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх
2. Нэхэмжлэгчдийн ашиг сонирхол болон нийгмийн хэрэгцээнд төлбөрийн чадваргүй болсон үйлдвэрийн газрыг татан буулгаснаас үйл ажиллагааг нь хэвээр үргэлжлүүлэх нь ийшээ гэж үзсэн тохиолдолд уг үйлдвэрийн газарт өөрчлөн зохион байгуулагдах боломж олгох
3. Бүх нэхэмжлэгчдэд жигд хандах
4. Дампуурлын дараа шударга өр төлөгчид үйл ажиллагаагаа шинээр эхлэх боломж олгох гэжээ.¹

Дампуурлын өйлголт, тодорхойлолттой салшгүй холбоотой асуудал нь татан буулгахын хэрэгцээгээр сэргэн босгох, дахин хөрөнгөмтгүүлэх асуудал юм.

Хоёр: Гадаадын зарим орнуудын дампуурлын эрх зүйн зохицуулалтын тухайд

Дэлхийн хөгжингүй улс орнуудын эрдэмтэд үр өгөөж бүхий дампуурлын хууль нь дараах элементүүдийг агуулсан байх шаардлагатай гэж үзжээ. Үүнд:

1. Дампуурлын хэрэг үүссэн тохиолдолд нэхэмжлэгчид дор бүрдээ төлбөр гаргуулахтай холбогдсон үйл ажиллагааг бие биеэсээ салангид явуулахгүй байх өр төлөгчийн хөрөнгийг хамгаалалтанд авах болон төлбөрт гаргах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхийн тулд зохион байгуулалттайгаар өөрчлөн байгуулагдах буюу татан буугдах боломжийг олгох.

2. Дампуурлын хэргийг гардан гүйцэтгэгч хүн (хэрэг гүйцэтгэгч) өр төлөгчийн бусадтай байгуулсан гэрээг тухайлбал: 2 талын хэрэгжүүлж эхлээгүй гэрээг цуцлах буюу баталгаажуулах эрх олгох.

3. Нэхэмжлэгчдийн эрх ашгийг хохироосон шударга бич үйлдлийг хэрэг гүйцэтгэгч гаргахгүй байх журам тогтоох дампуурлын хэргт нэхэмжлэгчдийн адил тэгш байдлыг хангах

4. Шударга өр төлөгчийн төлбөрийн чадваргүй болохын өмнөх өр төлбөрийг хүчингүй болгох энэ бодлогыг Франц, Германы шинэ хуульд болон Англи Саксоны эрх зүйн систем бүхий улс орон баримталдаг бөгөөд дампуурлын хэргийн явцад төлөгдөөгүй төлбөрийн үүргээс өр төлөгчийг чөлөөлдөг байна. Энэ нь шударга өр төлөгчийн хувьд дахин бизнес эхлэх боломжийг олгож байгаа юм.

5. Олон улсын хэмжээний дампуурлын асуудлыг шийдвэрлэх шударга бөгөөд тэнцвэртэй журам тогтоох. Энэ тухай дэлхийн банкнаас судалгаа явуулж зөвлөмж гаргасан. Үүнд: Швейцарь, Германд сүүлийн үед авч хэрэгжүүлж байгаа туршилага, АНУ болон нэгдсэн вант улсын хууль тогтоомж болон Европын зөвлөл Европын холбооны баримталж байгаа бодлогод үндэслэн хэлэхэд дампуурлын талаар баримталж байгаа бодлогоо хамгаалах,

¹ "Основные проблемы и моменты которые должны содержаться в законе о банкротстве и не которые альтернативные возможности их решения" Р.Кюппер Х.Шинггер М.П. ван Сент Труйден /Брекен. Амстердам/ 05.05.1997/

¹ Дампуурлын хуулийн харьцуулсан судалгаа. Манфред Вальц, Хенри Шейфман. УБ., 1997.

тухайн улсад өрсөх гадаадын үйлдвэр аж ахуйн газрын дампуурлын асуудлыг шийдвэрлэхэд гадаад улсын дампуурлыг хүлээн зөвшөөрөх систем байх нь зүйтэй болов уу гэжээ. Энэ нь олон улсын хэмжээний дампуурлын хэрэгт өөрийн улсын нэхэмжлэгчдийн эрх ашгийг хамгаалах боломжийг тухайн улсад олгох санааг агуулсан байна.¹

ХБНГУ-д дампуурлын эрх зүйн субъект нь үйл ажиллагааны зүйл ба аж ахуйн статусаас хамааралгүйгээр "өрөө төлөх чадваргүй болсон" /ХБНГУ-ын Дампуурлын дүрмийн 102 дугаар зүйл/ ямар ч этгээд /иргэн эсвэл хуулийн этгээд ялгаагүй аль аль нь/ байхаар заасан.

Үүнтэй нжил зохицуулалтыг мөн Францын эрх зүйд баримтладаг ба №85-98 хуулиар дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа аль ч худалдаачин, гар урчууд мөн Иргэний эрх зүйн ямар ч хуулийн этгээдэд нэгэн адил хамаарахаар тогтоосон байна.

Голланд улсад дампуурлын ажиллагааны хүрээнд хамрагдах субъектуудад: хуулийн этгээд, хувь хүн, үйлдвэрлэгч, хэрэглэгч гэсэн этгээдүүд байж болохыг дурьдсан байна.²

Энд ОХУ-ын дампуурлын хуулийг авч үзье. Энэ хуульд "Иргэний дампуурал" гэсэн бие даасан 9-р бүлэг бий. Энэ бүлэг нь үйлдвэрийн эзэд, фермерийн аж ахуй эрхлэгчид болон иргэний дампуурлын харилцааг зохицуулдаг. Энэ хуулийн 150 дугаар зүйлд зааснаар: Иргэний дампуурлын онцлог шөвөг нь харилцагч талын өмнө хүлээсэн төлбөр тооцооны үүргээ биелүүлэх гүйцэтгэх үүргийн төлбөрийн хэмжээ түүний өмчөөс хэтэрсэн байхыг ойлгодог.

Түүхэн хөгжлийн явцад дампуурлын хэргийг үүсгэх тухай таван төрлийн шаардлагыг бий болгон тогтоосон байна. Үүнд,

- Нэхэмжлэгчийн шаардлагаар,
- Харнуцагчийн хүсэлтээр,
- Бусад этгээдийн шаардлагаар,
- Шүүхийн шийдвэрээр,
- Прокурорын шаардлагаар.³

ОХУ-ын Дампуурлын хуулийн 151 дүгээр зүйл: Иргэний дампуурлын хэрэг үүсгэх нэхэмжлэлийг өр төлөгч өөрөө буюу нэхэмжлэгч, эзэлийн байгууллага тэрчлэн прокурор гаргах эрхтэй байдаг. Эрүүл мэндийн хувьд хохирол амссан нэхэмжлэгчийн хувьд нөхөн төлбөр төлүүлэхээр нэхэмжлэл гаргах эрхтэй гэж заасан байдаг.

Төлбөрийн чадваргүй болсонтой холбоотойгоор процессийн ажиллагааг үүсгэх тухай нэхэмжлэл буюу хүсэлтийг нэхэмжлэгч гаргасан эсэхээс үл хамааран энэ төрлийн хэргийг хэргийн болон шүүхийн харьяаллын дагуу холбогдох шүүхэд гаргадаг. Энэ асуудлыг шийдвэрлэх шүүхийг дампуурлын хэргийг үүсгэх хэргийн харьяаллаар нь гурван бүлэгт нэгтгэж болно: /

¹ Дампуурлын хуулийн харьцуулсан судалгаа. Манфред Вац, Хенри Шеффам УБ, 1997

² "Основные проблемы и моменты которых должны содержаться в законе о банкротстве и не которые альтернативные возможности их решения" Р.Кюпер Х.Шинттер М.П. ван Синт Труйден /Бремех Амстердам/ 05.05.1997/

³ Гражданское и торговое право капиталистических государств. Под ред. Е.А.Васильев. М., 1993, стр. 446.

иргэний бүх шүүх /ХБНГУ/, 2/ худалдааны болон зарим иргэний шүүх /Франц/, 3/ дампуурлын хэрэг үүсгэж хянан шийдвэрлэх тусгай шүүх /Англи/. Эдгээр улсуудад төлбөрийг чадваргүй болсонтой холбоотойгоор хэрэг үүсгэхдээ тогтоогдсон хэлбэрийн дагуу бичгэн нэхэмжлэлийг гаргахаар заасан байдаг.

Герман Улсын дампуурлын дүрмийн 102 дугаар зүйлд зааснаар дампуурлын хэрэг үүсгэх үндэслэл нь хариуцагч өрөө төлөх чадваргүй болсон, төлөх чадваргүй болсон гэдгээ хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хэрэг үүсгэхээр заасан байдаг. Энэ заалт нь Франц улсад ч мөн баримтлагддаг. Энэ тохиолдолд хариуцагч төлбөрөө төлж чадахгүй болсон тухай фактыг нэхэмжлэгч нотлох ёстой болдог. Английн эрх зүйн системийн дагуу доод тал нь 750 фунт стерлингийн үнийн дүнтэй нэг буюу хэд хэдэн үүргийг нэн даруй буюу тодорхой тогтоосон хугацаанд биелүүлж чадаагүй тохиолдолд дампуурлын хэрэг үүсгэдэг байна.

Зарим системд нэхэмжлэгчдийн хамтарсан хүсэлтийг шаарддаг АНУ-д дор хаяж гураван нэхэмжлэгч ба нэхэмжлэгчийн нийт дүнгийн доод хэмжээ 5000 \$ ам.дол байхаар хуульчилсан байдаг. Эдгээр нь хуурамч дампуурлаас сэргийлэх хэрэв хуульд зааснаас бага тооны нэхэмжлэгчид мөн бага хэмжээний асуудал гаргасан тохиолдолд иргэний журмаар шийдвэрлэж болох талтай. Нидерландын болон Германы системээр өр төлөгчийн хөрөнгийг хөдөлгөөнд байлгаж бизнесээ үргэлжлүүлэх замаар нэхэмжлэгчдийн эрх ашигт нийцүүлэх гол техник хэмээн өөрчлөн байгуулах төлөвлөгөөг үздэг ба нэхэмжлэгч /АНУ/ буюу итгэмжлэгдсэн гүйцэтгэгч /Герман 1994/ өөрчлөн байгуулах ажиллагаа явуулах хүсэлтийг тавьж болохоор заасан байдаг.

/ Үргэлжлэл дараагийн дугаарт /

СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭГЧДИЙН УЛС ТӨР, ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИ СЭТГЭЛГЭЭНИЙ ХӨГЖЛӨӨС

Ажурлал лекц

Дагдангийн ОТГОНТУЯА

Хууль зүйн ухааны магистр

Шарль Луи Секонда Барон де Ла-Бред буюу де Монтескье (1689-1755):
Монтескье нь 1689 оны 1 сарын 18 ид язгууртны гэр бүлд төржээ.

Тэрээр Францын соён гэгээрүүлэгчдийн нэрт төлөөлөгч, улс төрийн сэтгэгч, социологч, хуульч хүн.

Шарль Луи Секонда өөрийн Монтескье өвгөө 1716 онд авга ахаасаа эдлэн газар мөн тэр үед шүүхийн байгууллагын үүрэгтэй байсан Бордогийн парламентын ерөнхийлөгчийн албан тушаалын хамт өвлөн авсан ба авга ахыгаа нас барсны дараа хууль цаазыг өвлөгдөн ирсэн албан тушаалын улмаас бие даан судалсан байна. Тухайн үед хууль цаазыг судлах нь нэлээд хэцүү байсан хэдий ч тэрбээр өөрийн боловсруулсан системийн дагуу маш сайн судалсан бөгөөд магадгүй тэр үед л улс төр, эрх зүйн сургаалын түүхэнд нэрийг нь мөнхөлсөн "Хуулийн амин сүнс" зохиолын санаа нь төрсөн байх.

Түүний анхны томоохон бүтээл болох "Персийн захидал" нь 1721 онд зохиогчийн нэргүйгээр хэвлэгдсэн. Хэдийгээр уг ном хориглогдсон ч маш олон хувиар тарж алдарших болсон. Үүний шалтгаан нь Монтескье дээрх бүтээлдээ 18-р зууны Францын феодалуудын царцанги ёс журам, хямрал зөрчилдөөн, үнэн дүр зургийг нээн илрүүлж гаргаж чадсанд оршино. Үүний дараа тэрээр Парисад очин улс төрийн шинжлэх ухааныг судлах зорилго өмнөө тавьж "Антресоль" клубын үйл ажиллагаанд идэвхийлэн оролцох болжээ. Энд тэрээр Английн улс төрийн зүтгэлтэн Боллингброктой танилцсан ба түүний Английн улс төр, эрх зүйн байгуулалтын талаархи яриа нь Английг сонирхох сонирхлыг нь ихээхэн хөдөлгөсөн байна.

1725 онд Монтескье Парисад бүрэн суурьшиж Бордогийн академи болон парламентын ерөнхийлөгчийн албан тушаалуудаасаа татгалзан Парисын академийн гишүүн болсон боловч түүнд бүх юм уйтгартай санагдаж хураалдаандаа ч ховор үзэгдэх болсон. Ингээд ард түмний соёл, зан заншил, ашиг сонирхлыг өөрийн нүдээр үзэх, ирээдүйн "Хуулийн амин сүнсний тухай" номлолоо боловсруулах зорилгоор аялал хийж нэлээдгүй хугацааг Англид өнгөрүүлсэн байна.

1731 оны 4 дүгээр сард Францад эргэн ирж үр бүтээлтэй ажилласан ба чухам энэ үед л тэрээр "Ромчуудын мандалт болон мөхөлтийн шалтгааныг тунгаан бодохуй (1734)", "Хуулийн амин сүнс(1748)", "Хуулийн амин сүнсний хамгаалалт (1750)" зэрэг томоохон бүтээлүүдээ туурвисан байна. Түүний бүтээлүүд нь өнгөндөө Францыг бус Перс, Туркийг шүүмжилсэн мэт байсан ч

ухаалаг уншигчид нь үнэндээ Францын хэмжээгүй эрхт төр ба эрх зүйг шүүмжилж буйг нь ойлгож байв.

Монтескьегийн улс төр, эрх зүйн үзэл сургаал нь тухайн үед хуримтлагдсан байсан маш их баримт материалыг анх системчлэсний нэрлэл байв. Түүний сургаалд улс төр, эрх зүйн баримтууд нь зүй тогтол бүхий харилцан холбоонд орших хэсгүүдээс бүрдсэн нэг бүхэл мэт тусгагдсан байдаг.

Тэрээр шашны үзэл ба улс төр, хууль цаазны шинжлэх ухааны заагийг маш тод гарган, эрс шийдвэртэйгээр "Миний улс төрийн сургаалаас шашны үзэл бүү хай" хэмээн зарлаж байв.

Улс төр, эрх зүйн ертөнцийг шинжлэх ухааны тусламжтайгаар танин мэдэх гэсэн эрмэлзлэл нь түүний арга зүйн үндсэн шинж юм. Түүний улс төр, эрх зүйн сургаалын үндсэн сэдэв нь улс төрийн эрх чөлөө бөгөөд энэхүү эрх чөлөөг хангах нөхцөл нь шударга хууль ба төрийн зохих байгууллага юм гэж үзэж байв.

Монтескье "Хуулийн амин сүнс" -дээ нийгмийн гэрээний талаар шууд яриагүй бөгөөд энэ нь амьд ахуйдаа "Үзэл бодол", "Үүргийн тухай номлол" зэрэг бүтээлүүдээ хэвлүүлэхэд засаглагчдын хийгээд сүм хийдийнхний дургуйцлийг өдөөхгүй байх зорилготой байсан бөгөөд энэ нь соён гэгээрлийн онолын зуунд нийтлэг зүйл байжээ. Хэдийгээр тэрээр гэрээний онолыг хүлээн зөвшөөрсөн ч үүний хамт төрийг ямар нэгэн дур зоргын зөвшилцөл бус харин нийгмийн хөгжлийн бодит хүчин зүйлээр тодорхойлогдох зайлшгүй түүхэн үзэгдэл хэмээн үзжээ. Мөн тэрээр төр, нийгэм хоёрыг ялгаатай гэж үзэгчдийн нэг байв. Түүний үзсэнээр төр нь нийгэмтэй зэрэг үүсдэггүй, харин нийгмийн хөгжлийн түүхэн үе шатанд, тодруулбал, хөгжлийн явцад хүмүүсийн дунд эсрэг тэсрэг байдал бий болж, баялаг хуваах явцад өөр хоорондоо тэмцэн хэсэг бүлэг хүмүүс нийтийн ашиг сонирхлыг өөрийн жигшүүрт зорилгод ашиглах болсон тэр үед бий болдог. Ийм нөхцөлд хүмүүс дайн тэмцэл, үл ойлголцох байдлыг намжаах, үгүй болгох зорилгоор хэлэлцээ хийж зөвшилцөхөөс өөр аргагүйд хүрч, хүсэл зориг, хүчээ нэгтгэн нийтийн хүч болох төрийг бий болгодог байна. Ийм ч учраас төрийн гол зорилго бол хүмүүсийн хооронд бий болсон сөргөлдөөнийг арилгах, нийтийн хүчийг ашиглан маргааныг хууль эрх зүйн тусламжтайгаар зохицуулах, нийтийн журам зорчигчдад хуулийн дагуу албадлага хэрэглэх явдал юм.

Тэрээр "нийгмийн гэрээний онолын дагуу төр гэдэг бол ард түмэн ба төр гэх хоёр тал өөрсдийн эрх, үүргийг харилцан тогтоож буй хэлцэл" гэж үздэгийг эсрэгүүцэж удирдлагад эрх олгон, ард түмэнд үүрэг оногдуулж байсан үзэлтнүүдийг бүр хүчтэй шүүмжилж байсан. Түүнийхээр төрийн засаглал нь гагцхүү нийтийн ашиг сонирхолд үндэслэгдэх бөгөөд төр, ард олны зохистой зөвшилцөл гэдэг нь тэдгээрийн хоорондох харилцааг зохицуулах суурь хуулиудыг батлах явдал ажээ.

Монтескье төрийн хэлбэрийн асуудалд нэлээд анхаарал хандуулж байсан бөгөөд туйлын хэлбэрийн санааг хэтэрхий магтан дуулах сэтгэгчдийг шүүмжлэн, төрийн удирдлагын хэлбэр нь тухайн ард түмний хувьд тэдний нийтлэг хүсэл зоригтой нэгдсэн тохиолдолд төрөлх шинжтэй болно хэмээгээд Бүгд Найрамдах, Хаант, Давгаар ноёрхох гэсэн хэлбэрүүдийг авч үзсэн.

Бүгд Найрамдах засаглалын үед төрийн дээд эрх мэдэл бүхлээрээ ард түмний гарт (демокрит буюу ардчилсан) тодруулбал, ард түмэн нэг талаас засаглагч, нөгөө талаас албат болж байдаг, эсвэл тэдний нэг хэсгийн гарт (аристократ буюу язгууртны) тодруулбал, өөрсдийн мэдлэг, баялаг болон өөр бусад давуу талдаа тулгуурлан ард түмнээс ялгарч дээд эрх мэдлийг авсан бүлэг хүмүүст оршино.

Хаант засаг (монархи)-ийн үед төрийн дээд эрх мэдэл нэг этгээдэд оногдох ба хууль нь түүний удирдлагаар язгууртнууд, санваартнуудын оролцоотойгоор тогтоогдоно. Ийнхүү хатуу тогтоогдсон хуулиар ард түмнийг захирна.

Дангаар ноёрхох (диспот) засаглалын үед ямар нэгэн хууль дүрмээс гадуур дан ганц нэг хүний хүсэл зоригоор бүх зүйл тодорхойлогдоно. Диспот төрийн удирдлагын гол зарчим нь “айлгах” явдал хэдий ч хүний өөрийн орчин нь энэ байдлын (төрийн) эсрэг босоход хүргэдэг учир диспот төрийн үед хувьсгал зүй ёсны байдаг.

Ийнхүү Монтескье төрийн хэлбэрийг авч үзээд тухайн хэлбэрт тохирсон “Үндсэн хууль” байх ёстойг тэмдэглэсэн. Ардчиллын үед гол хууль нь эрх бүхний сонгогдогсдолд хяналт тавих, санал авах эрхээр тодорхойлогддог, язгууртны төрийн үед хууль гаргах, хэрэгжүүлэх нь ард түмний нэг хэсгийн эрхээр тодорхойлогддог, хаант засаглалын үед засаглалыг бүрдүүлэгч субъектын хоорондын эрхээр өөрөөр хэлбэл, захирагч-хаан, албат-харьяатын эрхээр тодорхойлогддог бол дангаар ноёрхох засаглалын үед хууль үндсэндээ байхгүй байх ба түүний байр суурийг шашин, зан заншил тэрчлэн дарангуйлагчийн дур зоргоор байдал эзэдэг юм гэж үзжээ.

Монтескье хуулийн зүй тогтол, өөрөөр хэлбэл, “хуулийн өнүн санаа”-г нлэрхийлж байсан ба хууль, эрх зүйн тухай ерөнхий ойлголтонд байгал ертөнцөд биет байдлаар үйлчлэх хувирангүй хуулиуд, мөн хүний ухамсарар үйлчлэдэг өөрчлөгдөн хувьсагч тогтвортой бус хуулийг хамааруулан үзэж байв. Хүн, байгалийн бусад биеттэй адилын хувьд хувирангүй хууль болох жам ёсны хуульд захирагддаг ч өөрийн ухамсар санаагаар үйлдлээ удирддаг, сэтгэдэг ухаант амьтан болохынхоо хувьд энэ хуулийг зорчдог учир хүний хууль болох тогтвортой бус хууль гарах шаардлага бий болдог.

Хүнийг захирагч жам ёсны хууль нь түүнийхээр хүний өөрийнх нь шинэ байдлаас урган гардаг бөгөөд энэ хуулийн хүрээнд хүний амар тайван амьдрах, хүнс тэжээлээ цуглуулах, эв найрамдалд тэмүүлэх, бусадтай хамт нийгэмд амьдрах, харилцан тусалцах зэрэг хүн төрөлхтний төрөлхийн хэрэгцээ, шаардлагыг хамруулсан. Хүмүүс нийгэмд амьдарч нийгэмшсэний дараа өөрсдийн сул талаа ухамсарлахаа больж ингэснээр тэдний дунд оршин байсан тэгш байдал ажмаар алдагдаж, ард түмэн ба эсрэг талын хооронд дайн эхэлдэг. Чухам энэ үеэс тэдний хооронд хуулийн шаардлага бий болж улс хоорондын харилцааг тодорхойлогч хууль (олон улсын эрх зүй), засаглал удирдлагын харилцааг тодорхойлогч хууль (улс төрийн), жирийн иргэдийн хоорондын харилцааг зохицуулагч хууль (иргэний эрх зүй)-нуд гардаг гэжээ.

Тэрээр аль ч улсын хувьд өөрийн хуулиндаа нийгэмийн хөгжлийн олон хүчин зүйлс тухайлбал, байгал, цаг уур, газар зүйн байршил, орчин, удирдлагын зарчим, хорс шороо, нутаг дэвсгэр, ард түмний амьдралын ахуй хэлбэр, баялаг, зан заншил гэх мэтийг тусгахын чухлыг тэмдэглэсэн ба түүний

энэхүү хандлага нь тухайн цаг үедээ хууль цаазны шинжлэх ухаанд гарсан дэвшил байв.

